

АГУУЛГА

МУИС-ийн эрхэм зорилго, Үнэт зүйлс	4
МУИС-ийн танилцуулга	5
I БҮЛЭГ. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР	
Бакалаврын сургалтын хөтөлбөр	6
Магистрын сургалтын хөтөлбөр	22
Докторын сургалтын хөтөлбөр	24
II БҮЛЭГ. ХӨТӨЛБӨР СОНГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	
Систем дээр хөтөлбөрт тандалт өгөх болон сонголт хийх процесс хэрхэн явагддаг вэ?.....	28
Мэргэжил сонгох зөвлөмж	33
III БҮЛЭГ. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦ	
Хичээлд бүртгүүлэх, баталгаажуулах.....	36
Суралцагчийн мэдлэг, чадварын үнэлгээ.....	37
Суралцагч чөлөө авах	40
Суралцагч үргэлжлүүлэн суралцах	41
Сургуулиас чөлөөлөгдөх.....	41
Төгсөгчдөд тавих шаардлага, хүсэлт гаргах.....	41
Сургалтын үйлчилгээний төлбөр	44
Сургуулиас олгох албан бичиг баримт, лавлагаа.....	45
Оюутны хүсэлт, санал гомдлыг хүлээн авах, барагдуулах.....	46
IV БҮЛЭГ. СИСИ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	
Нүүр хуудас.....	52
Хөтөлбөр.....	54
Хөтөлбөр сонголт	56
Хичээлд бүртгүүлэлт	61
Дүн	79
V БҮЛЭГ. СУРАЛЦАГЧИЙГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ	
Академик үйлчилгээ	80
Оюутны тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг	80
Гадаад, дотоодын хувь, хүн сангийн нэрэмжит тэтгэлэг.....	82
МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг	84
Боловсролын зээлийн сангийн үйлчилгээ	86
Оюутан солилцооны хөтөлбөр.....	87
Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад үзүүлэх үйлчилгээ.....	94
Хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээ	94
Оюутны дотуур байрны үйлчилгээ	94
Эрүүл мэндийн үйлчилгээ	96
Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ	96
Багш, оюутны гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр.....	97
Гадаад оюутныг дэмжих үйлчилгээ.....	98
Соёл урлаг, спортын үйлчилгээ.....	99
Оюутны байгууллага, клубуудад зөвлөн туслах үйлчилгээ.....	100
Цахим үйлчилгээ	104
VI БҮЛЭГ. ХОЛБОО БАРИХ	
Утасны жагсаалт.....	106



БАТЛАВ.

СУРГАЛТ, ОЮУТАН ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ Д.БАДМААНЯМБУУ

СУРГАЛТЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ
НАМРЫН УЛИРАЛ

Сар	Долоо	1117143
	УХ	000072918
	хоног	Өдөр

Өдөр	Үйл ажиллагаа
------	---------------

VIII сар	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня
						1	2
	3	4	5	6	7	8	9
	10	11	12	13	14	15	16
	17	18	19	20	21	22	23
	0	24	25	26	27	28	29
						30	

8 сарын 10-21
8 сарын 17-21
8 сарын 24-28
8 сарын 25-31
8 сарын 25-31

Бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэгчдийн бүртгэл
Шилжилтийн шалгалт явагдана
Шилжилтийн шалгалтад тэнцсэн хүсэлт гаргагчийг бүртгэх
Бакалаврын /өдөр, орой/ хөтөлбөрийн хичээл сонголт, баталгаажуулалт
Шинэ элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалт

IX сар	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня
	I	31	1	2	3	4	5
	II	7	8	9	10	11	12
	III	14	15	16	17	18	19
	IV	21	22	23	24	25	26
	V	28	29	30			

9 сарын 01
9 сарын 1 - 10 сарын 01
9 сарын 14 - 18
9 сарын 21 - 23
9 сарын 22 - 28
9 сарын 22 - 28
9 сарын 29

Хичээлийн шинэ жилийн нээлт
Өмнөх улирлын дүнгийн гомдол, маргаан шийдвэрлэх
Магистр, докторын хөтөлбөрт элсэгчдийн шалгалт явагдана /намар/
Бакалаврын эцнээ хөтөлбөрт элсэгчдийн шалгалт явагдана
Бакалаврын эцнээ, магистрант, докторантын хичээл сонголт, баталгаажуулалт
Бакалаврын эцнээ, магистр, докторын хөтөлбөрт элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалт
Бакалаврын эцнээ, магистрант, докторантын намрын улирлын хичээл эхэлнэ

X сар	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня
	V			1	2	3	4
	VI	5	6	7	8	9	10
	VII	12	13	14	15	16	17
	VIII/ЯШ	19	20	21	22	23	24
	IX	26	27	28	29	30	31

10 сард
10 сарын 06 - 11 сарын 09
10 сарын 20 - 26

Хос, хавсарга мэргэжлийн хөтөлбөрт суралцах хүсэлт гаргах
Бүх түвшний суралцагчид төгсөх хүсэлт гаргах
Явцын шалгалт

XI сар	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня
				1	2	3	4
	X	2	3	4	5	6	7
	XI	9	10	11	12	13	14
	XII	16	17	18	19	20	21
	XIII	23	24	25	26	27	28
							29

11 сард
11 сарын 02 - 06
11 сарын 09 - 13
11 сарын 09 - 13
11 сарын 24 - 12 сарын 07
11 сарын 10 - 1 сарын 10
11 сарын 24 - 30

Хос, хавсарга хөтөлбөрөөр суралцуулах тушаал гаргах, бүртгэх
Мэргэжлийн хөтөлбөр сурталчлах өдөрлөг I
Багш дараагийн улиралд заах хичээлийн санал өгөх
Мэргэжлийн хөтөлбөр сонгох мандалт I
Хаврын улиралд судлах хичээлийн мандалт, санал өгөх
Магистр, докторын хөтөлбөрт хаврын улиралд элсэгчдийн бүртгэл
Бакалаврын урьдчилсан хамгаалалт /өөвл/

XII сар	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня
	XIV	30	1	2	3	4	5
	XV	7	8	9	10	11	12
	XVI	14	15	16	17	18	19
	УШ	21	22	23	24	25	26
	УШ	27	29	30	31		

12 сарын 01-07
12 сарын 08 - 21
12 сарын 08 - 14
12 сарын 15 - 1 сарын 15
12 сарын 22-27
12 сарын 22 - 1 сарын 04

Магистрантын урьдчилсан хамгаалалт
Тэнхим хичээл орох багшийг эцэслэн тодорхойлж, баталгаажуулна
Бакалаврын жинхэнэ хамгаалалт
Шилжин суралцах хүсэлт гаргах
Магистрантын жинхэнэ хамгаалалт
Улирлын шалгалт

I сар	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня
	УШ				1	2	3
	НД	4	5	6	7	8	9
	УА	11	12	13	14	15	16
	УА	18	19	20	21	22	23
	УА/0	25	26	27	28	29	30
							31

1 сарын 01
1 сарын 05 - 11
1 сарын 18 - 22
1 сарын 13 - 15
1 сарын 12 - 2 сарын 01
1 сарын 11 - 18

Шинэ жил
Нэгтгэн дүгнэх
Бакалаврын мэргэжлийн хөтөлбөр сонголт
Төгсөлтийн баяр
Улирлын амралт
Магистр, докторын хөтөлбөрт элсэгчдийн шалгалт явагдана /хавар/

1 сарын 26 - 2 сарын 01
1 сарын 26 - 2 сарын 01
1 сарын 18 - 22
1 сарын 26 - 2 сарын 01

Бакалавр, магистрант, докторантын хичээл сонголт, баталгаажуулалт
Магистр, докторын хөтөлбөрт элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалт
Шилжилтийн шалгалт явагдана
Шилжилтийн шалгалтад тэнцсэн хүсэлт гаргагчийг бүртгэх

- ЯШ *Явцын шалгалт*
- УШ *Улирлын шалгалт*
- НД *Нэгтгэн дүгнэх*
- УА *Улирлын амралт*

БАТЛАВ:  СУРГАЛТ, ОЮУТАН ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ Д.БАДМААНЫМБУУ

СУРГАЛТЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ
ХАВРЫН УЛИРАЛ

Сар	Долоо хоног	1117144 (сэд)	Өдөр
-----	-------------	---------------	------

Өдөр	Үйл ажиллагаа
------	---------------

II сар	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	
	I	1	2	3	4	5	6	7
	II	8	9	10	11	12	13	14
	III	15	16	17	18	19	20	21
IV	22	23	24	25	26	27	28	

2 сарын 02 *Хаврын улирлын хичээл эхэлнэ*
 2 сарын 02 - 3 сарын 01 *Өмнөх улирлын дүнгийн гомдол, маргаан шийдвэрлэх*
2 сарын 12 - 14 *Цагаан сар*

III сар	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня	
	V	1	2	3	4	5	6	7
	VI	8	9	10	11	12	13	14
	VII	15	16	17	18	19	20	21
	VIII/ЯШ	22	23	24	25	26	27	28
IX	29	30	31					

3 сар *Хос, хавсарга мэргэжлийн хөтөлбөрт суралцах хүсэлт гаргах*
 3 сарын 09 - 4 сарын 05 *Бүх түвшний суралцагчид төгсөх хүсэлт гаргах*
 3 сарын 23 - 29 *Явцын шалгалт*
 3 сарын 30 - 4 сарын 03 *Мэргэжлийн хөтөлбөр сурталчлах өдөрлөг II*

IV сар	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня
	IX			1	2	3	4
	X	5	6	7	8	9	10
	XI	12	13	14	15	16	17
	XII	19	20	21	22	23	24
XIII	26	27	28	29	30		

4 сар *Хос, хавсарга мэргэжлээр суралцуулах тушаал гаргах*
 4 сарын 05 - 09 *Мэргэжлийн хөтөлбөр сонгох тандалт II*
 4 сарын 13 - 19 *Багш дараагийн улиралд заах хичээлийн санал өгөх*
 4 сарын 27 - 5 сарын 10 *Намрын улиралд судлах хичээлийн тандалт, санал*
 4 сарын 27 - 5 сарын 03 *Бакалаврын урьдчилсан хамгаалалт*

V сар	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня
	XIII					1	2
	XIV	3	4	5	6	7	8
	XV	10	11	12	13	14	15
	XVI	17	18	19	20	21	22
УШ	24	25	26	27	28	29	

5 сарын 04 - 10 *Магистрантын урьдчилсан хамгаалалт*
 5 сарын 11 - 24 *Тэнхим хичээл орох багшийг эцэслэн тодорхойлж, баталгаажуулна*
 5 сарын 11 - 17 *Бакалаврын жинхэнэ хамгаалалт*
 5 сарын 25 - 31 *Магистрантын жинхэнэ хамгаалалт*
 5 сарын 25 - 6 сарын 07 *Улирлын шалгалт*

VI сар	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня
	УШ	31	1	2	3	4	5
	НД	7	8	9	10	11	12
	ЗА	14	15	16	17	18	19
	ЗА	21	22	23	24	25	26
ЗА	28	29	30				

6 сарын 08 - 14 *Нэгтгэн дүгнэх*
6 сарын 14 - 18 *Бакалаврын мэргэжлийн хөтөлбөр сонголт*
 6 сарын 15 - 8 сарын 24 *Зуны амралт*
6 сарын 18 - 21 *Төгсөлтийн баяр*

VII сар	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя	Ня
				1	2	3	4
	ЗА	5	6	7	8	9	10
	ЗА	12	13	14	15	16	17
	ЗА	19	20	21	22	23	24
ЗА	26	27	28	29	30	31	

6 сарын 20 - 8 сарын 20 *Бакалаврын орой хөтөлбөрийн элсэлтийн бүртгэл*
 7 сарын 01 - 8 сарын 15 *Шилжин суралцах хүсэлт гаргах*
 7 сарын 10 - 9 сарын 10 *Магистр, докторын хөтөлбөрт элсэгчдийн бүртгэл*
 7 сарын 20 - 9 сарын 20 *Бакалаврын эчнээ хөтөлбөрийн элсэлтийн бүртгэл*

ЯШ Явцын шалгалт
 УШ Улирлын шалгалт
 НД Нэгтгэн дүгнэх
 ЗА Зуны амралт

АЛСЫН ХАРАА

МУИС-ийн алсын хараа нь “дэлхийн түвшний их сургууль” болоход оршино. Үүний дүнд 2024 онд МУИС нь чөлөөт мэдлэг буюу “либерал арт” уламжлалд суурилсан, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх байр суурьтай судалгааны их сургууль болж, улмаар Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтаж орно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

МУИС нь шинжлэх ухааны үндсэн салбаруудыг хамарсан чөлөөт мэдлэг буюу “либерал арт” уламжлалд суурилсан хөтөлбөртэй, байгалийн ухаан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь асуудлаар сургалт, судалгааны ажлыг тогтвортой эрхэлж, эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилготой академик буюу эрдмийн байгууллага болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

МУИС-ийн хамт олны гишүүн бүр дараах үнэт зүйлсийг эрхэмлэн, дагаж мөрдөнө. Үүнд:

- Академик эрх чөлөө
- Хөгжлийн жишиг
- Ёс зүй
- Манлайлал
- Хүндлэл/Урамшуулал

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

Бид зорьж буй алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараах стратегийн чиглэлийг тэргүүлэх ач холбогдолтой хэмээн тодорхойлж байна. Үүнд:

- Судалгааны хамрах хүрээг өргөжүүлэх, түвшинг дэлхийн жишигт нийцүүлнэ.
- Сургах ба суралцах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэнэ.
- Нийгэмд мэдлэгээр манлайлж, нийгмийн хөгжлийн түүчээ байна.
- Байгууллагын бие даасан байдлыг хангаж, менежментийн олон улсын шилдэг арга барилыг нэвтрүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангана.

МУИС-ийн ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Сургууль (МУИС) нь улс орны хөгжлийн тулгуур, мэдлэгийн цөм болсон үндэсний тэргүүлэх судалгааны их сургууль байж, нийгэм, эдийн засгийн эрэлт шаардлагад нийцсэн олон улсын түвшний судалгаа, сургалт явуулж, шинжлэх ухааны мэдлэг эзэмшсэн, дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх үүргээ нэр төртэй биелүүлж буй дээд боловсролын ууган байгууллага, Монгол Улсын эрдэм оюуны төв юм.

МУИС нь бүрэлдэхүүн 6 сургууль, орон нутаг дахь харьяаллын 2 сургууль, Байгаль-Эх лицей ахлах сургууль, экологийн боловсролын төв, сургалт, судалгааны хүрээлэн, төвүүдтэй, бакалавр, магистр, докторын түвшний суралцагч, эрдэмтэн багш, ажилтантай, Үндэсний хэмжээнд “Шилдэг багш”, “Шилдэг оюутан”, “Шилдэг хөтөлбөр”, “Шилдэг судалгаа, эрдэм шинжилгээ”, “Шилдэг удирдлага, менежмент”, “Шилдэг орчин нөхцөл”, “Шилдэг төгсөгчид” гэсэн тодотгол нэр хүндээ улам бэхжүүлж алсын хараа, зорилгоо нэр төртэй биелүүлэн ажиллаж байна.

Манай сургууль түүхэн хөгжлийнхөө явцад одоогийн МУБИС, ХААИС, АШУУИС, ШУТИС, ХИС, Ховд их сургууль зэрэг 6 их сургуулийг өрх тусгаарлан шинээр байгуулж, Монгол Улсад дээд боловсролын системийг бий болгон төлөвшүүлэхэд асар их хувь нэмэр оруулсан билээ.

МУИС-ийг 2016-2024 онд хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөндөө “МУИС-ийн алсын хараа нь дэлхийн түвшний их сургууль болоход оршино. Үүний дүнд 2024 онд МУИС нь чөлөөт мэдлэг буюу либерал арт уламжлалд суурилсан, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх байр суурьтай судалгааны их сургууль болж улмаар Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтаж орно” хэмээн тодорхойлсон.

Бид олон улсад өрсөлдөх чадвараа сайжруулахын тулд эрдмийн эрх чөлөөт дээдэлж, хамгийн шилдэг профессор багш, оюутан суралцагчидтай байж, сургалт судалгааны хамгийн таатай орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байна.

БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ

ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

Байгалийн ухааны салбар

Нийгмийн ухааны салбар

Хүмүүнлэгийн ухааны салбар

ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ

БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ

АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛЬ

ЭРДЭНЭТ СУРГУУЛЬ

ЗАВХАН СУРГУУЛЬ

I БҮЛЭГ. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөр нь ерөнхий танилцуулга, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын арга зүй, суралцах орчин, элсэгчдэд тавих шаардлага, багшид тавих шаардлага, төгсөгчдийн эзэмших үр чадвар, суралцагчийн үнэлгээ, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт, удирдлагын мэдээллийн систем, харилцаа хамтын ажиллагаа болон бусад нэмэлт мэдээллээс бүрдэнэ.

Хөтөлбөрийг бакалаврын түвшинд өдөр, орой, эчнээ хэлбэрээр үндсэн, хос, хавсарга мэргэжил олгох, магистрын түвшинд өдөр, эчнээ хэлбэрээр судалгааны болон мэргэжлийн, докторын түвшинд өдөр, эчнээ, экстернат хэлбэрээр боловсруулна.

МУИС-д зөвхөн хөтөлбөрийн ерөнхий хороогоор батлагдсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1. БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Дээд боловсролын Бакалаврын зэрэг олгох хөтөлбөр нь “ерөнхий суурь” (General education), “мэргэжлийн суурь” (Core), “мэргэжлийн” (Major) болон “чөлөөт сонголт” (Free elective) гэсэн бүтэцтэй байна.

Хөтөлбөрийн бүрдэл хэсгийн нэр	Тайлбар
Ерөнхий суурь (General education)-МУИС-ийн шаардлага	Дээд боловсролын үндэс буюу ойлгомжтой ярих, бичих; тоон болон тоон бус мэдээллийг боловсруулах; олон ургалч үзэл баримтлалын учир шалтгааныг таньж мэдэх; бусад мэргэжлийн хүмүүстэй үр дүнтэй хамтарч ажиллах, харилцан суралцах мэдлэг, үр чадварыг эзэмшүүлэх зорилготой заавал болон сонгон суралцах хичээлүүд байна.
Мэргэжлийн суурь (Core)- Бүрэлдэхүүн сургуулийн шаардлага	Хөтөлбөрийн суурь мэдлэг, мэргэжлийн чиглэлийн анхдагч үр чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой заавал болон сонгон судлах хичээлүүд байна.
Мэргэжлийн (Major)	Оюутны суралцах үндсэн мэргэжлийн тодорхой мэдлэг, чадвар, дадлыг олгох, заавал болон сонгон суралцах хичээлүүд байна.
Чөлөөт сонголт (Free elective)	Оюутан хавсарга болон хос мэргэжил эзэмших, магистрын хөтөлбөрийн зарим хичээлүүдийг судлах, их сургуулийн хэмжээнд хүссэн хичээлээ сонгон үзэхэд зориулагдсан хичээлүүд байна. Тухайн хичээл нь залгамж холбоотой бол өмнөх хичээлийг заавал үзсэн байна.

Бакалаврын хөтөлбөрийн багц цагийг дараах байдлаар хуваарилна.

	Бүрэлдэхүүн сургуулиуд			Тайлбар
	ШУС, Орхон сургууль /хүмүүнлэгийн салбарын хөтөлбөр/	ХШУИС, БС, ОУХНУС, Орхон сургууль / бизнесийн хөтөлбөр/, Завхан сургууль	ХЗС	
	Цуглуулах багц цаг			
Ерөнхий суурь	37	31	31	121 багц цаг (ХЗС-ийн хувьд 151 бц) бол бакалаврын зэрэг авахад шаардагдах хамгийн доод хэмжээ бөгөөд хөтөлбөрийн шаардлагаас үүдэн нэмэгдэж болно.
Мэргэжлийн суурь	9	21	37	
Мэргэжлийн	60	54	68	
Чөлөөт сонголт	15	15	15	
НИЙТ	121	121	151	
Хавсарга мэргэжил	30	30	30	Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдээс бүрдэнэ.
Хос мэргэжил	69	75	105	Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдээс бүрдэнэ. Хоёр хөтөлбөрт ижил хичээл байвал аль алинд нь багц цагийг дүйцүүлэн тооцно.
Орой, эчнээ	69	75	105	Бакалаврын түвшинд эзэмшсэн мэргэжил болон суралцах мэргэжлээсээ хамааран суралцах багц цагийн хэмжээ өөрчлөгдөж болно.

Бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн хөтөлбөр

№	МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль	Сонгох боломжтой бакалаврын үндсэн мэргэжлийн хөтөлбөр
1	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ (ШУС)	Математик, Багш, математикийн, Багш, байгалийн ухааны боловсрол (Физик, Газарзүй, Биологи, Хими), Физик, Геофизик, Хими, Биологи, Биохими, Биологийн нөөц судлал, Экологи, Газарзүй, Геологи, Байгаль орчныг зайнаас тандан судлал, Хот ба бүс нутгийн төлөвлөлт, Биотехнологи, Газар зохион байгуулалт, Аялал жуулчлал, Цаг уур, Ус судлал, Уур амьсгал судлал
1.1.	Байгалийн ухааны салбар	
1.2.	Нийгмийн ухааны салбар	Эдийн засаг, Сэтгүүл зүй, Улс төр судлал, Сэтгэл судлал, Социологи, Нийгмийн ажил, Антропологи, Археологи



1.3.	Хүмүүнлэгийн ухааны салбар	Философи, Шашин судлал, Хэл, уран зохиол (Монгол, Англи, Хятад, Япон), Хэл шинжлэл (Монгол хэл, Орос, Герман, Хятад, Япон), Гадаад хэлний орчуулга (Англи, Орос, Солонгос, Хятад, Герман, Франц, Япон, Араб, Түрк), Утга зохиол судлал, Урлаг судлал, Гадаад хэл, орон судлал (Араб, Испани, Итали, Их Британи, Америк, Польш, Солонгос, Түрк, Франц, Хятад, Чех, Япон), Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол, Багш, нийгмийн ухааны боловсрол, Багш, гадаад хэлний боловсрол (Англи, Орос), Түүх
2	БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ	Нягтлан бодох бүртгэл, Санхүү, Банк, Даатгал, Менежмент, Маркетинг, Худалдаа, Аялал жуулчлалын менежмент
3	ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ	Олон улсын харилцаа, Төрийн удирдлага
4	ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ	Эрх зүй
5	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ	Статистик, Хэрэглээний математик, Хэрэглээний хими, Химийн инженерчлэл, Компьютерийн ухаан, Компьютерийн сүлжээ, Мэдээллийн технологи, Программ хангамж, Мэдээллийн систем, Холбооны технологи, Сэргээгдэх эрчим хүч, Электрон системийн автоматжуулалт, Цөмийн инженерчлэл, Материал судлал, Био-инженерчлэл, Нано шинжлэх ухаан, инженерчлэл, Ойн үйлдвэрлэлийн техник, технологи, Хүрээлэн буй орчны инженерчлэл
6	ЭРДЭНЭТ СУРГУУЛЬ	Багш, гадаад хэлний боловсрол, Гадаад хэлний орчуулга, Нягтлан бодох бүртгэл, Санхүү, Банк, Даатгал, Менежмент, Маркетинг
7	ЗАВХАН СУРГУУЛЬ	Нягтлан бодох бүртгэл, Банк, Маркетинг, Менежмент, Худалдаа, Санхүү



**Бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн сургалтын төлөвлөгөө
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ**

№	Бүрэлдэхүүн сургууль, тэнхим	Хөтөлбөрийн нэр	А. Ерөнхий суурь хичээл	Б. Мэргэжлийн суурь	В. Мэргэжлийн хичээл		Г. Чөлөөт сонголт	Хөтөлбөрийн шаардлага
				Б1 сонгон судлах хичээл	В1. Заавал судлах хичээл	В2 сонгон судлах хичээл		
1	ШУС, БУС, математикийн тэнхим	Математик	37	9	45	15	15	Хөтөлбөр тус бүрийн шаардлагатай сургалтын төлөвлөгөөнөөс танилцана уу
		Багш, математикийн боловсрол			54	6		
2	ШУС, БУС, физикийн тэнхим	Физик			45	15		
		Багш, байгалийн ухааны боловсрол (Физик)			54	6		
3	ШУС, БУС, химийн тэнхим	Хими						
		Багш, байгалийн ухааны боловсрол (Хими)						
4	ШУС, БУС, биологийн тэнхим	Биологи			45	15		
		Багш, байгалийн ухааны боловсрол (Биологи)			54	6		
		Биохими			45	15		
		Биологийн нөөцийн менежмент						
		Экологи						
		Биотехнологи						
5	ШУС, БУС, газар зүйн тэнхим	Газар зүй			45	15		
		Багш, байгалийн ухааны боловсрол (Газарзүй)						
		Байгаль орчныг зайнаас тандан судлал						
		Хот ба бүс нутаг төлөвлөлт						
		Газар зохион байгуулалт /төлөвлөлт кадастр/						
		Аялал жуулчлал						
6	ШУС, БУС, геологи, геофизикийн тэнхим	Геологи	45	9				
		Геофизик						
7	ШУС, БУС	Цаг уур судлал	45	9				
		Уур амьсгал судлал						
		Ус судлал						



8	ШУС, НУС, эдийн засгийн тэнхим	Эдийн засаг	37	9	27	33	15	Хөтөлбөр тус бүрийн шаардлагатай сургалтын төлөвлөгөөнөөс танилцана уу
9	ШУС, НУС, улс төр судлалын тэнхим	Улс төр судлал			48	12		
10	ШУС, НУС, боловсрол, сэтгэл судлалын тэнхим	Сэтгэл судлал			45	15		
11	ШУС, НУС, антропологи, археологийн тэнхим	Антропологи			45	15		
		Археологи						
12	ШУС, НУС, социологи, нийгмийн ажлын тэнхим	Социологи			45	15		
		Нийгмийн ажил						
13	ШУС, НУС, сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим	Сэтгүүл зүй			48	12		
14	ШУС, ХУС, түүхийн тэнхим	Түүх Багш, нийгмийн ухааны боловсрол						
15	ШУС, ХУС, монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим	Хэл, уран зохиол (Монгол хэл)			54	6		
		Багш, монгол хэл, уран зохиол						
		Хэл шинжлэл (Монгол)						
16	ШУС, ХУС, утга зохиол, урлаг судлалын тэнхим	Утга зохиол судлал			45	15		
		Урлаг судлал						
17	ШУС, ХУС, философи, шашин судлалын тэнхим	Философи			48	12		
		Шашин судлал						
18	ШУС, ХУС, их британи, америк судлалын тэнхим	Багш, гадаад хэлний боловсрол (Англи)			54	6		
		Гадаад хэл, орон судлал (Их британи)						
		Гадаад хэл, орон судлал (Америк)	55	5				
		Хэл, уран зохиол (Англи)						
		Гадаад хэлний орчуулга (Англи)	56	4				

19	ШУС, ХУС, европ судлалын тэнхим	Гадаад хэл, орон судлал (Франц)	37	9	54	6	15	Хөтөлбөр тус бүрийн шаардлагатай сургалтын төлөвлөгөөнөөс танилцана үү
		Гадаад хэл, орон судлал (Итали)						
		Гадаад хэл, орон судлал (Польш)						
		Гадаад хэл, орон судлал (Чех)						
		Гадаад хэл, орон судлал (Испани)						
		Хэл шинжлэл (Орос)						
		Гадаад хэлний орчуулга (Орос, Герман, Франц)						
		Хэл шинжлэл (Герман)						
		Багш, гадаад хэлний боловсрол (Орос)						
20	ШУС, ХУС, ази судлалын тэнхим	Гадаад хэл, орон судлал (Хятад)	37	9	54	6	15	
		Хэл шинжлэл (Хятад)						
		Хэл, уран зохиол (Хятад)						
		Гадаад хэлний орчуулга (Хятад)						
		Гадаад хэл, орон судлал (Солонгос)						
		Гадаад хэлний орчуулга (Солонгос)						
		Гадаад хэл, орон судлал (Түрк)						
		Гадаад хэлний орчуулга (Түрк)						
		Гадаад хэл, орон судлал (Араб)						
		Гадаад хэлний орчуулга (Араб)						
		Гадаад хэл, орон судлал (Япон)						
		Хэл шинжлэл (Япон)						
		Хэл, уран зохиол (Япон)						
Япон хэлний орчуулга								



ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ

№	Бүрэлдэхүүн сургууль, тэнхим	Хөтөлбөрийн нэр	А. Ерөнхий суурь хичээл	Б. Мэргэжлийн суурь		В. Мэргэжлийн хичээл		Г. Чөлөөт сонголт	Хөтөлбөрийн шаардлага					
				Б1. Заавал судлах хичээл	Б2 Сонгон судлах хичээл	В1. Заавал судлах хичээл	В2 Сонгон судлах хичээл							
1	ХШУИС, Хэрэглээний математикийн тэнхим	Хэрэглээний математик	31	6	15	45	9	15	Хөтөлбөр тус бүрийн шаардлагатай сургалтын төлөвлөгөөнөөс танилцана уу					
		Статистик				36	18							
2	ХШУИС, Электроник, холбооны инженерчлэлийн тэнхим	Компьютерийн сүлжээ				31	6			15	48	6	15	Хөтөлбөр тус бүрийн шаардлагатай сургалтын төлөвлөгөөнөөс танилцана уу
		Сүлжээний технологи												
		Сэргээгдэх эрчим хүч												
3	ХШУИС, Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим	Электроник				31	6			15	48	6	15	Хөтөлбөр тус бүрийн шаардлагатай сургалтын төлөвлөгөөнөөс танилцана уу
		Мэдээллийн технологи												
		Програм хангамж												
4	ХШУИС, Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим	Мэдээллийн систем				31	6			15	48	6	15	Хөтөлбөр тус бүрийн шаардлагатай сургалтын төлөвлөгөөнөөс танилцана уу
		Компьютерийн ухаан												
		Хүрээлэн буй орчин судлал												
5	ХШУИС, Хими, биологийн инженерчлэлийн тэнхим	Ойн аж ахуй	31	6	15	48	6	15	Хөтөлбөр тус бүрийн шаардлагатай сургалтын төлөвлөгөөнөөс танилцана уу					
		Хүрээлэн буй орчны инженерчлэл												
		Цөмийн инженерчлэл	31/12*	6	15	48	6	15						
		Материал судлал												
		Химийн инженерчлэл												
31	Хэрэглээний хими	31	6	15	48	6	15	Хөтөлбөр тус бүрийн шаардлагатай сургалтын төлөвлөгөөнөөс танилцана уу						
									Нано шинжлэх ухаан, инженерчлэл					
		Био-инженерчлэл												



БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

№	Бүрэлдэхүүн сургууль, тэнхим	Хөтөлбөрийн нэр	А. Ерөнхий суурь хичээл	Б. Мэргэжлийн суурь		В. Мэргэжлийн хичээл		Г. Чөлөөт сонголт	Хөтөлбөрийн шаардлага
				Б1. Заавал судлах хичээл	Б2 Сонгон судлах хичээл	В1. Заавал судлах хичээл	В2 Сонгон судлах хичээл		
1	Нягтлан бодох бүртгэлийн тэнхим	Нягтлан бодох бүртгэл	31	15	6	42	12	15	Хөтөлбөр тус бүрийн шаардлагатай сургалтын төлөвлөгөөнөөс танилцана уу
2	Санхүүгийн тэнхим	Санхүү				42	12		
		Банк							
		Даатгал							
3	Менежментийн тэнхим	Менежмент			39	15			
		Аялал жуулчлалын менежмент							
4	Маркетинг, худалдааны тэнхим	Маркетинг			39	15			
		Худалдаа							

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ

№	Бүрэлдэхүүн сургууль, тэнхим	Хөтөлбөрийн нэр	А. Ерөнхий суурь хичээл	Б. Мэргэжлийн суурь		В. Мэргэжлийн хичээл		Г. Чөлөөт сонголт	Хөтөлбөрийн шаардлага
				Б1. Заавал судлах хичээл	Б2 Сонгон судлах хичээл	В1. Заавал судлах хичээл	В2 Сонгон судлах хичээл		
1	ОУХНУС, Олон улсын харилцааны тэнхим	Олон улсын харилцаа	31	15	9	42	9	15	Хөтөлбөр тус бүрийн шаардлагатай сургалтын төлөвлөгөөнөөс танилцана уу
2	ОУХНУС, Нийтийн удирдлагын тэнхим	Төрийн удирдлага	31	15	6	36	18	15	

ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

№	Бүрэлдэхүүн сургууль, тэнхим	Хөтөлбөрийн нэр	А. Ерөнхий суурь хичээл	Б. Мэргэжлийн суурь		В. Мэргэжлийн хичээл			Г. Чөлөөт сонголт
				Б1. Заавал судлах хичээл	Б2 Сонгон судлах хичээл	В1. Заавал судлах хичээл	В2 Сонгон судлах хичээл	В3 Сонгон судлах хичээл	
1	Хууль зүйн сургууль,	Эрх зүй	31	30	6	57	57	12	15

Сургалтын төлөвлөгөөний дагуу 151-ээс доошгүй багц цаг цуглуулна

Ерөнхий суурь хичээл

МУИС-ийн бакалаврын сургалтад тавигдах суурь шаардлагыг хангахад чиглэсэн нийгэм, хүмүүнлэг, байгалийн шинжлэх ухааны суурь мэдлэг, эзэмшсэн ур чадвараа амьдралд бүтээлчээр бодитой ашиглах дадал олгох үндсэн зорилго бүхий дээд боловсролын суурь судлагдахуун юм.

Ерөнхий суурь хичээлийг судалснаар оюутан либерал арт боловсрол буюу нийгмийн идэвхтэй гишүүн байхад зайлшгүй шаардлагатай шүүмжлэлт, бүтээлч, логик сэтгэлгээнд суралцаж, санаачлан хийдэг, рациональ шинжлэх ухаанч шийдвэр гаргадаг, хөрвөдөг, нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны суурь мэдлэг, ур чадвар эзэмшсэн, их сургуулийн боловсролтой, чадварлаг, ёс зүйтэй иргэн болж хөгжинө.

МУИС-ийн нэгдүгээр түвшний оюутан эхний 2 улирал Ерөнхий суурь багцын хичээлүүдээс хамгийн багадаа 24 багц буюу 8 хичээл судлаж **“Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам”-д** заасны дагуу мэргэжлийн хөтөлбөр сонгоно.

Ерөнхий суурь хичээлийн жагсаалт

2017 оны 12-р сарын 20-ний өдрийн

МУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцэж батлагдсан хувилбар

АГУУЛГЫН ЧИГЛЭЛ, БАГЦ ЦАГ	№	Санал болгож буй хичээл	Харьяа сургууль	Харьяалах тэнхим	Тайлбар
I. Байгалийн ухаан 6 багц цаг (ШУС, ХШУИС тус бүр 6 багц цаг, БС, ХЗС, ОУХНУС тус бүр 3 багц цаг)	I. Байгалийн ухаан				
	1	Хүрэх үр дүн: Байгалийн юмс үзэгдлийн мөн чанар, шинжлэх ухааны үзэл баримтлалыг ойлгож тайлбарлах, мэдээлэлд шинжлэх ухаанчаар хандах, таамаглал дэвшүүлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадвартай болно.			
	1	Математик 1а	ШУС, БУС	Математикийн тэнхим	Нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухааны чиглэл гэх мэт
	2	Математик 1б	ШУС, БУС	Математикийн тэнхим	Байгалийн ухаан, инженер, бизнесийн ангийн оюутнуудад зориулсан
	3	Математик 1в	ШУС, БУС	Математикийн тэнхим	Байгалийн ухаан, математикийн чиглэлээр сурах сонирхолтой оюутнуудад зориулсан
	4	Юмс үзэгдлийн физик үндэс	ШУС, БУС	Физикийн тэнхим	Нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухааны чиглэл гэх мэт
	5	Физик	ШУС, БУС	Физикийн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл
	6	Физикийн үндэс	ШУС, БУС	Физикийн тэнхим	Физикийн мэргэжлээр суралцах оюутнуудад зориулсан
	7	Нийгмийн газарзүй	ШУС, БУС	Газарзүйн тэнхим	Хүмүүнлэг, нийгэм, хууль, эдийн засгийн чиглэлээр сурах сонирхолтой оюутнуудад
8	Дэлхий судлалын үндэс	ШУС, БУС	Газарзүйн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл	

<p>I. Байгалийн ухаан 6 багц цаг</p> <p>(ШУС, ХШУИС тус бүр 6 багц цаг, БС, ХЗС, ОУХНУС тус бүр 3 багц цаг)</p>	9	9	Молекул ба эсийн биологи	ШУС, БУС	Биологийн тэнхим	Хүмүүнлэг, нийгэм, хууль, эдийн засгийн чиглэлээр сурах сонирхолтой оюутнуудад
	10	10	Организм ба эволюцийн биологи	ШУС, БУС	Биологийн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл
	11	11	Экологи ба тогтвортой байдал	ШУС, БУС	Биологийн тэнхим	Нийтлэг
	12	12	Хими ба амьдрал	ШУС, БУС	Химийн тэнхим	Хүмүүнлэг, нийгэм, хууль, эдийн засгийн чиглэлээр сурах сонирхолтой оюутнуудад
	13	13	Байгалийг танин мэдэх химийн үндэс	ШУС, БУС	Химийн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл
	14	14	Астрономийн үндэс	ШУС, БУС	Геологи, газар зүйн тэнхим	Байгалийн ухаан, инженерийн чиглэл
<p>II. Хүмүүнлэгийн ухаан 6 багц цаг</p> <p>(ХШУИС-3 багц цаг, ШУС, БС, ХЗС, ОУХНУС тус бүр 6 багц цаг)</p>	II. Хүмүүнлэгийн ухаан					
	15	Хүрэх үр дүн: Сэтгэлгээний түүхийг танин мэдэх, философи, уран зохиолын бичвэрт дүн шинжилгээ хийх чадвар, урлаг гоо зүйн сэтгэлгээг хөгжүүлэх, ёс зүйн үнэлэмжийг төлөвшүүлэх зорилготой				
		1	Хүний хөгжил, харилцааны ёс зүй	ОУХНУС, НУС	Эдийн засгийн тэнхим	Нийтлэг
	16	2	Эрх зүйн үндэс	ХЗС	Төр, захиргааны эрх зүй, Эрх зүй судлал, Эрүүгийн эрх зүй, Олон улсын эрх зүйн тэнхим	Нийтлэг
	17	3	Хэл шинжлэлийн үндэс	ШУС, ХУС	Монгол хэл хэлшинжлэлийн тэнхим Европ судлалын тэнхим	Нийтлэг
	18	4	Соёл судлал	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим Ази судлалын тэнхим	Нийтлэг
	19	5	Дэлхийн соёл иргэншил	ШУС, ХУС	Түүхийн тэнхим\ Ази судлалын тэнхим Европ судлалын тэнхим	Нийтлэг\ Дэлхийн түүх хичээлтэй уялдуулж сонголттой санал болгоно.
	20	6	Монгол бичиг 1	ШУС, ХУС	Монгол хэл хэлшинжлэлийн тэнхим	Нийтлэг



II. Хүмүүнлэгийн ухаан 6 багц цаг (ХШУИС-3 багц цаг, ШУС, БС, ХЗС, ОУХНУС тус бүр 6 багц цаг)	21	7	Урлагийн боловсрол	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг
	22	8	Уран зохиолын боловсрол	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг
	23	9	Шашин судлалын үндэс	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг
	24	10	Философийн үндэс	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг
	25	11	Монгол соёл иргэншил судлал	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг
	26	12	Хүний эрх	ХЗС	ХЗС	Нийтлэг
	27	13	Олон улсын харилцааны үндэс ба даяаршил	ОУХНУС	-	Нийтлэг
	28	14	Хэл ба танихуй	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
III. Нийгмийн ухаан 6 багц цаг (ШУС- 6 багц цаг, ХШУИС, БС, ХЗС, ОУХНУС тус бүр 3 багц цаг)	III. Нийгмийн ухаан					
	29	Хүрэх үр дүн: Нийгэм эдийн засаг, засаглал, ослын олон талт байдал, хүн хоорондын харилцаа, зан үйлийг танин мэдэх, бүтээлч сэтгэлгээ, шинжлэх ухаанч хандлагад суралцах болно.				
		1	Макроэкономиксийн үндэс	ШУС, НУС	Эдийн засгийн тэнхим	Нийтлэг
		2	Микроэкономиксийн үндэс	ШУС, НУС	Эдийн засгийн тэнхим	Нийтлэг
		3	Экономиксийн үндэс	ШУС, НУС	Эдийн засгийн тэнхим	Нийтлэг
		4	Антропологийн үндэс	ШУС, НУС	Антропологи, археологийн тэнхим	Нийтлэг
		5	Археологийн үндэс	ШУС, НУС	Антропологи, археологийн тэнхим	Нийтлэг
		6	Социологи	ШУС, НУС	Социологи, нийгмийн ажлын тэнхим	Нийтлэг
		7	Нийгмийн ажил	ШУС, НУС	Социологи, нийгмийн ажлын тэнхим	Нийтлэг
		8	Улс төр судлалын үндэс	ШУС, НУС	Улс төр судлалын тэнхим	Нийтлэг
		9	Сэтгэл судлалын үндэс	ШУС, НУС	Боловсрол, сэтгэл судлалын тэнхим	Нийтлэг
		10	Ардчиллын боловсрол	ШУС, НУС	Улс төр судлалын тэнхим	Нийтлэг
	11	Бизнес ба нийгэм	БС	Менежментийн тэнхим	Нийтлэг	

III. Нийгмийн ухаан 6 багц цаг (ШУС- 6 багц цаг, ХШУИС, БС, ХЗС, ОУХНУС тус бүр 3 багц цаг)	40	12	Жендер судлал	ШУС, НУС	Антропологи, археологийн тэнхим	Нийтлэг
	41	13	Хувийн менежмент ба манлайлал	БС	Менежментийн тэнхим	Нийтлэг
IV. Иргэний боловсрол 3 багц цаг (ШУС, ХШУИС, БС, ХЗС, ОУХНУС тус бүр 3 багц цаг) БШУЯ-наас гаргасан “хичээлийн жагсаалт”-ын дагуу Монголын түүх-3 кр нь заавал судлах хичээл юм.	IV. Иргэний боловсрол					
	42	Хүрэх үр дүн: Монголын түүх соёл, улс төр, эдийн засаг, эрх зүй, хүний үндсэн эрх, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, багаар ажиллах үр чадварыг хөгжүүлэх болно.				
		1	Монголын түүх (Ерөнхий)	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг
	43	2	Монголчууд дэлхийн түүхэнд	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг
	44	3	Монголын түүх: Нүүдэллэхүй ёсон	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг.
	45	4	Монголын түүх: Чингисийн эрин ба Евро-Ази	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг
	46	5	Монгол ба улаан хувьсгал	ШУС, ХУС	Түүхийн тэнхим	Нийтлэг
V. Судалгаа шинжилгээний арга зүй 3 багц цаг (ШУС, ХШУИС, БС, ХЗС, ОУХНУС тус бүр 3 багц цаг)	V. Судалгаа шинжилгээний арга зүй					
	47	Хүрэх үр дүн: Тоон болон чанарын мэдээ баримтанд шинжилгээ хийж үнэлэх, логик сэтгэлгээ хөгжүүлэх, шалтгаан үр чадварын холбоог тогтоох, процессийг загварчлах, асуудал тодорхойлж сурна.				
		1	Компьютер тооцооллын үндэс	ХШУИС	Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим	Нийтлэг
	48	2	Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үндэс	ХШУИС	Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим	Нийтлэг
	49	3	Мэдээллийн технологийн үндэс	ХШУИС	Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим	Нийтлэг
	50	4	Магадлал, статистикийн удиртгал	ШУС, БУС ХШУИС	Математикийн тэнхим Хэрэглээний математикийн тэнхим	Нийтлэг
	51	5	Статистикийн үндэс	ШУС, БУС, НУС	Математикийн тэнхим Эдийн засгийн тэнхим	Нийтлэг
	52	6	Элементар логик ба математик хандлага	ШУС, БУС	Математикийн тэнхим	Нийтлэг
	53	7	Логикийн удиртгал	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг



V. Судалгаа шинжилгээний арга зүй 3 багц цаг (ШУС, ХШУИС, БС, ХЭС, ОУХНУС тус бүр 3 багц цаг)	54	8	Хувь хүний санхүү	БС	Санхүүгийн тэнхим	Нийтлэг
	55	9	Нийгмийн судалгааны аргууд	ШУС, НУС	Социологи, нийгмийн ажлын тэнхим/Эдийн засгийн тэнхим	Нийтлэг
VI. Яриа бичгийн ур чадвар 3 багц цаг (ШУС, ХШУИС, БС, ХЭС, ОУХНУС тус бүр 3 багц цаг)	VI. Яриа бичгийн ур чадвар					
	Хүрэх үр дүн: Яриа бичгийн өөрийгөө илэрхийлэх ур чадвар, эрдэм шинжилгээний бичгийн ур чадвар эзэмших болно.					
	56	1	Монгол хэл бичиг, найруулга зүй	ШУС, ХУС	Монгол хэл хэлшинжлэлийн тэнхим	Нийтлэг
	57	2	Хэл ярианы соёл	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	58	3	Илтгэх урлаг	ШУС, ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Нийтлэг
59	4	Академик бичих ур чадвар (монгол, англи хэлээр)	ШУС, НУС	Социологи, нийгмийн ажлын тэнхим, Их британи, Америк судлалын тэнхим	Нийтлэг	
VII. Англи хэл, бусад хэл 6 цаг (ШУС, ХШУИС, БС, ХЭС, ОУХНУС тус бүр 6 багц цаг)	VII. Англи хэл, бусад хэл					
	Хүрэх үр дүн: Англи хэл /бусад хэл/-ээр мэргэжлийн эх сурвалжийг ашиглаж чаддаг байх, англи хэлний ярих, сонсох, унших, бичих ур чадварын дундын дээд түвшинг (upper intermediate) хангаж өгнө.					
	60	1	Ерөнхий англи хэл: Унших дадал (анхан)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	61	2	Англи хэл: Харилцах дадал (анхан)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	62	3	Англи хэл: Бичих дадал (анхан)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	63	4	Академик англи хэл: Унших дадал-1 (Анхан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	64	5	Академик англи хэл: Бичих дадал-1 (Анхан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	65	6	Академик англи хэл: Харилцах дадал-1 (Анхан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	66	7	Академик англи хэл: Бичих дадал-2 (дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	67	8	Академик англи хэл: Унших дадал-2 (дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг

<p>VII. Англи хэл, бусад хэл 6 цаг цаг</p> <p>(ШУС, ХШУИС, БС, ХЭС, ОУХНУС тус бүр 6 багц цаг)</p>	68	9	Академик англи хэл: Харилцах дадал-2 (дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	69	10	Академик англи хэл: Унших дадал-3 (ахисан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	70	11	Академик англи хэл: Харилцах дадал-3 (ахисан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	71	12	Академик англи хэл: Бичих дадал-3 (ахисан дунд)	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	72	13	Академик англи хэл - 4	ШУС, ХУС	Гадаад хэлний төв	Нийтлэг
	73	14	Ахисан түвшний бичих дадал	ШУС, ХУС	Их Британи Америк судлалын тэнхим	Нийтлэг
	74	15	Ахисан түвшний яриа	ШУС, ХУС	Их Британи Америк судлалын тэнхим	Нийтлэг
	75	16	Солонгос хэл 1	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг
	76	17	Солонгос хэл 2	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг
	77	18	Япон хэл 1	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг
	78	19	Япон хэл 2	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг
	79	20	Хятад хэл 1	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг
	80	21	Хятад хэл 2	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг
	81	22	Франц хэл 1	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	82	23	Франц хэл 2	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	83	24	Орос хэл 1	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	84	25	Орос хэл 2	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	85	26	Герман хэл 1	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	86	27	Герман хэл 2	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	87	28	Араб хэл	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг
88	29	Түрк хэл	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	
89	30	Түрк хэл 2	ШУС, ХУС	Ази судлалын тэнхим	Нийтлэг	



<p>VII. Англи хэл, бусад хэл 6 цаг цаг</p> <p>(ШУС, ХШУИС, БС, ХЗС, ОУХНУС тус бүр 6 багц цаг)</p>	90	31	Чех хэл	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	91	32	Чех хэл 2	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	92	33	Итали хэл	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	93	34	Итали хэл 2	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	94	35	Испани хэл	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	95	36	Испани хэл 2	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	96	37	Төвд хэл	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг
	97	38	Санскрит хэлний үндэс	ШУС, ХУС	Философи, шашин судлалын тэнхим	Нийтлэг
	98	39	Польш хэл 1	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
	99	40	Польш хэл 2	ШУС, ХУС	Европ судлалын тэнхим	Нийтлэг
<p>VIII. Биеийн тамир, эрүүл ахуй</p> <p>(ШУС, ХШУИС, БС, ХЗС, ОУХНУС тус бүр 3 багц цаг)</p>	VIII. Биеийн тамир, эрүүл ахуй					
	Хүрэх үр дүн: Бие бялдраа хөгжүүлэх, эрүүл амьдрах ухаанд суралцах, эрсдэл гамшгийн үед аюулгүй байдлаа хангах, анхан шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлж өгнө.					
	100	1	Биеийн тамир	СНА	Биеийн тамирын тэнхим	Нийтлэг
			Биеийн тамир/ сагсан бөмбөг, Аэробик, волейбол/	СНА	Биеийн тамирын тэнхим	Сонголтоор
			Биеийн тамир / Усанд сэлэлт, Туяалзүүр сэлэм, Боулинг, Бүжгийн спорт, Спортын гимнастик, Йога, Таэквондо, Бокс, Софт теннис (2-р улиралд), Хөлбөмбөг /	СНА	Биеийн тамирын тэнхим	Нэмэлт төлбөртэй спортын төрлүүд
	101	2	Хүнс ба эрүүл хооллолт	ШУС, ШУС	Биологийн тэнхим	Нийтлэг
102	3	Эмчилгээний биеийн тамир/ Тусгай бүлэг/		Биеийн тамирын тэнхим	Эрүүл мэндийн байдлаар огцом хөдөлгөөн хийх хязгаартай оюутнуудад	
103	4	Эрүүл мэндийн сэтгэл судлал	ШУС, НУС	Боловсрол, сэтгэл судлалын тэнхим	Нийтлэг	

МУИС-ийн ерөнхий суурийн оюутнуудад ерөнхий суурийн зарим хичээлийн сургалтыг англи хэл дээр явуулж байна. Англи хэл дээр заагдах дараах хичээлүүд болон багшаа сонгон судлах бүрэн боломжтой.

Мэргэжлийн суурь (Бүрэлдэхүүн сургуулийн шаардлага)

Мэргэжлийн суурь хичээлийн багц цагт тухайн бүрэлдэхүүн сургууль өөрийн санал болгож буй хөтөлбөр/хөтөлбөрүүдийн шаардлагатай суурь мэдлэг, мэргэжлийн чиглэлийн анхдагч ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой заавал болон сонгон судлах хичээлүүд орно.

Мэргэжлийн суурь хичээлийн багц цаг нь ШУС-ийн хувьд 9 багц цаг мэргэжлийн сургуулиудын хувьд 21 цаг байна.

Мэргэжлийн хичээл

Мэргэжлийн хичээлийн багц цагт тухайн мэргэжлийн эзэмшвэл зохих шинжлэх ухааны мэдлэг, шаардагдах ур чадвар, дадлыг олгох заавал болон сонгон судлах хичээлүүд орно. Мэргэжлийн хичээлийг гүнзгийрэн судлах хэлбэрээр тэнхим санал болгож болно.

Үндсэн мэргэжил олгох багц цагт оюутны суралцах үндсэн чиглэл/хөтөлбөрийн шинжлэх ухаан/мэргэжлийн бакалавр зэргийн тодорхой мэдлэг, чадвар, дадлыг заавал болон сонгон суралцах хэлбэрээр эзэмшүүлэх зорилготой бүлэг хичээл багтах бөгөөд ШУС-ийн хувьд 60 багц цаг, бусад салбар сургуулийн хувьд 54 багц цаг байна. ХЗС-ийн хувьд нийтлэг шаардлагад заасан нийт багц цагийн багтаамжтай хувь тэнцүүлэн тогтооно.

Үндсэн мэргэжлийн хичээл нь заавал болон сонгон судлах хичээлээс бүрдэнэ. Оюутан үндсэн мэргэжлийн тодорхой салбараар сонгон суралцах боломжтой байх бөгөөд үндсэн мэргэжлийн сонгох хичээл нь энэхүү зорилгод нийцсэн, оюутан сонгох боломжоор хангагдсан байна.

Чөлөөт сонголт

Чөлөөт сонголтын зорилго нь оюутан МУИС-д зааж байгаа бүх хичээлээс өөрийн хүсэл, сонирхлын дагуу чөлөөтэй сонгох боломжийг олгоход оршино. Чөлөөт сонголтын багц цаг нь 30 хүртэлх багц цаг байж болох бөгөөд оюутан энэ цагийг үндсэн мэргэжлийн хүрээнд мэргэших, хавсарга болон хос мэргэжил эзэмших, их сургуулийн хэмжээнд хүссэн хичээлээ сонгон үзэхэд зориулна.

Хавсарга болон Хос мэргэжил

Оюутан суралцаж буй үндсэн мэргэжлийнхээ сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлийг бүрэн судалж, мэргэжлийн хичээлийн багц цагийн 1/3-ийг амжилттай цуглуулсан, суралцсан хугацааны голч дүн 2.6-аас дээш байх шаардлагыг хангасан тохиолдолд хос болон хавсарга мэргэжлээр суралцах хүсэлт гаргаж болно. Хавсарга болон хос мэргэжлээр сурах хүсэлтээ сургалтын мэдээллийн системээр тухайн хичээлийн жилийн 10 болон 3-р сард гаргана

- **Хавсарга мэргэжил олгох** хөтөлбөр нь оюутныг хөдөлмөрийн зах зээлд давуу боломжтой оролцох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэх бөгөөд нийт 30 багц цаг /мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээл/-аас багагүй байна. Үндсэн мэргэжлийн зэрэгцээ хавсарга мэргэжил эзэмшиж байгаа оюутан бакалаврын зэрэг авахад шаардагдах нийт багц цаг 130 багагүй байна.
- **Хос мэргэжил** эзэмшихдээ өөрийн сурч буй хөтөлбөрөөс гадна суралцах гэж буй хөтөлбөрийнхөө шаардлагыг хангаж, мэргэжлийн суурь болон мэргэжлийн

хичээлүүдийг судална. Хос мэргэжил эзэмшиж байгаа оюутан хоёр бакалаврын зэрэг авахад шаардагдах нийт багц цагийн хэмжээ 174 багц цагаас багагүй байна.

Бакалавр, магистр, докторын түвшний зэргэцсэн хөтөлбөр

МУИС-ийн бакалаврын 3-р түвшинг 3.2-оос дээш голчтой дүүргэсэн мэргэжлийн чиглэлээр магистрын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй оюутан холбогдох тэнхим, Элсэлт, бүртгэлийн хэлтсийн зөвшөөрлөөр магистрын судалгааны арга зүй, мэргэжлийн хичээлүүдээс сонгон судлах боломжтой. Бакалаврын зэрэг авсны дараа тухайн магистрын хөтөлбөрт элсэн орж судалсан хичээлээ тооцуулна. Үүнийг цаашид бакалавр, магистрын зэргэцсэн (integrated) хөтөлбөр гэнэ.

МУИС-ийн Судалгааны магистрын 15-аас дээш багц цагийн хичээлийг амжилттай 3.0-аас дээш голчтой дүүргэсэн тухайн мэргэжил, судалгааны чиглэлээр докторын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй магистрант холбогдох тэнхим, Элсэлт, бүртгэлийн хэлтсийн зөвшөөрлөөр докторын хичээлүүдээс сонгон судлах боломжтой. Магистрын зэрэг авсны дараа тухайн докторын хөтөлбөрт элсэн орж судалсан хичээлээ тооцуулна. Үүнийг цаашид магистр, докторын зэргэцсэн хөтөлбөр гэнэ.

2. МАГИСТРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

МУИС-ийн магистрын хөтөлбөр нь судлаач болон мэргэжлийн магистр гэсэн 2 хэлбэртэй байна. Судалгааны магистр: сургалтын төлөвлөгөө нийт 30 багц цаг байна. Судалгааны магистрын хувьд магистрын судалгааны ажил бичиж, эрдэм шинжилгээний 4 багц цаг биелүүлнэ. Үндсэн хичээлийн хувьд ерөнхий суурь хичээл 3 багц цаг, мэргэжлийн хичээл 6 багц цаг, мэргэшүүлэх 8 багц цаг байна.

Мэргэжлийн магистр: сургалтын төлөвлөгөө нийт 32 багц цаг байна. Мэргэжлийн магистрын хувьд магистрын судалгааны ажил бичихгүй мэргэжлийн дадлага хийж багц цаг биелүүлнэ. Үндсэн хичээлийн хувьд ерөнхий суурь хичээл 4 багц (харилцааны чадвар, гадаад хэл), мэргэжлийн хичээл 12 багц цаг, мэргэшүүлэх 12 багц цаг, мэргэжлийн дадлага 4 багц цаг байна.

Дээд боловсролын магистрын зэрэг олгох хөтөлбөр нь мэргэжлийн суурь (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), мэргэшүүлэх (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), чөлөөт сонголт (тухайн хөтөлбөрийг хариуцсан тэнхим, нэгжээс бусад тэнхим, салбар, их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгох хичээл), удирдагч багшийн удирдлага дор хийх эрдэм шинжилгээний ажил, дадлага, магистрын ажил гэсэн бүтэцтэй байна.

Магистрант нь элссэн эхний улиралд багтаан ахисан түвшний сургуулийн бодлогын газар баталсан ганцаарчилсан төлөвлөгөөний үлгэрчилсэн загварын дагуу сургалтын төлөвлөгөө боловсруулж, тэнхимийн эрхлэгч/хөтөлбөрийн удирдагч, Элсэлт, бүртгэлийн хэлтсийн даргаар баталгаажуулна.

Магистрант, докторант нь магистрын ажил, докторын диссертацийн сэдэв, сэдвийн дагуу судалгаа хийх төлөвлөгөөг удирдагчтай зөвшилцөн боловсруулна.

Магистрын хөтөлбөрүүдэд тухайн чиглэлээс өөр бакалаврын боловсрол эзэмшсэн элсэгчдэд зориулсан хөтөлбөр боловсруулж болно. Хөтөлбөрийн нийт багц цаг 15

хүртэл байх бөгөөд тухайн шинжлэх ухааны бакалаврын түвшний мэргэжлийн суурь хичээлүүдээс бүрдэнэ.

Судлаач болон мэргэжлийн магистрын хөтөлбөрийн багц цагийг дараах байдлаар хуваарилна.

Хөтөлбөрийн агуулга	Судалгааны магистр	Мэргэжлийн магистр
Судалгааны арга зүй	3 багц цаг Судалгааны асуудал боловсруулах, таамаглал дэвшүүлэх, харьцуулсан судалгаа анализ хийх, зүй тогтол, харилцан хамаарлыг загварчлах, шинэ санаа гаргах, тоон болон чанарын шинжилгээ судалгаа хийх, дүгнэн боловсруулах, тайлагнах үр чадвар	4 багц цагаас доошгүй, үүнээс 2 багц цагийн Харилцааны чадвар (харилцааны стратеги, бүтцийг ойлгодог, бичгийн, электрон, мультимедиа, график дүрслэлээр болон яриа, бичгээр тайлагнах, хүнтэй харилцах) эзэмшүүлэх хичээл, 2 багц цагийн Мэргэжлийн гадаад хэлний хичээл
Мэргэжлийн хичээл	6 багц цаг	12 багц цаг
Мэргэшүүлэх хичээл	12 багц цагаас доошгүй, үүнээс 3 багц цагийг бусад хөтөлбөр, тэнхим, гадаад хэлний төв, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгоно, 4 багц цагийг магистрын ажилд зориулна	12 багц цаг үүнээс 6 багц цагийг бусад хөтөлбөр, тэнхим, гадаад хэлний төв, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгоно
Эрдэм шинжилгээний ажил	4 багц цаг	Мэргэжлийн дадлага 4 багц цаг (мэргэжлийн шалгалтанд бэлдэх модуль сургалтууд)
Магистрын ажил	5 багц цаг	0
		Мэргэжлийн нэгдсэн шалгалт (Мэргэшсэн нягтлан бодогч, хуульчийн гэх мэт)
Нийт багц цаг	30 багц цаг	32 багц цаг

Судалгааны магистр төгссөн суралцагч докторын түвшинд суралцах боломжтой ба мэргэжлийн магистр төгссөн суралцагч сурах боломжгүй.

Магистрын эрдэм шинжилгээний ажлын багц цаг нь удирдагч багшийн удирдлага дор хичээлийн туслахаар ажиллах, бакалаврын семинарын хичээлд бэлдэх, суралцагчдын хичээлийн явцын болон улирлын шалгалтын материал засах, бакалаврын оюутнуудад хичээлийн зөвлөгөө өгөх, эрдэм шинжилгээний хуралд оролцоход туслах, зөвлөгөө өгөх, удирдагч багшийн удирдлага дор судалгааны туслахаар ажиллаж судалгааны ажлын үр дүнг хөндлөнгийн хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлүүдэд хэвлүүлж цуглуулсан байх шаардлагатай.

Магистрын ажил нь профессор багшийн удирдлага дор магистрант бие даан эрдэм шинжилгээний судалгаа хийж, тэнхимд урьдчилсан байдлаар болон магистрын ажлыг хамгаалуулах комисст хамгаалах судалгааны ажил юм. Бүрэлдэхүүн сургуулийн онцлог, тухайн хөтөлбөрөөр олгох цогц чадамжийн шаардлагаас хамааран магистрын ажилд патент, биеэ даасан үзэсгэлэн, бизнес төлөвлөгөө, эрх зүйн бодлогын судалгааг оруулж болно.

Салбар дундын хөтөлбөрийн нийт багц цаг 32-36 байх бөгөөд дараах байдлаар хуваарилна.

Хөтөлбөрийн агуулга	Салбар дундын судлаач магистр	Салбар дундын мэргэжлийн магистр
Судалгааны арга зүй	3 багц цаг	Харилцааны чадвар эзэмшүүлэх хичээл 2 багц цаг

Мэргэжлийн хичээл	8 багц цаг	15 багц цаг
Мэргэжлийн гадаад хэл	0	0
Мэргэшүүлэх хичээл	8 багц цаг, үүнээс 3 багц цагийг бусад хөтөлбөр, тэнхим, гадаад хэлний төв, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгоно	15 багц цаг, үүнээс 6 багц цагийг бусад хөтөлбөр, тэнхим, гадаад хэлний төв, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгоно
Эрдэм шинжилгээний ажил	4 багц цаг	Мэргэжлийн дадлага 4 багц цаг
Магистрын ажил	9 багц цаг	Мэргэжлийн нэгдсэн шалгалт (багц цагт орохгүй)
Нийт багц цаг	32 багц цаг	36 багц цаг

Магистрант нь удирдагч багшаа өөрчлөх хүсэлт гаргавал холбогдох мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн удирдагч, удирдагч профессорын саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

3. ДОКТОРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Докторын зэрэг олгох хөтөлбөр нь мэргэжлийн суурь (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), мэргэжлийн заавал (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), мэргэжлийн сонгон судлах (тухайн хөтөлбөрийг хариуцсан тэнхим, нэгжээс бусад тэнхим, салбар, бусад их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгох), удирдагч багшийн удирдлага дор хийх эрдэм шинжилгээний ажил, докторын диссертаци гэсэн бүтэцтэй байна.

Докторын хөтөлбөрийн багц цагийг дараах байдлаар хуваарилна.

Хөтөлбөрийн агуулга	Докторын хөтөлбөр
Мэргэжлийн хичээл	8-9 багц цаг
Мэргэшүүлэх хичээл	14-15 багц цаг, үүнээс 6 багц цагийг бусад тэнхим, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургуулиудаас сонгоно.
Эрдэм шинжилгээний ажил	12 багц цаг, удирдагч багшийн удирдлага дор 2-3 багц цагийг судалгааны сэдвийн дагуух бакалаврын хичээлийг зааж туслах багшаар ажилласан байх, багшийн судалгааны төсөлд оролцож туслах судлаачаар ажиллаж 3-аас доошгүй багц цаг цуглуулсан байх.
Диссертаци	24 багц цаг
Нийт багц цаг	60 багц цаг

Докторын хөтөлбөрүүдэд тухайн чиглэлээс өөр магистрын боловсрол эзэмшсэн элсэгчдэд зориулсан хөтөлбөр боловсруулж болно. Хөтөлбөрийн нийт багц цаг 15 хүртэл байх бөгөөд тухайн шинжлэх ухааны магистрын түвшний мэргэжлийн суурь хичээлүүдээс тухайн докторантын судлах чиглэл, өмнө эзэмшсэн боловсрол, мэдлэг, түршлагыг харгалзан удирдагч багшийн саналыг үндэслэн хөтөлбөрийн дэд хороо шийдвэрлэнэ.

Докторант нь мэргэжлийн хичээлийн багц цагийг амжилттай судалсны дараа докторын судалгааны ажлыг эхлүүлэхийн өмнө нэгдсэн шалгалт өгнө. Нэгдсэн шалгалт авах бүрэлдэхүүн, хуваарийг холбогдох тэнхим, хөтөлбөрийн хорооны саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирал батална.

Докторын эрдэм шинжилгээний ажлын багц цагийг удирдагч багшийн удирдлага дор докторант сургалтын туслах ажилтнаар ажиллаж бакалаврын хичээлийн лекц, семинарын хичээл заах, удирдагч багшийн удирдлага дор судалгааны туслахаар ажиллах, удирдагч багштай хамтарч хийсэн судалгааны ажлын үр дүнг Томсон Ройтерс, Скопус зэрэг дэлхийн шинжлэх ухааны мэдээллийн санд бүртгэлтэй болон бусад хөндлөнгийн хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлүүдэд хэвлүүлж цуглуулсан байх шаардлагатай.

Бүрэлдэхүүн сургуулийн онцлогоос хамааран, тухайлбал Хэрэглээний шинжлэх ухааны инженерчлэлийн сургууль, Бизнесийн сургуулийн докторантын эрдэм шинжилгээний ажлын багц цагийн тодорхой хэсгийг хөтөлбөрийн онцлогт нийцүүлэн шинжлэх ухааны парк, инкубатор төв, гарааны компани байгуулсан, өндөр технологи үйлдвэрлэлд нэвтрүүлсэн, олон улсын патент авсан бол эрдэм шинжилгээний ажилд дүйцүүлэн тооцох боломжтой.

Докторын диссертацийн судалгаа нь профессор багшийн удирдлага дор докторант шинжлэх ухааны тодорхой салбарын мэдлэг, практик хэрэглээг хөгжүүлэх зорилтыг бие даан шийдсэн эсвэл улс орны нийгэм, эдийн засагт ач холбогдолтой практик асуудлыг шинжлэх ухааны онол, арга зүйн зохих түвшинд нотолсон, шийдсэн эрдэм шинжилгээний судалгаа хийж, тэнхим/бүрэлдэхүүн сургуулийн их семинар болон докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаалах судалгааны ажил юм.

Магистр, докторын эрдэм шинжилгээний багц цаг, магистрын судалгааны ажил, докторын диссертацийг тухайн сургалтын хөтөлбөрийн дагуу тооцно.

Докторант нь удирдагч багшаа өөрчлөх хүсэлт гаргавал холбогдох мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн удирдагч, удирдагч профессорын саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

Экстернат хэлбэрээр суралцах докторантын мэргэших хичээлийн 18 хүртлэх багц цагийг бүтээлүүдээр нь дүйцүүлэн тооцож болно. Дүйцүүлэн тооцож болох цагийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын томилсон комисс үнэлж, бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлөөр батлуулна. Тухайн хичээлийг мэдээллийн системд удирдагч багш дээр оноож үсгэн үнэлгээ (CR)-г оруулна. Дүйцүүлэн тооцож болох бүтээлд:

1. Үр дүн нь диссертацийн ажилд орохгүй, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэн нийтлүүлсэн өгүүлэл,
2. Их сургуулийн сурах бичиг,
3. Хэвлүүлсэн монографи,
4. Зохион бүтээсэн багаж төхөөрөмж, тогтоосон стандарт, патент,
5. Байгуулсан эрдэм шинжилгээний лаборатори, эрдэм шинжилгээний музей,
6. Зарим боловсруулалтууд (компьютерийн програм, газрын зураг/карт, хуулийн төсөл, бизнесийн кейс судалгаа албан ёсоор улсын хэмжээнд мөрдөж буй аргачлал, стандарт гэх мэт).

II БҮЛЭГ. ХӨТӨЛБӨР СОНГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

МУИС-д элсэн суралцаж, ерөнхий суурь хичээл судалсан оюутнуудад бакалаврын зэрэг олгох мэргэжлийн хөтөлбөр сонгуулах үйл ажиллагаа нь жил бүр МУИС-ийн захирлын тушаалаар батлан хэрэгждэг “Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам”-аар зохицуулагдана. Энэхүү журамд зааснаар МУИС-ийн оюутан та дараах шаардлагуудыг хангасан тохиолдолд мэргэжлийн хөтөлбөрөө сонгох боломжтой болох юм.

Үндсэн шаардлагууд:

1. МУИС-ийн бүрэлдэхүүн сургуульд элссэн байх
2. Ерөнхий суурийн хичээлүүдээс хамгийн багадаа 24 багц цагийн хичээл судалсан байх

Хөтөлбөр сонголтын үйл ажиллагаа нь дараах гурван үндсэн үе шаттайгаар явагдах бөгөөд *хөтөлбөр сурталчлах* болон *тандалт өгөх* үйл ажиллагаа нь жилд хоёр удаа зохион байгуулагдана.

I шат: Хөтөлбөр сурталчлах өдөрлөг (намар, хавар)

Намрын хөтөлбөр сурталчлах өдөрлөгөөр МУИС-д хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг бүрэлдэхүүн сургууль бүрээр нэгдсэн байдлаар танилцуулна. Мөн мэргэжлээ хэрхэн зөв сонговол зохих талаар мэргэжилтэн багш нар зөвлөгөө өгөх юм. Энэхүү үйл ажиллагаа нь оюутан танд МУИС-д хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн зохих түвшний ерөнхий мэдээллийг олгох зорилготой ба өдөрлөгийн үр дүнд оюутан та бүхэн өөрийн зайлшгүй суралцах цөөн тооны хөтөлбөрийг эхний байдлаар товлон төлөвлөсөн байна гэдэгт итгэж байна.

Хаврын хөтөлбөр сурталчлах өдөрлөг нь хөтөлбөрийг хэрэгжүүлж буй харьяа тэнхим бүрээр зохион байгуулагдана. Энэхүү үйл ажиллагааны үеэр оюутан та өөрийн төлөвлөсөн хөтөлбөрүүдийн талаар мэргэжлийн багш, төгсөгчдийн төлөөлөл нартай уулзан илүү нарийвчилсан мэдээлэл авахад чиглэгдэх юм.

II шат: Элсэх хөтөлбөрийн хүсэлт буюу урьдчилсан тандалт (намар, хавар)

Хөтөлбөр сурталчлах үйл ажиллагаа явагдсаны дараа (Зураг №1) элсэх хөтөлбөрийн хүсэлт буюу урьдчилсан тандалтыг заавал өгнө. Урьдчилсан тандалтын мэдээлэлд үндэслэн харьяа бүрэлдэхүүн сургуулиуд нь тухайн хөтөлбөрөөр элсүүлэх оюутны хяналтын тоог (квот) тогтоодог тул тандалтын үйл ажиллагаанд идэвхитэй оролцсоноор таны сонгосон хөтөлбөрт элсэн орох боломж улам нэмэгдэх юм.

III шат: Хөтөлбөр сонголт (баталгаажуулалт - хавар).


Хөтөлбөр сонголт ба баталгаажуулалт нь хичээлийн жилийн төгсгөлд буюу хаврын улирлын дүн гарсны дараа зохион байгуулагдана (Зураг №1-д зааснаар 2020 оны 06-р сарын 15-19-ний өдрүүдэд). Энэхүү үйл ажиллагаа нь мэргэжлийн хөтөлбөрт саналаа өгөх, өгсөн саналаа баталгаажуулах гэсэн 2 үе шаттайгаар зохион байгуулагдах ба нийт саналаа өгсөн оюутнуудыг “Оюутны оноо” гэж нэрлэгдэх оноогоор эрэмбэлэн хөтөлбөр сонгох дарааллыг тогтооно. Оюутны оноог тооцоход оюутны голч дүн, цуглуулсан багц цаг болон ЭШ-ийн оноо гэсэн үндсэн гурван үзүүлэлтийг хувиалан тооцно. Хөтөлбөр сонгон баталгаажуулсан оюутнуудыг МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулж оюутан цаашид суралцхаар баталгаажуулсан хөтөлбөрийн хичээлүүдийг сургалтын мэдээллийн системээр сонгон судлах эрхтэй болно.

Анхаарах зүйлс:

- Оюутан ерөнхий суурийн хөтөлбөрт хичээлийн 2 жил хүртэлх хугацаанд суралцаж болно. Энэ хугацаанд мэргэжлийн хөтөлбөр сонгохгүй бол сургуулиас хасахыг анхаарна уу
- Хөтөлбөр сурталчлах өдөрлөгийн дараагийн 7 хоногт багтаан өөрийн суралцахыг хүсч буй хөтөлбөрийн урьдчилсан саналыг СиСи системийн дагуу гаргана.
- Тодорхой хүндэтгэн үзэх шалтгаанаар мэргэжлийн хөтөлбөр сонгох боломжгүй болсон тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан сонгуулах боломжтой бөгөөд энэ талаар урьдчилан Хөтөлбөр, Чанарын Баталгаажуулалтын Хэлтэс (ХЧБХ)-т маягтын дагуу мэдэгдсэн байна.
- Хөтөлбөр сонголтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө хөтөлбөр сонголтоо хойшлуулах хүсэлтийг ХЧБХ-д холбогдох маягтын дагуу гаргаж болно.
- Оюутан хөтөлбөр сонголтоо хойшлуулсан, сонголтоос хоцорсон тохиолдолд дараагийн намрын улирлын төсгөлд хяналтын тоо нь гүйцээгүй хөтөлбөрөөс сонгож болно.
- Мэргэжлээ сонгож чадаагүй, шаардлага хангаагүй оюутнууд Ерөнхий суурийн хичээлүүдээс сонгон үргэлжлүүлэн суралцана.
- Мэргэжлийн хөтөлбөрөө сонгосон, зохих болзол хангасан оюутан шилжих хүсэлт гаргах боломжтой. Энэ нь тусдаа МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журмаар зохицуулагдана.

2020-2021 оны хичээлийн жилд элсэгчдийн хувьд дээрх үндсэн үйл ажиллагаануудын календарьчилсан төлөвлөгөөг Зураг №1-д үзүүлэв.

Оюутан та хөтөлбөрийн сурталчилгаа, тандалт өгөх болон баталгаажуулалтын үйл ажиллагаанд идэвхитэй оролцоно уу.



Зураг №1. 2020-2021 оны хичээлийн жилийн хөтөлбөр сонголтын календарьчилсан төлөвлөгөө

СИСТЕМ ДЭЭР ХӨТӨЛБӨРТ ТАНДАЛТ ӨГӨХ БОЛОН СОНГОЛТ ХИЙХ ПРОЦЕСС хэрхэн явагддаг вэ?


Бакалаврын өдрийн ерөнхий суурь хөтөлбөрийн оюутнуудын мэргэжлийн хөтөлбөр сонгуулах процессийн үйл ажиллагаа нь дараах үе шаттайгаар, цахим хэлбэрээр явагдана. Үүнд:

- Хөтөлбөр сурталчлах өдөрлөг зохион байгуулагдсан долоо хоногийн дараачийн долоо хоногт багтаан 4 хүртэлх хөтөлбөрт урьдчилсан хүсэлт (тандалт) өгөх. Энэхүү үйл ажиллагаа нь жилд 2 удаа зохион байгуулагдах тул товлосон хугацааг Зураг №1-с харна уу.
- Хаврын улирлын дүн гарч дууссаны дараа зохион байгуулагдах хөтөлбөр сонголт, баталгаажуулалтын үеэр элсэхээр шийдсэн 3 хүртэлх хөтөлбөрт эцсийн байдлаар санал өгч, уг санал өгсөн хөтөлбөрүүдийн дундаас зөвхөн нэг хөтөлбөрийг сонгож баталгаажуулах.


A. Урьдчилсан хүсэлт, эцсийн санал өгөх процесс

Дээр дурьдсанчлан хөтөлбөрийн урьдчилсан хүсэлт (2019 оны 11-р сар, 2020 оны 3-р сар) болон 2020 оны 6-р сард зохион байгуулагдах мэргэжил сонголт, баталгаажуулалтын үеийн эцсийн санал нь Сиси системийн хувьд адилхан байдлаар гүйцэтгэгдэнэ.

Мэргэжлийн хөтөлбөр сонгох болзол хангасан оюутнууд журамд заасан хугацааны дагуу системийн зүүн талд байрлах **Хөтөлбөр сонголт** -> **Тандалт, санал** хэсгээр орон, журамд заасан тооны дагуу мэргэжлийн хөтөлбөрүүдэд саналаа өгнө. **Хөтөлбөр сонголт** -> **Тандалт, санал** хэсгээр ороход саналын тооноос хамааран дараах хэсэг дуудагдана.



Оюутан та харгалзах **Хөтөлбөр сонгох** товч бүр дээр даран ялгаатай хөтөлбөрүүдэд саналаа өгнө.



Тухайн хөтөлбөрийг сонгоод **Хадгалах** товч дарснаар тухайн хөтөлбөрт тандалт өгсөн гэсэн үг бөгөөд тандалт өгсөн хөтөлбөрүүд дараах байдлаар харагдана. Энэ хэсгээс тандалт өгсөн хөтөлбөрийг журмын тандалт өгөх хугацаанд солих боломжтой.

2015-	-аас 2015-	-ны хооронд явагдана.	Өгсөн сонголт
1	Компьютерийн график дизайны		Тандалт өгсөн хөтөлбөрүүд
2	Мэдээллийн систем		Сонгосон хөтөлбөрийг солих
3	Менежмент, мэдээллийн системийн		
4			

Санамж:

- Бүрэлдэхүүн сургуулиас хамааран оюутны тандалт өгөх хөтөлбөрийн тоо ялгаатай байна.
- Журамд заасан тандалт өгөх хугацаанд өөрийн тандалт өгсөн хөтөлбөрийг өөрчлөх боломжтой.
- Журамд заасан тандалт өгөх хугацаа дууссан тохиолдолд өөрийн тандалт өгсөн хөтөлбөрийг өөрчлөх боломжгүй.
- Оюутан та зөвхөн тандалт өгсөн мэргэжлийн хөтөлбөрүүдээс сонгож баталгаажуулах учир сонголтгоо зөв хийгээрэй.

Б. Онооны үзүүлэлт

Оюутан та **Хөтөлбөр сонголт** -> **Онооны үзүүлэлт** хэсгээс мэргэжлийн хөтөлбөр сонгох болзол хангасан, хангаагүй эсэхээ харах бөгөөд хэрвээ та мэргэжлийн хөтөлбөр сонгох болзлоо хангасан бол тухайн салбар/сургуулийн хэмжээнд нийт хэдэн оюутнаас хэдэн оноотойгоор хэддүгээр байранд явж байгаагаа харах боломжтой.




Санамж:

- Мэргэжлийн хөтөлбөр сонгох журмын дагуу оюутныг болзол хангасан, хангаагүйг бодож байгаа учраас журамтай сайтар танилцана уу.
- Оюутны оноог журмын **3.1.2-ийн 6-д** заасан томъёоны дагуу бодогдоно.


В. Онооны жагсаалт

Оюутан өөрийн сургуулийн нийт оюутнууд болон өөрийн тандалт өгсөн хөтөлбөрүүдэд санал өгсөн нийт оюутнуудын онооны жагсаалт болон сонгож баталгаажуулсан мэргэжлийг **Хөтөлбөр сонголт -> Онооны жагсаалт** хэсгээс харж, хянах боломжтой.




Г. Баталгаажуулалт


Мэргэжлийн хөтөлбөрүүдэд саналаа өгсний дараа журамд заасан хугацаанд **Хөтөлбөр сонголт -> Баталгаажуулалт** хэсгээр орон зөвхөн тандалт өгсөн тухайн хөтөлбөрийн хяналтын тоонд багтсан хөтөлбөрүүдээс зөвхөн **НЭГ** мэргэжлийн хөтөлбөрийг сонгож баталгаажуулна.




Одоогоор эзэлж байр нийт хяналтын тоонд багтсан тохиолдолд дээрх зурагт үзүүлсэн байдлаар сонгох боломжтой. Өөрийн сонгох хөтөлбөрт харгалзах **Сонгох** талбар дахь утгыг сонгож **Баталгаажуулах** товч дээр даран сонгосон хөтөлбөрийг баталгаажуулах бөгөөд доорх анхааруулга цонх гарч ирнэ.



Анхааруулга цонхонд гарч ирсэн санамжтай сайтар танилцсаны дараа **“Тийм. Зөвшөөрч байна.”** гэсэн хэсгийг чагталж **«Баталгаажуулах»** товч дээр дарснаар таны сонгосон хөтөлбөр баталгаажна.



Баталгаажсан хөтөлбөр доорх байдлаар харагдана.



- * Тухайн оюутан мэргэжлийн хөтөлбөр сонголтоо баталгаажуулахад бусад хөтөлбөрт өгсөн санал нь хүчингүй болж энэ хугацаанд жагсаалтын дагуу улаан шугамны доор байгаа оюутан хяналтын тоонд нэмэгдэн сонголтоо баталгаажуулах боломжтой.
- * Оюутан өөрийн сургуулийн нийт оюутнууд болон өөрийн тандалт өгсөн хөтөлбөрүүдэд санал өгсөн нийт оюутнуудын онооны жагсаалт болон сонгож баталгаажуулсан мэргэжлийг **Жагсаалт харах** харах хэсэг болон **Хөтөлбөр сонголт -> Онооны жагсаалт** хэсгээс харж, хянах боломжтой.



Санамж:

- *Оюутан та зөвхөн тандалт өгсөн мэргэжлийн хөтөлбөрүүдээс сонгож баталгаажуулна.*
- *Нэгэнт баталгаажуулсан мэргэжлийн хөтөлбөрийг буцаах боломжгүй тул сонголтоо анхааралтай хийнэ үү.*
- *Хэрвээ та мэргэжлийн хөтөлбөрөө журамд заасан хугацаанд системээр баталгаажуулж чадаагүй бол үлдсэн хөтөлбөрийн хяналтын тооны дагуу нэмэлтээр сонгох боломжтой.*

МЭРГЭЖИЛ СОНГОХ ЗӨВЛӨМЖ

Мэргэжил бол хүний хамгийн үнэ цэнэтэй баялаг, орлого олж, сэтгэл хангалуун амьдрах үндсэн хэрэгсэл юм. Та ч гэсэн эзэмшсэн мэргэжлийн мэдлэг, чадвараараа материаллаг болон оюуны баялгийг бүтээж, тогтвортой орлого олж, амьдралаа өөрийн гараар бүтээн байгуулна.

Мэргэжлээ сонгоно гэдэг нь хүсэл сонирхол, чадавх, боломжоо таньж мэдсэний үндсэн дээр мэргэжлүүдийн талаарх мэдлэгтэй тулгуурлан, өөрийнхөө ирээдүйн ажил, мэргэжлийн талаар үндэслэлтэй шийдвэр гаргах явдал юм. МУИС-ийн Оюутан үйлчлэх алба, Боловсрол, сэтгэл судлалын тэнхим хамтран мэргэжил сонгох талаар зөвлөмжийг танд хүргэж байна.

Мэргэжлийг үндэслэлтэй сонгох арга замууд:

- 1. Мэргэжлүүдийн талаар мэдлэг олж авах.** Мэргэжлийн төрөл нь олон янз, тооны хувьд бидний ердийн төсөөлдгөөс хавьгүй олон. 2008 онд хэвлэгдсэн ажил, мэргэжлийн олон улсын стандартчилсан ангилал (ISCO-08)-д 9000 гаруй ажил, мэргэжлийн мэдээлэл орсон бий. Олон хүн амтай, хөгжингүй улс орнуудад үүнээс ч илүү тооны мэргэжил хэрэглэгддэг тухай мэдээлэл байдаг.
- 2. Мэргэжилд чиглэсэн хүсэл сонирхлоо таньж мэдэх.** Хүн өөрийн сонирхдог, өөртөө таалагддаг ажилдаа илүү амжилт гаргадаг. Энэ утгаараа сонирхол нь мэргэжлээ сонгохдоо зайлшгүй харгалзан үзэх ёстой зүйл юм. Мэргэжилд чиглэсэн хүсэл сонирхлоо тодорхойлдог аргууд бий. Тухайлбал, хүсэл сонирхлыг тандах тест бөглөх, сэтгэл судлаач, ажил мэргэжлийн зөвлөгч нараас зөвлөгөө авах, хүсэл сонирхлынхоо талаар эсээ бичих гэх мэт.
- 3. Мэргэжилд чиглэсэн чадавхаа харгалзан үзэх.** Аливаа ажил үйлд зөвхөн хүсэл сонирхол хангалттай биш. Тухайн ажлыг амжилттай гүйцэтгэх чадавх зайлшгүй хэрэгтэй. Хүн бүхэн өөр өөрийн онцлог чадавхтай. Хүн чадавхдаа тохирсон ажлыг л амжилттай гүйцэтгэдэг. Нөгөөтээгүүр, ажил, мэргэжил бүхэнд өөр өөр чадавх шаардагддаг.
Ийм учраас мэргэжлээ зөв сонгохын тулд нэгдүгээрт, өөрийн чадавх тодорхойлсон байх, хоёрдугаарт, сонирхож байгаа мэргэжлүүд тань чухам ямар чадавх шаарддагийг судалж мэдсэн байх, гуравдугаарт, өөрийн чадавхыг тухайн мэргэжилд шаардагддаг чадавхтай харьцуулан шинжилж, өөрт тохирох эсэх талаар дүгнэлт гаргах учиртай.
- 4. Өөрийнхөө чадавх, боломжийг бодитой үнэлэх.** Өөрийгөө бодитой байгаагаас нь дээгүүр үнэлвэл хуурамч төсөөлөлд автаж, биелэх боломжгүй, хүрч чадахааргүй зорилго тавихад хүргэдэг. Харин чадавхаа бодитой байгаагаас нь доогуур үнэлдэг хүн өөрийгөө бусдаас ямагт дутуу гэж үздэг. Тийм хүмүүс чадавхаасаа доогуур сонголт хийж, амжилтад хүрэх боломжоо алддаг байна.
- 5. Эцэг эх, ойр дотнын хүмүүстэйгээ зөвлөлдөх.** Мэргэжлээ сонгоход эцэг эх, асран хамгаалагч нарын идэвхтэй оролцоо хэрэгтэй байдаг. Эцэг, эхийн санал болгож байгаа мэргэжил нь хүүхдийнх нь хүсэл сонирхол, чадавх, боломжид тохирч байвал сайн хэрэг. Харин тийм биш бол хүүхэд эцэг эхтэйгээ (мөн багш, ажил мэргэжлийн зөвлөгчтэй) сайтар зөвшилцөж, зөв сонголт хийх нь чухал байдаг.
- 6. Найз нөхөдтэйгээ зөвлөлдөх.** Та өөрийнхөө чадавх, боломжийг сайн мэддэг гэж бодож байж болох юм. Харин найз нөхөд чинь таны чадавх, боломжийн талаар өөр дүгнэлттэй байж магадгүй. Найз нөхдийн дүгнэлт нь танд өөрийнхөө бодит чадавх, хувийн шинж чанараа шүүн тунгаах боломжийг олгоно.
- 7. Багш, ажил мэргэжлийн зөвлөгч нараас зөвлөгөө авах.** Мэргэжлээ сонгохдоо сургуулийнхаа багш, сэтгэл судлаач, ажил мэргэжлийн зөвлөгч нартай уулзаж зөвлөгөө авах нь ач холбогдолтой. Багш өөрийн тань чадавх, боломж, хувийн

шинж чанарын талаар үнэ цэнэтэй зөвлөгөө өгч чадна.

- 8. Ажил мэргэжлийн ирээдүйн төлөвлөгөөгөө харгалзан үзэх.** Мэргэжлийн ирээдүйн төлөвлөгөө гэдэг бол ямар мэргэжил эзэмших, цаашид хэрхэн өсөж хөгжих, орлого олж сэтгэл хангалуун амьдрах талаар тухайн хүний төсөөлж, төлөвлөж байгаа зүйл юм. Ирээдүйтэй холбоотой ийм асуудлыг урьдаас нарийн төлөвлөх нь бэрхшээлтэй байдаг боловч ажил мэргэжлийн талаар ямар нэгэн чиг баримжаатай, зорилготой байх нь нэн чухал юм.


Мэргэжил сонгоход гардаг алдаанаас сэргийлэх нь

Мэргэжлээ сонгох явдал нь хүний ирээдүйн ажил, амьдралтай холбоотой хариуцлагатай шийдвэр боловч амьдрал дээр оюутнууд мэргэжлээ сонгохдоо алдаа гаргах нь олонтаа байна. Тухайлбал:

1. Чадавх, боломжоо бодитой үнэлэхгүйгээр мэргэжлээ сонгох нь алдаанд хүргэнэ. Оюутан бүр өөрийн чадавх, боломжоо бодитой үнэлж, мэргэжлээ сонговол амжилтад хүрнэ. Тухайн мэргэжилд чухал шаардлагатай чадавх, шинж чанарыг өөрийн чадавх, боломжтой харьцуулж үзэх нь зүйтэй.
2. Ажил мэргэжлийг сайтар судлахгүйгээр сонголт хийх нь буруу. Мэргэжил бүхний үйл ажиллагааны агуулга, технологи, ажлын нөхцөл нь өөр өөр байдаг бөгөөд түүнд тохирсон мэдлэг, чадвар, шинж чанарыг хүнээс шаарддаг. Ийм учраас тухайн мэргэжилд шаардлагатай чадавх, шинж чанар нь уг мэргэжлийг сонгож байгаа хүний чадавх, шинж чанартай нийцэж байх учиртай. Энэ бол мэргэжил сонгох үндсэн шалгуур юм.
3. Мэргэжлийг шохоорхох байдлаар сонгохоос зайлсхий. Мэргэжлийн тухайн үеийн нэр хүнд, цалин хангамж зэрэг шинжийг нь шохоорхож мэргэжил сонгох нь алдаанд хүргэдэг. Мэргэжлийн нэр хүнд, цалин мэт нь тухайн мэргэжил танд тохирох эсэхийг нотлох үзүүлэлт биш бөгөөд уг мэргэжлийн зөвхөн ил харагддаг тал нь юм. Тэгээд ч зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан мэргэжлийн эрэлт, нэр хүнд, цалингийн хэмжээ ч өөрчлөгддөг гэдгийг анхаарах нь зүйтэй.
4. Мэргэжлийг “ирээдүйтэй”, “ирээдүйгүй” гэж ялгаварлах нь алдаанд хүргэдэг. Оюутнууд ямар мэргэжил ирээдүйтэй вэ? гэсэн асуултыг олонтаа тавьдаг. Ирээдүйтэй мэргэжил гэж байдаггүй, харин ирээдүйтэй мэргэжилтэн гэж байдаг. Тухайлсан нэг мэргэжил дээр аваад үзэхэд, амжилттай ажиллаж байгаа хүмүүс байхад, төдийлөн амжилт гаргаж чадахгүй байгаа хүмүүс бий.
5. Хичээлийг мэргэжилтэй адилтган үзэж сонголт хийх нь эрсдэл дагуулна. Ерөнхий суурийн хүрээнд судалдаг хичээл, мэргэжил хоёр бол өөр өөр зүйл юм. Математик, физик, хими, биологи, түүх, газарзүй, хэл, уран зохиол гэх мэт хичээл нь юуны өмнө мэдлэгийн салбар юм. Харин мэргэжил гэдэг нь үүнээс ялгаатай өргөн хүрээтэй ойлголт байдаг. Иймээс зөвхөн “хичээлд сонирхолтой” гэдэг үүднээс мэргэжлийн сонголт хийхээс зайлсхийх хэрэгтэй.
6. Бусдын нөлөөнд автаж мэргэжлээ сонгох нь алдаанд хүргэнэ. Ажил, мэргэжлийн талаар тодорхой мэдлэггүй ч гэсэн мэргэжил сонгох асуудлаар хүн бүхэн л ярьж зөвлөдөг. Туршлага багатай, өөрийн тань сонирхол, авьяас чадварыг таньж мэдээгүй хүнээс зөвлөгөө авах нь тийм ч үр дүнтэй биш байдаг.
7. Өөрөө үлгэр дууриалал авдаг хүмүүсийг дуурайж мэргэжлээ “сохроор” сонгох нь алдаа дагуулна. Та хэн нэгнийг хүндэтгэдэг, тэр хүн танд үлгэр дууриал болдог байж болно. Гэхдээ энэ нь тэр хүний мэргэжил танд мөн тохирно гэсэн үг биш. Хүндэтгэдэг хүн, мэргэжил хоёр нь өөр өөр ойлголтууд байдаг. Таны хүндэтгэдэг хүний мэргэжил танд тохирч болох л юм. Гэхдээ та үүнийг шинжлэх ухааны үндэслэлтэй нотлох хэрэгтэй.
8. Найз нөхдөө дуурайж мэргэжлээ сонгохоос болгоомжил. Нэгнийгээ дуурайх

үзэгдэл бишгүй л байдаг. Найз нөхдөө дуурайж адилхан компьютер, гар утас, хувцас мэтийг худалдаж авах нь зөвтгөх аргагүй боловч байдаг л үзэгдэл. Харин нэгнийгээ дуурайж мэргэжил сонгох нь байж боломгүй зүйл юм.

9. Мэргэжлийн нөөц хувилбаргүй байх нь алдаа дагуулна. Нөөц хувилбаргүйгээр ганц мэргэжил сонгох нь эрсдэлтэй. Ямар нэгэн шалтгааны улмаас тэр мэргэжлээрээ суралцаж чадахгүйд хүрвэл ирээдүйн ажил мэргэжлийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх боломжгүй болох муу үр дагавартай. Нөөц хувилбар гэдэг нь багаар бодоход 3-аас доошгүй мэргэжлийг сонгоно гэсэн үг. Хэрвээ нэг дэх мэргэжлээрээ суралцах боломжгүйд хүрвэл хоёр дахь мэргэжлээр, хоёр дахь нь боломжгүй болвол гурав дахь мэргэжлээр суралцах жишээтэй.
10. Мэргэжлээ сонгохдоо уян хатан биш хандвал алдаанд хүргэнэ. Мэргэжил бол өөрчлөгдөж хувирдаггүй зүйл биш юм. Учир нь, нэгдүгээрт, хүн өөрөө ч, сонирхол нь ч хөгжиж өөрчлөгдөж байдаг. Цаг хугацааны явцад хүний нуугдмал байсан авьяас, чадавх илрэн гарах нь бий. Хоёрдугаарт, технологийн хөгжлийн нөлөөгөөр мэргэжлийн ажлын агуулга, шинж чанар шинэчлэгдэж, мэргэжилтэн хүний мэдлэг чадварт тавигдах шаардлага өөрчлөгдөж байдаг. Гуравдугаарт, нийгэм, эдийн засаг, үйлдвэрлэлийн шинэ салбарууд үүсч, түүнийг дагаад шинэ мэргэжлүүд ч олноор бий болж байна.



III БҮЛЭГ. МУИС-ИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

Бакалаврын зэрэг олгох сургалтын зорилго нь бүрэн дунд боловсролтой иргэнийг нийгмийн идэвхтэй гишүүн байхад зайлшгүй шаардлагатай бүтээлч, логик сэтгэлгээтэй, санаачлагатай, шинжлэх ухаанч шийдвэр гаргадаг, нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны суурь мэдлэг эзэмшсэн, ёс зүйтэй, мэргэжлийн мэдлэг, үр чадвартай дээд боловсролтой иргэн болгон төлөвшүүлэхэд оршино.

МУИС-ийн сургалтын үйл явц нь Сургалтын журмын дагуу зохицуулагдах бөгөөд сургалтын календарьчилсан төлөвлөгөөний дагуу явагдана.

ХИЧЭЭЛД БҮРТГҮҮЛЭХ, БАТАЛГААЖУУЛАХ, ЦУЦЛАХ

Хичээлд бүртгүүлэх үйл ажиллагаа нь хичээлд санал өгөх, баталгаажуулалт гэсэн хоёр үе шаттай, цахим /<http://sisi.num.edu.mn/> хэлбэрээр явагдана.

- Бакалаврын өдрийн хөтөлбөрийн хувьд оюутан улиралд дунжаар 15 багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн доод хэмжээ 12, дээд хэмжээ 21 байна.
- Магистрын хөтөлбөрийн хувьд улиралд дунджаар 10 багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн дээд хэмжээ 16 байна.
- Докторын хөтөлбөрийн хувьд улиралд дунджаар 10 (эчнээ бол 6) багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн дээд хэмжээ 18 байна.

Суралцагч судалж буй хичээлийн агуулга, чанар, багшийн заах арга, ёс зүй, харилцаа, суралцах орчны талаарх судалгааг цахим хэлбэрээр өгснөөр дараа улирлын хичээлийн санал өгөх эрх нээгдэж тухайн улирлын **13, 14** дэх долоо хоногт багтаан дараагийн улиралд судлах хичээлд санал өгнө. Санал өгснөөр хичээл баталгаажуулалтын хугацааны 50 хувьд тухайн хичээлийг баталгаажуулах давуу эрх эдэлнэ.

Мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн хороо хичээлийн саналыг үндэслэж **15, 16** дахь долоо хоногт багтаан хичээл орох багшийг эцэслэн тодорхойлж, дараагийн улиралд орох хичээл, заах багшийн нэр, анги танхим, цаг бүхий хичээлийн хуваарийг улирлын шалгалтын хугацаанд бэлэн болгоно.

Суралцагч хичээлийн хуваарийг үндэслэн тухайн улирал эхлэхээс өмнөх долоо хоногт (**0 долоо хоног**) хичээлд бүртгүүлэх ба **24** цагийн дотор бүртгүүлсэн хичээлийн багц цагийн төлбөрийг цахим хэлбэрээр төлж, баталгаажуулна.

Улирлын эхний **7 хоногт (ажлын 5 өдөр)** 1 багц цагийн төлбөртэйгөөр баталгаажуулалтыг нээнэ. Суралцагч баталгаажуулсан хичээлийг хичээлд бүртгүүлэн, баталгаажуулах хугацаанд өөрөө цуцалж болно.

Магистр, докторын эрдэм шинжилгээний ажил, магистрын судалгааны ажил, докторын диссертацийг төгсөх улиралдаа сургалтын мэдээллийн системээр сонгон баталгаажуулна.

Хүндэтгэн үзэх шалтгаанаар заасан хугацаанд хичээлдээ бүртгүүлж амжаагүй суралцагч тухайн улирлын эхний **7 хоногт багтан** бүртгүүлэх боломжтой хичээлд

бүртгэлийн хураамж төлж бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж нь тухайн хичээлийн 1 багц цагийн төлбөртэй дүйцэхүйц байна.

Улирлын хичээл эхэлснээс хойш, сургалтын төлөвлөгөөн дэх тухайн хичээлийн цагийн **30 хувь** өнгөрөөгүй байхад баталгаажуулсан хичээлээ цуцлах тохиолдолд хичээлийн багц цагийн төлбөрийн **70 хувийг** дараагийн улиралд бүртгүүлэх хичээлийн багц цагийн төлбөрт шилжүүлнэ. Хичээлийн цагийн 30-аас дээш хувь өнгөрсөн бол багц цагийн төлбөрийг буцааж олгохгүй. Улирлын эхний 7 хоногт СиСи-ээр цуцлах, 2 дахь 7 хоногт Элсэлт, бүртгэлийн хэлтэст хандаж цуцална.

СУРАЛЦАГЧИЙН МЭДЛЭГ, ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

Хичээлээр эзэмшсэн суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэхдээ тэдний бие даан суралцах үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, хөгжүүлэх, оюутны сурах, багшийн сургах хариуцлагыг өндөржүүлэх зарчмыг удирдлага болгох бөгөөд үнэлгээ шинжлэх ухааны үндэстэй, бодитой, шударга, ил тод байна. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлж дүгнэх гол хэлбэр нь шалгалт байна.

Суралцагчийн сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнгээр тодорхойлно. Голч оноо, голч дүнг бодохдоо багц цаг бүхий хичээл бүрээр оюутны авсан оноо/дүнг харгалзах багц цагаар нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг багц цагийн нийлбэрт хувааж (арифметикийн жинлэсэн дундаж), таслалаас хойш нэг орны нарийвчлалтай бодож гаргана.

$$ГО = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot O_i}{\sum_{i=1}^n K_i} \quad ГД = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot Д_i}{\sum_{i=1}^n K_i}$$

n - хичээлийн тоо

K_i - тухайн (i) дугаар хичээлийн багц цаг

$O_i(Д_i)$ - тухайн (i) дугаар хичээлийн оноо (дүн)

ГО(ГД) - голч оноо (голч дүн)

Суралцагч улирал бүр тухайн улирлын мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнтэйгээ танилцан, сурлагынхаа байдалд үнэлэлт дүгнэлт хийж цаашид суралцах үйл ажиллагаагаа төлөвлөнө.

Суралцагчийн голч оноо, голч дүнг улирал, хичээлийн жил, суралцсан хугацаа, мэргэжлийн хөтөлбөр, бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд суралцагчийг байр эзлүүлэхэд ашиглах буюу оюутныг үндсэн мэргэжлийн хөтөлбөр сонгуулах, хавсарга болон хос мэргэжил эзэмшүүлэх, бакалавр, магистрын зэргэцсэн хөтөлбөрт суралцуулах, суралцагчийг шагнах, тэтгэлэг олгохоор тодорхойлох, магистр, докторын зэргэцсэн хөтөлбөрт суралцуулах, төгсгөх, оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах, магистр, докторын хөтөлбөрт үргэлжлүүлэн сургах зэрэгт гол үзүүлэлт болгоно.

Семинар, лабораторийн хичээл, судалгааны ажил бусад бие даалтын ажлаар олсон мэдлэг, чадварыг үнэлэхэд төсөл, тайлан хамгаалалт, явцын шалгалт, тест, ангийн ажил болон тэдгээртэй дүйцэх бусад хэлбэрийг ашиглах ба мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлээр хийх дадлагад багц цаг харгалзуулсан бол тэдгээрийн

тайлангийн хамгаалалтыг шалгалтын нэгэн адил үзэж оноогоор үнэлнэ.

Ерөнхий суурь хичээлийн үнэлгээ

Ерөнхий суурь хичээлийн шалгалтыг тест болон бусад хэлбэрээр авах ба явцын болон улирлын тест (сорилго) хэлбэрийн шалгалтыг зохион байгуулж суралцагчдын дүнгийн мэдээллийг хичээл зааж буй багшид ажлын 2 хоногийн дотор өгнө.

Ерөнхий суурийн англи хэлний хичээлийн агуулгын шаардлагыг хангасан мэдлэгтэй суралцагч нь тухайн чиглэлээр гадаад хэлний төвд шалгалт өгч эсвэл TOEFL, IELTS-ийн харгалзах түвшний онооноос дээш оноотой, МУИС-ийн харъяа байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай “Байгаль-Эх” лицей ахлах сургууль болон МУИС-тай багц цаг тооцох гэрээ байгуулсан ахлах сургуулийг төгссөн сурагч ерөнхий суурь хичээлийн байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны багцаас гүнзгийрүүлэн судалсан 85-аас дээш үнэлгээтэй хичээлийг дүйцүүлэн тооцуулж болно.

Суралцагчийн тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээ

Тухайн хичээлээр суралцагчийн улирлын туршид эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээг гаргахдаа оюутны хичээлийн явцын идэвх оролцоо, бие даасан ажиллагааны завсрын хяналтын үнэлгээ, улирлын шалгалтын үнэлгээ тус бүрийг зохих хэмжээгээр тооцон 100 оноогоор үнэлнэ.

$$O = O_1 + O_2 + O_3$$

Үүнд:

O ₁ -	Идэвх, оролцооны үнэлгээ. Хичээлд оролцсон бүтээлч ирц, семинар, дадлагын хичээлд бэлтгэсэн байдал зэрэгт багшийн өгсөн үнэлгээ бөгөөд 20-40 оноо байна.
O ₂ -	Суралцагчийн явцын үнэлгээ. Улирлын явцад хийсэн илтгэл, реферат, тайлан, хяналтын ажил, коллеквиум, сэдвийн үнэлгээний дундаж болон явцын шалгалтын нийлбэр бөгөөд 20-40 оноо байна.
O ₃ -	Улирлын шалгалтын үнэлгээ бөгөөд 20-60

Тайлбар:

- Суралцагчийн ирц, идэвх оролцоог бүртгэн үнэлэх боломж хязгаарлагдмал хичээлийн хувьд тэнхим хэлэлцэж, O₁ оноог хамгийн бага боломжит хэмжээнд тогтоож болно.
- Хичээл бүрийн хөтөлбөрт тухайн хичээлээр суралцагчийн олж авсан мэдлэг, чадварыг үнэлэх онооны хуваарилалтыг хэдэн ч хэсгээр хийсэн байж болох ба багш түүнийг баримтлана.
- O₁, O₂, O₃ үнэлгээ нь бүхэл тоон нарийвчлалтай байна.

Хичээлд 60 ба түүнээс дээш оноо авсан суралцагчийг уг хичээлийн агуулгыг судалж, багц цагийг биелүүлсэн гэж үзнэ. Харин 60-аас бага оноо авсан суралцагчийг “хангалтгүй” суралцсан буюу тухайн хичээлийн багц цагийг биелүүлээгүй гэж үзнэ. Мөн багц цаг тооцохгүй хичээлийн шалгалтыг авахдаа шалгалтын адил 100 оноогоор үнэлнэ. Суралцагчийн авсан оноо нь 60 ба түүнээс дээш бол “тооцов”, 60-аас доош бол “үл тооцов” гэж дүгнэх бөгөөд үнэлгээг харгалзан “S”, “U” гэж бичнэ.

Хувьчилсан оноо, үсгээр илтгэсэн дүн ба тоогоор илтгэсэн дүнгийн хоорондын холбоо дараах хэлбэртэй байна. Үүнд:

Хувьчилсан оноо	Үсгээр илтгэсэн дүн	Тоогоор илтгэсэн дүн
95-100	A	4.0
90-94	A-	3.6
85-89	B	3.1
80-84	B-	2.7
75-79	C	2.3
70-74	C-	1.9
65-69	D	1.4
60-64	D-	1.0
0-59	F	0

Суралцагчийг үнэлэхдээ тоо болон үсгээр илтгэсэн дүнг хэрэглэхээс гадна I, E, NC, CR, R, W, NA, NR, S, U гэсэн нэмэлт тэмдэглэгээг хэрэглэнэ. Эдгээр тэмдэглэгээ нь суралцагчийн голч дүн буурах шалтгааныг тогтоох, суралцагч голч дүнгээ хянах, дүнгээ ахиулах боломж олгох, бусад сургуулийн багц цагийг шилжүүлэн тооцох зэрэгт хэрэглэгдэнэ.

I	<i>(Incomplete)</i> Хүндэтгэн үзэх шалтгаанаар явцын үнэлгээ (реферат, даалгавар, дадлагын ажил дутуу, явцын шалгалтанд орж чадаагүй гэх мэт) дутуу боловч шалгалтын хугацаанд нөхөн гүйцэтгэж, шалгуулах нөхцөлтэйгээр хэрэглэнэ.
E	<i>(Examine incomplete by student)</i> Хүндэтгэн үзэх шалтгаанаар улирлын шалгалтанд ороогүй бол багш энэ тэмдэглэгээг бичнэ.
NC	<i>(No Credit)</i> Багц цаг тооцохгүй бөгөөд уг хичээлийг суралцагч судалсан гэсэн тэмдэглэгээ. Кредит тооцуулахгүйгээр хичээл судлах зөвшөөрөл авч амжилттай судалсан тохиолдолд тавигдах тэмдэглэгээ юм.
CR	<i>(Credit granted)</i> Өөр сургуулийн багц цагийг шилжүүлэн тооцох үед энэ тэмдэглэгээг хийх ба дипломын хавсралтан дээр энэ хэвээрээ бичигдэнэ.
R	<i>(Repeat)</i> Тухайн хичээлийг амжилттай судалсан ч тодорхой шаардлагаар дахин судлах хүсэлт гаргасан бол суралцагчийн өмнөх үнэлгээний үсгээр илтгэсэн дүнг R болгож, дахин судлах боломжоор хангана.
W	<i>(Withdrew)</i> Хэрэв суралцагч хичээлийг цаашид судлах боломжгүй эсвэл хангалтгүй судалсан бол улирлын шалгалтаас 7 хоногийн өмнө өөрийн саналаар уг тэмдэглэгээг багшид хүсэлт гаргаж хийлгэнэ. Суралцагч чөлөө авсан, хасагдсан, гарсан тохиолдолд дүгнэгдээгүй хичээлийн дүнг системээс тавина. Дараа нь тус хичээлийг шинээр үзэх хичээлийн адил бүртгүүлж судална.
NA	<i>(grade Not yet Available)</i> Одоогоор дүгнэгдээгүй буюу судалж байгаа хичээлийн тэмдэглэгээ.
NR	<i>(No grade Reported)</i> Багш эцсийн үнэлгээг үнэлгээ тавих хугацааны дотор тавьж, системд оруулаагүй тохиолдолд мэдээллийн системээс автоматаар тавьсан тэмдэглэгээ.
S	<i>(Satisfactory)</i> “Тооцов” тэмдэглэгээ.
U	<i>(Unsatisfactory)</i> “Үл тооцов” тэмдэглэгээ.

Явцын болон улирлын шалгалтыг 1 удаа тус тус авч шалгагч багш дүнгээ шалгалт авсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор мэдээллийн системд оруулах үүрэгтэй.

Улирлын явцад хичээлд байнга идэвхтэй оролцсон, тухайн хичээлийн явцын шалгалтын бүх хэлбэрүүдэд амжилттай үнэлэгдсэн, үлгэр жишээч оюутанд уг хичээлийн улирлын шалгалтын үнэлгээг шууд тавихыг үгүйсгэхгүй бөгөөд уг асуудлыг багш суралцагчийн хамт олонд мэдэгдэн, ил тод шийднэ. Шууд дүгнэгдэх суралцагчийн тоо нийт шалгагдах суралцагчийн 10%-аас хэтрэхгүй байна.

Хүндэтгэх шалтгаангүйгээр улирлын шалгалтанд ирээгүй суралцагчид “F” буюу “хангалтгүй” үнэлгээ тавина. Харин хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол нотлох бичиг баримтыг үндэслэн “E”, “I” тэмдэглэгээг хийх ба суралцагч дараагийн улирлын эхний 1 сард багтаан шалгуулахгүй бол Элсэлт, бүртгэлийн хэлтсээс F дүн тавина.

Нэмэлт тэмдэглэгээ тавигдсан хичээлийн багц цагийг улирлын болон нийт голч оноо, голч дүнг бодоход хэрэглэхгүй.

Магистрын хөтөлбөрийн хувьд мэргэжлийн гадаад хэлний хичээлийн агуулгын шаардлагыг хангасан мэдлэгтэй суралцагч нь тухайн чиглэлээр шалгалт өгч дүйцүүлэн тооцуулж болно.

Магистр, докторын эрдэм шинжилгээний ажлын багц цагийг тооцох комиссыг бүрэлдэхүүн сургуулийн тэнхмийн эрхлэгч, тэнхимгүй бүтцийн хувьд хөтөлбөрийн удирдагчийн саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулж эрдэм шинжилгээний ажил, магистрын ажил, докторын диссертацийн дүнг сургалтын мэдээллийн системд тэнхмийн эрхлэгчид оноож үнэлгээг оруулна.

Дахин судлах хичээлийн үнэлгээ

Заавал судлах хичээлийг судалж, амжилтгүй дүн авсан, мөн “R”, “W”, “U”, “NR” үнэлгээний тэмдэглэгээтэй суралцагч тухайн хичээлийн багц цагийг биелүүлэхийн тулд дахин судална.

Суралцагч хичээлийг судалж, амжилттай үнэлгээ авсан ч тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвар, үнэлгээгээ ахиулах зорилгоор дахин судалж болно. Суралцах хугацаанд дахин судлах хичээлийн тоо 3 хүртэл байна.

Суралцагч судалж, дүгнэгдсэн хичээлээ дахин судлах тохиолдолд, Элсэлт, бүртгэлийн хэлтэсд хүсэлтээ гаргаж, сургалтын мэдээллийн системд өмнөх үнэлгээг “R” болгож тэмдэглүүлнэ. “R” үнэлгээ тавиулсан тохиолдолд өмнөх дүнг хүчингүй болгох бөгөөд буцаах боломжгүй.

СУРАЛЦАГЧ ЧӨЛӨӨ АВАХ

Суралцагч хүндэтгэн үзэх шалтгаанаар 21 хоногоос богино хугацаагаар чөлөө авах бол багшийн зөвшөөрлийг үндэслэн Элсэлт, бүртгэлийн хэлтэс шийдвэрлэх ба 3 долоо хоногоос дээш хугацаагаар хичээлд сууж чадахгүйд хүрвэл, Элсэлт, бүртгэлийн хэлтэсд улирлын чөлөө авах тухай хүсэлтээ бичгээр гаргаж сургалтын мэдээллийн системд суралцагчийн төлвийг Элсэлт, бүртгэлийн хэлтэс өөрчилж сонгосон хичээлийг цуцална.

Нэг удаагийн чөлөөний хугацаа 2 хүртэл улирал байж болно. Суралцагчийн суралцах хугацаанд олгох чөлөөний нийт хугацаа 2 жилээс хэтрэхгүй байна.

СУРАЛЦАГЧ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН СУРАЛЦАХ

Чөлөөний хугацаа дууссан суралцагч улирлын хичээл эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө үргэлжлүүлэн суралцах өргөдлөө Элсэлт, бүртгэлийн хэлтэсд өгч шаардлагатай төлбөрийг төлсний үндсэн дээр бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар үргэлжлүүлэн суралцах эрх нээгдэж сургалтын мэдээллийн системд Элсэлт, бүртгэлийн хэлтэс суралцагчийн төлвийг өөрчлөнө.

Улирлын чөлөөг дуусгаад ирсэн болон бусад шалтгаанаар сургалтын хугацаа хойшлон суралцаж байгаа суралцагч сургалтын төлөвлөгөөний өөрчлөлтөөс болж хичээл, хөтөлбөрийн түвшин, шалгалтын зөрүү гарвал үргэлжлүүлэн суралцах болсон шалтгаан, өмнө нь авч байсан дүнг харгалзахгүйгээр нөхөн үзэх хичээл, өгөх шалгалтыг Элсэлт, бүртгэлийн хэлтэс, тэнхмийн эрхлэгч/хөтөлбөрийн удирдагч нар хамтран тогтооно.

Хоёр улирал дараалан идэвхгүй төлөвт байгаа суралцагч Элсэлт, бүртгэлийн хэлтэсд үргэлжлүүлэн идэвхтэй төлөвт суралцах хүсэлт гаргах ба идэвхгүй суралцсан хугацааны суурь үйлчилгээний төлбөрийг нөхөн төлнө/Тухайн суралцаж байсан хугацааны/.

СУРГУУЛИАС ЧӨЛӨӨЛӨГДӨХ

Суралцагч сургуулиас чөлөөлөгдөх тухай хүсэлтийг Элсэлт, бүртгэлийн хэлтэсд гаргасан тохиолдолд сургуулиас бүрмөсөн чөлөөлөх МУИС-ийн захирлын тушаал гарна.

Суралцагчийг дараах шалтгаанаар бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн шийдвэрээр МУИС-ийн захирлын тушаалаар сургуулиас хасна. Үүнд:

- Чөлөөний хугацаа дуусаад хичээлд бүртгүүлээгүй, эсвэл чөлөөг сунгах хүсэлт гаргаагүй,
- 4 улирал сургалт, судалгааны ажилд оролцоогүй,
- Суралцах үлдсэн хугацаанд нийт багц цагийг амжилттай цуглуулах боломжгүй болсон,
- Эзэмшсэн мэдлэг, чадвараа үнэлүүлэхдээ хуурч мэхлэх, дүнгийн тодорхойлолтыг хуурамчаар үйлдэх зэрэг зөрчил гаргасан,
- Гэмт хэрэг, ёс суртахууны ноцтой зөрчил гаргасан нь хууль, хяналтын байгууллагаар тогтоогдсон.

Суралцагч сургуулиас хасагдах тохиолдолд өөрт нь албан ёсоор мэдэгдэх ба ямар ч төлбөрийг буцааж олгохгүй. Сургуулиас хасагдах нөхцөл бүрдсэн бөгөөд холбоо барих боломжгүй тохиолдолд сургуулиас хасна.

ТӨГСӨГЧДӨД ТАВИХ ШААРДЛАГА, ХҮСЭЛТ ГАРГАХ

Бакалаврын сургалтын төлөвлөгөөн дэх 121-оос доошгүй багц цаг цуглуулсан, сургууль/салбар, тэнхмээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн оюутанд дээд боловсролын бакалаврын зэрэг олгож төгсгөнө. Үүнд:

Бакалаврын хөтөлбөрийн төгсөгч нь англи хэлний ахисан дунд (upper intermediate) түвшний мэдлэг эзэмшсэн байх бөгөөд TOEFL, IELTS-ийн харгалзах түвшний онооноос

дээш оноотой байна.

Бакалаврын сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийг бүрэн, мөн мэргэжлийн зарим хичээлүүдийг судалж 90-ээс (ХЗС 120) доошгүй багц цаг цуглуулан, хүндэтгэх шалтгааны улмаас төгсөх хүсэлт гаргасан оюутанд дээд боловсролын дипломын зэрэг олгож болно. Дипломын зэргээр төгсөгч нь төгссөнөөсөө хойш 3 жилийн дотор тухайн мэргэжлээр элсэлтийн шалгалтгүйгээр үргэлжлүүлэн суралцаж, багц цагаа амжилттай судалж гүйцээн журмын дагуу бакалаврын зэрэг авч болно.

Төгсөгч хавсарга эсвэл хос мэргэжлээр суралцах тохиолдолд сургууль/салбар, мэргэжлийн тэнхмээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн байна. Хос мэргэжлээр амжилттай суралцсан оюутанд давхар суралцсан мэргэжлийн хоёр дахь бакалаврын диплом олгоно.

Магистрын ажлын хамгаалалтын өмнөх хэлэлцүүлгийг тэнхмийн эрдэм шинжилгээний өргөтгөсөн семинарт хийнэ. Өргөтгөсөн семинараас дүгнэлт гаргаж, хуралдааны протоколын хамт бүрэлдэхүүн сургуулийн Элсэлт, бүртгэлийн хэлтэсд хүргүүлнэ. Семинарын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийж магистрын ажлыг магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаална.

Магистрын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийг бүрэн судалж, сургууль/салбар, тэнхмээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн, мэргэжлийн магистрын хувьд 32, судалгааны магистрын хувьд 30-аас доошгүй багц цуглуулсан суралцагчийг дээд боловсролын магистрын зэргээр төгсгөнө.

Докторант сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, докторын зэрэг горилсон диссертацийн ажлаа тэнхим, бүрэлдэхүүн сургууль/салбар, мэргэжлийн эрдэмтдийн өргөтгөсөн семинарт урьдчилан хэлэлцүүлсэн тухай дүгнэлт гарган докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд уламжилна. Семинарын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийнэ. Семинараас диссертацид мэргэжлийн дүгнэлт хийж, хуралдааны протокол гаргах ба энэ нь докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд МУИС-аас гаргаж өгөх дүгнэлтийн нэг үндэслэл болно.

Докторын диссертацийг монгол хэлээр бичнэ. Диссертацийн тухай товч танилцуулгыг англи хэлээр 3 хуудаст багтаан бичиж, диссертацийн эцэст хавсаргана. Горилогчийн хүсэлт, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн дийлэнх олонхийн зөвшөөрснөөр диссертацийн ажлыг англи хэлээр бичүүлж, хамгаалалтыг англи хэлээр явуулж болно. Энэ тохиолдолд диссертацийн тухай товч танилцуулгыг монгол хэлээр бичнэ.

Бакалаврын судалгааны ажил, магистрын судалгааны ажил, докторын диссертацийг захирлын тушаалаар батлагдсан загварын дагуу бичиж, хэвлүүлнэ.

Докторын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийг бүрэн судалж, сургууль/салбар, тэнхмээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн, 60-аас доошгүй багц цуглуулсан, докторын диссертация амжилттай хамгаалсан суралцагчийг дээд боловсролын докторын зэргээр төгсгөнө.

Бакалаврын зэрэг горилогчийн суралцсан хугацааны голч дүн 1.8 ба түүнээс их, магистр, докторын зэрэг горилогчийн суралцсан хугацааны голч дүн 2.3 ба түүнээс их байна.

Төгсөгч нь сургалтын төлбөрийн болон бусад тооцоогүй байна.

Төгсөх хүсэлт гаргах

Төгсөлт жилд хоёр удаа хавар, намрын улиралд явагдах ба төгсөгчид тавих шаардлагыг бүрэн биелүүлэх боломжтой суралцагч төгсөх хүсэлтээ сургалтын мэдээллийн системээр дамжуулан төгсөх улирлын 6-10 дугаар долоо хоногт багтааж Элсэлт, бүртгэлийн хэлтэсд гаргана.

Хүндэтгэн үзэх шалтгаанаар хүсэлт гаргах хугацаанаас хоцорсон суралцагчийн төгсөх тухай асуудлыг Элсэлт, бүртгэлийн хэлтсийн саналыг үндэслэн төгсөлтийн салбар комисс шийдвэрлэж төгсөх боломжтой гэдгийг нь төгсөлтийн үйл явц, ёслолын үйл ажиллагааны талаарх мэдээллийн хамт, эсвэл төгсөхөд дутуу хангагдсан байгаа шаардлагуудын талаар суралцагчид мэдэгдэнэ.

Суралцагч төгсөх хүсэлт гаргасан улиралдаа төгсөж чадаагүй бол төгсөх тухай хүсэлтийг дараагийн улиралд дахин гаргаж болно.

Төгсөлтийн бичиг баримт

Амжилттай сурч, дээд боловсролын бакалавр, магистр, докторын зэргийн болзол хангасан суралцагчийн төгсөлтийн салбар комиссын шийдвэрийг үндэслэн, МУИС-ийн захирлын тушаалаар төгсгөн, мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг болох диплом, энгэрийн тэмдэг олгоно.

Магистр, докторын зэргийн диплом нь МУИС-ийн удирдах зөвлөлийн дарга, МУИС-ийн захирал, хамгаалуулах зөвлөлийн дарга, төгсөлтийн дараах сургуулийн захирлын гарын үсэг, МУИС-ийн тамга тэмдгээр баталгаажих ба (мэргэжлийн магистрын хувьд хамгаалуулах зөвлөлөөр орохгүй тул даргын гарын үсэг шаарлагагүй) дугаар, бүртгэлийн дугаартай байна.

Диплом хавсралттай байх ба хавсралтанд эзэмшсэн үндсэн болон хавсарга мэргэжил, гүнзгийрэн судалсан чиглэл, суралцах хугацаанд амжилттай судалсан хичээлүүд, тэдгээрийн багц цаг, голч дүн ба оноог бичихээс гадна эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрт нийцүүлэн бусад бичиглэлийг хийж болно. Хавсралтыг МУИС-ийн Элсэлт, бүртгэлийн хэлтсийн дарга, Хөтөлбөр, чанарын баталгаажуулалт хэлтсийн даргын гарын үсэг, тамга/тэмдгээр баталгаажуулна.

Үндсэн чиглэлээсээ гадна хавсарга мэргэжлээр суралцсан тохиолдолд боловсролын давхар зэрэг, диплом олгохгүй.

Бакалаврын оюутны хувьд суралцах дээд хугацаанд судалбал зохих хичээлийг бүрэн судалсан ч суралцсан хугацааны голч дүн 1.8-аас доош оюутанд МУИС-ийн тухайн мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд заагдсан бүх хичээл судалсаныг гэрчилсэн тусгай бичиг баримт олгож болно.

Магистрант, докторант сургалтын багц цагаа хугацаандаа цуглуулсан боловч

магистрын ажил, диссертаци бичих багц цагаа биелүүлж амжаагүй бол МУИС-ийн магистр/докторын сургалт дүүргэсэн тухай захирлын тушаал гаргаж, гэрчилгээ олгоно. Магистрант оюутны сургалтын багц цаг энэхүү гэрчилгээг авснаас хойш 3 жил, докторант оюутны сургалтын багц цаг энэхүү гэрчилгээг авснаас хойш 5 жил хүчинтэй байх ба энэ хугацаанд эрдэм шинжилгээний багц цагаа гүйцээн магистрын ажил, докторын диссертаци бичиж хамгаалах эрхтэй байна.

Төгсөлтийн салбар комисс сургуулийн архивт төгсөж байгаа суралцагчтай холбоотой дараах материалыг бүрдүүлж өгнө. Үүнд:

- Төгсөлтийн салбар комиссын хурлын шийдвэр (загварыг сургалтын төв албанаас гарган мөрдүүлнэ)
- Төгсөгчдөд диплом олгосон бүртгэлийн хуулбар (мэргэжлийн хөтөлбөрөөр)
- Хамгаалуулах зөвлөлийн хуралдааны протокол, тогтоол
- Удирдагчийн тодорхойлолт
- Суралцсан хугацааны тодорхойлолт
- Дипломын хуулбар
- Сурлагын дүнгийн эх хувь (дипломын хавсралт) -1 ширхэг
- Дэлгэрэнгүй анкет (1-р маягт)
- Суралцагчийн үнэмлэх
- Тойрох хуудас

Магистрын ажил, диссертацийг үндэсний номын сан, мэдээллийн технологийн үндэсний парк, сургуулийн номын санд хүлээлгэн өгнө.

Төгсөлтийн баримт бичгийг үрэгдүүлсэн тохиолдолд архивын материалыг үндэслэн зөвхөн дипломыг нөхөн олгох бөгөөд үүнийг тусгай журмаар зохицуулна. Харин комиссын буруутай үйл ажиллагааны улмаас диплом дахин олгох асуудлыг тухайн үед мөрдөгдөж буй дүрэм, журамд нийцүүлэн төгсөлтийн хугацаанд шийдвэрлэнэ.

СУРГАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

Багц цагийн төлбөр нь сургалттай холбоотой шууд зардлаас бүрдэнэ. Энэ нь оюутны сурах үйл ажиллагаанд шууд холбоотой сургалтын үйлчилгээ бөгөөд багш профессорууд, мэргэжилтэн, зааварлагчдын цалин хөлс, үйл ажиллагааны зардал, хээрийн болон үйлдвэрлэлийн дадлага, сургалтын үйлчилгээний ажилчдын цалин хөлс, хичээл практик, эрдэм шинжилгээний хурал семинарын зардал, оюутны академик үйлчилгээ, оюутны тэтгэлэг, олимпиад, оюутны дунд зохиогддог бүх төрлийн уралдаан тэмцээний зардал, гадаад багш болон багшийн үйл ажиллагаа, хөгжлийг дэмжих зардал, интернэт, сургалтын тоног төхөөрөмж, эд хогшлын зардал зэргийг санхүүжүүлнэ.

Магистрант, докторантын эрдэм шинжилгээний ажлын багц цагийн төлбөр нь лаборатори, судалгааны тоног төхөөрөмжийн зардал, лабораторийн ажилтны зардал, эрдэм шинжилгээний хурал, семинарын зардал, магистрант, докторантын судалгааны ажлын хэлэлцүүлэг, санал, зөвлөмж өгсөн эрдэмтдийн ажлын хөлс зэргийг санхүүжүүлнэ.

Багц цагийн төлбөр нь бүрэлдэхүүн сургууль, салбар, хөтөлбөр, түвшингээрээ өөр өөр байж болно.

Хос, хавсарга хөтөлбөрөөр суралцах оюутан сургалтын багц цагийн төлбөрийг тухайн хос, хавсарга хөтөлбөрийг хэрэгжүүлж буй бүрэлдэхүүн сургуульд, үндсэн мэргэжлийн сургалтын багц цагийн төлбөрийг үндсэн мэргэжлээр суралцаж буй сургуульд төлнө.

Нөхцөлтэй элсэн суралцагч нь бакалаврын түвшний хичээл судалбал бакалаврын түвшний багц цагийн төлбөр, магистрын түвшний хичээл судалбал магистрын багц цагийн төлбөр төлнө.

Оюутан магистрын түвшний хичээл судалбал магистрын түвшний багц цагийн төлбөр, магистрант докторын түвшний хичээл судалбал докторын багц цагийн төлбөр төлнө. Магистрант, докторант нь өөр өөрийн хөтөлбөрт заасан хичээлийг хамтдаа судалбал өөр өөрийн түвшний багц цагийн төлбөр төлнө.

Суралцагчийн дүйцүүлсэн багц цагийн төлбөрийг авахгүй.

Суралцагч сургалтын төлбөрөөс гадна төгсөлт, дотуур байр болон бусад нэмэлт үйлчилгээтэй холбоотой төлбөр, хураамжийг тухай бүр төлнө.

Суралцагчаас авах сургалтын үйлчилгээтэй холбоотой төлбөр, хураамжийн хэмжээг санхүү, эдийн засгийн хэлтсээс боловсруулж хичээлийн жил эхлэхээс өмнө МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулан мөрдүүлнэ. Сургалт, үйлчилгээний төлбөрийн дэлгэрэнгүйг МУИС-ийн веб сайтын дүрэм журмын хэсгээс харна уу

СУРГУУЛИАС ОЛГОХ АЛБАН БИЧИГ БАРИМТ, ЛАВЛАГАА

МУИС-ийн бүрэлдэхүүн сургуульд суралцагчаар элсүүлэх тухай захирлын тушаал гарсны дараа элссэн суралцагчдад суралцагчийн үнэмлэхийг үнэ төлбөргүй олгоно. Үнэмлэхээ гээсэн, үрэгдүүлсэн, хулгайд алдсан тохиолдолд зохих төлбөрийг төлж нөхөн авч болно.

Амжилттай сурч, дээд боловсролын бакалавр, магистр, докторын зэргийн болзол хангасан суралцагчийг төгсөхөд тухайн боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх баримт бичиг, энгэрийн тэмдэг олгоно. Дипломын хавсралт дахь дүнгийн жагсаалтад суралцагчийн хангалтгүй судалсан хичээлийн дүнг оруулахгүй.

МУИС-ийн суралцагч мөн болох тухай, суралцаж байх үеийн дүнгийн албан ёсны тодорхойлолтыг суралцагчийн үнэмлэх, Си Си мэдээллийн системд нэвтрэх нууц үгээ ашиглан Түргэн үйлчилгээний цэгийн /ТҮЦ/ машинаас монгол, англи хэлээр үнэт цаасан дээр авч болно. Суралцагчийн болон дүнгийн тодорхойлолтыг тухайн хичээлийн жилд тус бүр 2 удаа үнэ төлбөргүй авах ба үүнээс дээш тоогоор авах тохиолдолд тухай бүр 500 төгрөгийн хураамж төлнө. Уг тодорхойлолт нь тухайн улиралдаа хүчинтэй.

Дүнгийн албан бус тодорхойлолтыг суралцагч Си Си мэдээллийн системээс төлбөргүй авч болно.

Суралцагчийн лавлагаа, тодорхойлолтын загварыг Элсэлт, бүртгэлийн хэлтсээс батлах бөгөөд дараах хугацаанд олгоно.

Бичиг баримтын нэр, төрөл	Олгох алба	Хугацаа
МУИС-ийн суралцагч мөн болох тухай, дүнгийн албан ёсны тодорхойлолт	Элсэлт, бүртгэлийн хэлтэс	Ажлын 1 хоногт
	ТҮЦ машин	Тухай бүр

Суралцаж байсан үеийн дүнгийн албан ёсны тодорхойлолт	Элсэлт, бүртгэлийн хэлтэс	Ажлын 3 хоногт
Төгссөн тухай тодорхойлолт, дипломын хавсралт дахь дүнгийн албан ёсны магадлагаа	Элсэлт, бүртгэлийн хэлтэс	Англи хэл дээр бол ажлын 3, монгол хэл дээр бол ажлын 1 хоногт
Суралцагчийн үнэмлэх хаяж гээгдүүлсэн тохиолдолд нөхөн авах	Элсэлт, бүртгэлийн хэлтэс	Ажлын 5 хоногт
Диплом нөхөн олгох	Элсэлт, бүртгэлийн хэлтэс	Ажлын 10 хоногт

Албан ёсны бүх бичиг баримтыг олгохдоо зохих хэмжээний хураамж авна

ОЮУТНЫ ХҮСЭЛТ, САНАЛ ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВАХ, БАРАГДУУЛАХ

Оюутан та сургалт болон бусад үйл ажиллагаатай холбоотой зарлал, зөвлөмж мэдээ, мэдээллийг веб сайт (<http://news.num.edu.mn>), facebook хуудас (МУИС), мобайл аппликейшн болон өөрийн суралцаж буй бүрэлдэхүүний сургуулийн зааварлагч нараас авч болно.

Хичээл сонголт, дүнтэй холбоотой асуудлаар хандах бол Элсэлт, бүртгэлийн хэлтсийн тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтнээс тодруулна. Таны хүсэлт, санал гомдлын хариу МУИС-ийн төв удирдлага эсвэл Элсэлт, бүртгэлийн хэлтсээс гарах шаардлагатай бол таны сурч буй сургуулийн сургалтын алба уг асуудлыг дамжуулж хариуг авч оюутанд мэдэгдэнэ.

- **“R” үнэлгээний хүсэлт гаргах (хичээл дахин судлах) маягт** /Суралцагч судалж, дүгнэгдсэн хичээлээ дахин судлах тохиолдолд, Элсэлт, бүртгэлийн хэлтэсд хүсэлтээ гаргаж, сургалтын мэдээллийн системд өмнөх үнэлгээг “R” болгож тэмдэглүүлнэ. “R” үнэлгээ тавиулсан тохиолдолд өмнөх дүнг хүчингүй болгох бөгөөд буцаах боломжгүй./

- **Дүнгийн маргаан, гомдол барагдуулах хүсэлтийн маягт** /Суралцагч хичээлийн дүнгийн гомдолтой бол тухайн хичээлийг судалсны дараагийн улирлын эхний 1 сар дотор Элсэлт, бүртгэлийн хэлтэсд хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлнэ. Шаардлагатай тохиолдолд бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулж шийдвэрлүүлнэ./

- **Хожимдсон бүртгэл хийлгэх хүсэлтийн маягт** /Хүндэтгэн үзэх шалтгаанаар заасан хугацаанд хичээлдээ бүртгүүлж амжаагүй суралцагч тухайн улирлын эхний 7 хоногт багтан бүртгүүлэх боломжтой хичээлд бүртгэлийн хураамж төлж бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж нь тухайн хичээлийн 1 багц цагийн төлбөртэй дүйцэхүйц байна/

- **Хичээл цуцлуулах хүсэлтийн маягт** /Улирлын хичээл эхэлснээс хойш, сургалтын төлөвлөгөөн дэх тухайн хичээлийн цагийн 30 хувь өнгөрөөгүй байхад баталгаажуулсан хичээлээ цуцлах тохиолдолд хичээлийн багц цагийн төлбөрийн 70 хувийг дараагийн улиралд бүртгүүлэх хичээлийн багц цагийн төлбөрт шилжүүлнэ. Хичээлийн цагийн 30-аас дээш хувь өнгөрсөн бол багц цагийн төлбөрийг буцааж олгохгүй/


- **Чөлөөт сонголтын хичээл нэмүүлэх хүсэлтийн маягт** /Суралцагч хичээлийн хуваарийг үндэслэн улирал эхлэхээс өмнөх долоо хоногт хичээлд бүртгүүлэх ба бүртгүүлсэн хичээлийн багц цагийн төлбөрийг цахим хэлбэрээр төлж, баталгаажуулна/

IV БҮЛЭГ СИСИ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

СиСи систем нь МУИС-ийн сургалт үйл ажиллагаанд хэрэглэдэг систем юм. Энэхүү системийн зорилго нь МУИС-ийн сургалт, удирдлага, зохион байгуулалттай холбоотой үйл ажиллагааг хөнгөвчлөх, чанаржуулах, шуурхай, найдвартай, ил тод, хяналттай болгох явдал юм. Энэхүү системийг МУИС-ийн салбар сургуулиудын багш ажилтан, оюутан болон удирдлагууд хэрэглэх ба систем нь МУИС-ийн хүрээнд хэрэглэгддэг системүүд болон бусад гадны системүүдтэй хамтарч ажиллана.

СиСи систем нь вэбд суурилсан, монгол ба англи хэл дээр ашиглах боломжтой бөгөөд диплом, дипломын хавсралтыг англи, кирилл, монгол бичгээр хэвлэхтэй холбоотойгоор монгол бичгийг дэмжинэ.

Элсэлтээс төгсөлт хүртэлх сургалтын бүхий л үйл ажилгаа уг системээр дамжиж явагдана.



SiSi системийн хэрэглэгч бүр системд **нэвтрэх нэр, нууц үгтэй** байх ба нэвтрэх нэр МУИС-ийн хэмжээнд давтагдахгүй оюутны хувийн дугаар байна.




Оюутан та нэвтрэх нэр буюу хувийн дугаараа өөрийн сургуулийн сургалтын албаны ажилтнаас авна уу.

Оюутны дугаар нь элссэн он, суралцаж буй түвшин, төрөл, салбар сургууль гэх мэт мэдээллийг агуулдаг. Жишээ нь: Оюутны дугаар 20B1NUM0000 бол


- 20 - 2020 оны элсэлт
- В - Бакалавр
- 1 - Өдрийн анги
- NUM- МУИС
- 0000 - давтагдахгүй дугааргэх мэт.

Нэвтрэх нууц үг нь оюутны төрсөн он сар өдрөөр үүсдэг. Жишээ нь: 1990 оны 1-р сарын 1нд төрсөн бол таны нууц үг 19900101 гэж үүсэх болно.




Хувийн мэдээлэл

Оюутан та энэ хэсгээс өөрийн **хувийн мэдээллийг харах, засах, нууц үг солих, нууцлалт хамгаалалтыг хэрхэн хийх** талаарх зааврыг авах болно. Туслах хэсэг нь системийн баруун дээд хэсэгт байрлах өөрийн нэр бүхий хэсгийн суман дээр дарснаар гарч ирнэ.



Оюутан та энэ хэсгээс МУИС-ийн бүх **хөтөлбөр, хичээлийн хуваарь, багш ажилчдын мэдээлэл, хичээлийг** харахаас гадна **форум буюу онлайн хэлэлцүүлэгт** оролцох боломжтой. Эдгээр мэдээллүүдийг системийн дээд хэсэгт байрлах хэсгээс харна

А. Хөтөлбөр. Та системийн дээд хэсэгт байрлах Хөтөлбөр хэсгээс МУИС-ийн бүх хөтөлбөр болон төлөвлөгөөний талаарх мэдээллийг авах болно.



Гарч ирэх хэсгийн зүүн талд байрлах МУИС-ийн бүтэц/нэгж дээр дарахад тухайн нэгжид харъяалагдах бүх хөтөлбөрийн жагсаалт гарч ирэх бөгөөд хөтөлбөрийн жагсаалтаас хайлт хийх, тухайн баганын утгаар эрэмбэлэх, тухайн хөтөлбөрийн төлөвлөгөөг харах боломжтой байна.

Хөтөлбөрүүд

Монгол Улсын Их Сургууль

Бүрэлдэхүүн/Салбар сургуулиуд

- Бизнесийн сургууль
- Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль
- Хууль зүйн сургууль
- Харгалзвэний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль**
- Захирагаа
- Сургалтын алба
- Харгалзвэний м
- Электроник, холбооны инженерчлэлийн тэнхим
- Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим
- Хүрээлэн буй орчин судлал, хилийн инженерчлэлийн тэнхим
- Шинжлэх ухааны сургууль
- Завхан сургууль
- Орхон сургууль
- Байгаль-Эх Лицей Ахлах Сургууль, Экологийн Болосролын Төв
- Бие даасан нэгжүүд

Өдрийн сургалт -> Бакалавр +

Шүүлт хийх

Тусламж

Академик түвшин

- ★ - Бүрэн дунд
- ★★ - Хэний багтаал
- ★★★ - Диплом
- ★ - Бакалавр
- ★★ - Магистр
- ★★★ - Доктор
- 📄 - Сургалтын төлөвлөгөө харах

Хуудсанд 10 -н бичлэг

Хайх: эле

Нэгжийн нийт хөтөлбөрөөс хайлт хийх

Түвшин	Хэлбэр	Хөтөлбөрийн нэр	Хуудасны дугаарлалт
★	Өдрийн сургалт	Электроник, автоматик (D521300) (МУИС, Хуаус)	📄
★	Өдрийн сургалт	Электроник, автоматик ба Мультимедиа, холбооны технологи (D521300,D522300) (МУИС, Хуаус)	📄
★	Өдрийн сургалт	Электрон системийн автоматжуулалт (D071401) (МУИС, Хуаус)	📄

Тухайн багана дээр дарахад баганын утгаар эрэмбэлэх

Тухайн нэгжид харъяалагдах нийт хөтөлбөрийн жагсаалт

Тухайн хөтөлбөрийн төлөвлөгөөг харах

Хуудасны дугаарлалт

Б. Хичээл. Та системийн дээд хэсэгт байрлах Хичээл хэсгээс МУИС-ийн бүх хичээлийн талаарх мэдээллийг авах боломжтой.

Гарч ирэх хэсгийн зүүн талд байрлах МУИС-ийн бүтэц/нэгж дээр дарахад тухайн нэгжид харъяалагдах бүх хичээлийн жагсаалт гарч ирэх бөгөөд хичээлийн жагсаалтаас хайлт хийх, тухайн баганын утгаар эрэмбэлэх, хичээлийн дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой байна.

Хичээлийн жагсаалт

Монгол Улсын Их Сургууль

- Захиргааны нэгжүүд
- Бурхадзүүн/Салбар сургуулиуд
- Бизнесийн сургууль
- Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль
- Жууль зүйн сургууль**
- Захиргаа
- Сургалтын алба
- Нийтийн эрх зүйн тэнхим
- Практик сургалтын төв
- Солонгосын боловсролын төв
- Хувийн эрх зүйн тэнхим
- Японы эрх зүйн боловсролын төв
- Хэрэглээн шилжилх ухаан, инженерчлэлийн сургууль
- Шилжилх ухааны сургууль
- Завхан сургууль
- Орхан сургууль
- Байгаль-Эх Лицей Ахлах Сургууль, Экологийн Боловсролын Төв
- Бие даасан нэгжүүд

Академик түвшин

- ★ - Бирэн дунд
- ★★ - Хэлний бэлтгэл
- ★★★ - Диплом
- 📄 - Дэлгэрэнгүй мэдээлэл харах
- ★ - Бакалавр
- ★★ - Магистр
- ★★★ - Доктор

Харуулах мөрийн тоо: 10 Хайс:

#	Түвшин	Индекс	Хичээлийн нэр		
1	★	POL1309	Олон улсын нийтийн эрх зүй (Нийтийн эрх зүйн тэнхим)		📄
2	★	POL1355	Захиргааны эрх зүй (Нийтийн эрх зүйн тэнхим)		📄
3	★	JRIS102	Эрх зүйн онол (Нийтийн эрх зүйн тэнхим)		📄
4	★	JRIS101	Ромын эрх зүй (Нийтийн эрх зүйн тэнхим)		📄
5	★	JRIS-401	Гадаад орнуудын төр, эрх зүйн түүх (Нийтийн эрх зүйн тэнхим)		📄
6	★	JRIS104	Төрийн онол (Нийтийн эрх зүйн тэнхим)		📄
7	★	JRIS-402	Эрх зүйн философи (Нийтийн эрх зүйн тэнхим)		📄
8	★	PLAW201	Монгол улсын төрийн /үндсэн хуулийн/ эрх зүй (Нийтийн эрх зүйн тэнхим)		📄
9	★	CLA-202	Монгол улсын иргэний эрх зүй /ерөнхий анги/ (Хувийн эрх зүйн тэнхим)		📄
10	★	CRLA-203	Монгол улсын эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/ (Нийтийн эрх зүйн тэнхим)		📄

Нийт 859 өгөгдлийн 1 - 10

Хуудасны дугаарлалт

В. Хичээлийн хуваарь. Та энэ хэсгээс өөрийн хичээлийн хуваарийг нийт улирлаар эсвэл тухайн өдрийн оролтоор харахаас гадна болон МУИС-ийн нийт хуваарийг харах болно.

Хуваарийг дараах хэлбэрээр харах боломжтой. Үүнд:

Оролтоор: Та системийн дээд хэсэгт байрлах *Хичээлийн хуваарь -> Оролтоор* хэсгээс МУИС-ийн салбар сургууль тус бүрийн бүх түвшний хичээлийн хуваарийг тухайн өдөр буюу оролтоор хичээл, багш болон өрөө хэлбэрээр харах боломжтой.

Бизнесийн сургууль (МУИС, Бс)

Автоматаар сонгогдох

Хичээлээр Багшаар Өрөөгөөр 7 хоногоор Өөрийн хуваарь ?

Өнөөдөр

Бүгд - Бакалавр, Магистр, Доктор ...

2014/06/20 -н өдрийн хичээлийн хуваарь

Нэрс	9:0	9:45	10:40	11:25	12:10	13:5	14:0	14:45	15:40	16:25	17:20	18:5	19:0	19:45	20:40	21:25	22:20	23:5
Энэ өдөр хуваарь оноогоогүй байна	9:45	10:30	11:25	12:10	12:55	13:40	14:25	15:10	16:00	16:25	17:10	18:5	18:50	19:45	20:30	21:25	22:10	23:50


Тухайн өдрийн хуваарийг харуулах

Тухайн сургуулийн, тухайн өдрийн, тухайн түвшний хичээлийн хуваарийг харахдаа МУИС-ийн салбар сургуулиудаас сонгон, хэдний өдрийн хичээлийн хуваарийг харахаа сонгоно. Мөн энэ хэсгээс тухайн хичээлийг орж байгаа багшийн мэдээлэл, өрөөний мэдээлэл болон хичээлийн мэдээллийг харах боломжтой юм.

Улирлаар: Та системийн дээд хэсэгт байрлах **Хичээлийн хуваарь** -> **Улирлаар** хэсгээс өөрийн хичээлийн хуваарийг нийт улирлаар харахаас гадна Excel рүү хөрвүүлэн татаж авах боломжтой.


	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
07:40 - 08:25		Лаб Хич-3а Интеррайсийн техник 22 / 25	Лекц Хич-3а Удирдлагын систем Зориг.Б 20 / 23	Лекц Хич-3а Удирдлагын систем Баярпүрэв.М	Семинар Хич-3а Электроник ба Антени 15 / 25	Дадлага Судалгаа Хич-0 Удварлалын дадлага 26 / 150	0
08:25 - 09:10						Бямбажав.Д	
09:20 - 10:05			Лаб Хич-3а Удирдлагын систем 20 / 23				
10:05 - 10:50							
11:00 - 11:45		Лекц Хич-3а Интеррайсийн техник 22 / 25	Зориг.Б				
11:45 - 12:30				Лаб Хич-3а Өгөгдлийн сан ба вэб программчлал 24 / 25	Уйтуман.Ж		
12:40 - 13:25					Лекц Хич-3а Энбээдэд систем 22 / 30	Лодойржавсал.М	
13:25 - 14:10							

Мөн тухайн өдрийн, тухайн цаг дээрх хуваарь дээр дарснаар хуваарь болон багшийн дэлгэрэнгүй мэдээлэл гарч ирэх болно.



1. НҮҮР ХУУДАС


Системийн нүүр хуудсанд оюутан таны ерөнхий мэдээлэл, тухайн улиралд судалж буй хичээлүүд, мэдээ мэдээлэл, гарын авлагын хамт байрлана.



- Таны ерөнхий мэдээллүүд алдаатай/буруу байвал Туслах -> Хувийн мэдээлэл -> Хувийн мэдээлэл засах хэсгийн зааврыг үзэн шаардлагатай мэдээллүүдийг засах боломжтой.
- Мэдээ хэсэгт хичээл баталгаажуулалт, санал өгөх, шалгалтын хуваарь тавигдсан гэх мэт системийн зүгээс илгээж буй мэдээллүүдээс гадна багш, ажилчдаас таньд илгээсэн мэдээллүүд гарч ирнэ.
- Гарын авлагын хэсгийн зааврын нэр дээр дарснаар системийн болон бусад мэдээлэл, зааврыг авах боломжтой.
- Та тухайн улиралд судалж буй хичээлүүдийнхээ мэдээлэл болон хуваарийг харах, цахим журнал ашиглах, санал асуулгад оролцох боломжтой.

А. Хичээлийн мэдээлэл харах

Тухайн хичээлийн мэдээллийг харахдаа хичээл дээр даран гарч ирэх хэсгээс Хичээлийн мэдээлэл товчийг дарна.



Б. Хичээлийн мэдээлэл товчин дээр дарснаар тухайн хичээлийн дэлгэрэнгүй мэдээлэл гарч ирэх болно.

Хичээлийн мэдээлэл

Сургууль:	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль (МУИС, Хшуис)
Хичээлийн нэр:	CSSW223-Объект хандлагат програмчлал (3кр)
Кредит:	3 кредит
Үргэлжлэх хугацаа:	16 долоо хоног
Долоо хоногт орох цаг:	Лекц: 2 цаг Семинар: 0 цаг Дадлага: 3 цаг Бие даалт: 4 цаг
Урьдчилан үзэх хичээлүүд:	CSSW111-Програмчлалын хэл Си (3кр) CSSW102-Алгоритм ба Си хэл (3кр)
Залгамж хичээлүүд:	Виндоус програмчлал
Тодорхойлолт хийгдсэн:	2007 Намрын улирал

Зорилго

Объект хандлагат програмчлал хичээлээр дараах сэдвүүдийг авч үзнэ. Үүнд: Объект хандлагат програмчлал тухай, C ба C хэлний ялгаа. Inline функц Класс ба Объект Байгуулагч ба устгагч функц Удамшлын тухай, түүний төрлүүд Статик өгөгдөл, Статик функц Найз функц ба ангилал Операторыг дахин тодорхойлох Объект ба санах ой Загвар функц ба ангилал, стандарт ангиллын сан Орлолт гаралт функц UML(unified modeling language)-ийн талаарх ерөнхий ойлголт

Товч агуулга

Програмчлалд гарсан технологийн хувьсгал гэж нэрлэдэг OOP (Object-Oriented-Programming) буюу Объект хандлагат програмчлалын онолын мэдлэг, түүний түшин янз бүрийн түвшиний бодлогыг С хэлээр програмчлах дадлага олгоно

Санамж:


- Тухайн хичээлийн мэдээлэл бүрэн ороогүй, тодорхойгүй байвал СА-даа хандана уу. Учир нь хичээлийн мэдээллийг СА-аас оруулдаг болно.
- Цахим журнал хэрэглэх зааврыг нүүр хуудасны гарын авлага хэсгийн **Цахим журнал хэрэглэх заавар** -аас харна уу.
- Тухайн хичээлийн санал асуулга хэсгийг ашиглах зааврыг үндсэн цэсний **Хичээлд бүртгүүлэлт** -> **Санал** хэсгээс харна уу.

2. ХӨТӨЛБӨР

Та энэ хэсгээс өөрийн сурч буй сургалтын төлөвлөгөө болон тухайн төлөвлөгөөний хичээлийн уялдаа холбоог харах боломжтой.

А. Сургалтын төлөвлөгөө

Оюутан та сурч буй сургалтын төлөвлөгөөгөө үндсэн цэсний **Хөтөлбөр -> Сургалтын төлөвлөгөө** хэсгээс харах болон хянах боломжтой. Та өөрийн сурч буй төлөвлөгөөнөөс ямар ямар хичээлийг судалсан болон судлаагүй, заавал болон сонгон судлах хичээлүүдээс нийт хэдэн багц цаг судалсан талаарх мэдээллээ харах боломжтой.



ерөнхий суурь хичээл - (25.0 багц цаг)					
Заавал судлах хичээл - (18.0 багц цаг)					
1	COMP100	3 бц	Мэдээллийн технологи, мэдээллийн систем	Судалсан	
2	HIST100	3 бц	Монголын түүх	Судалсан	
3	SPRT100	3 бц	Биеийн тамир	Судлаагүй	
4	FNDR100	1 бц	Гамшигаас хамгаалах менежментийн үндэс	Судалсан	
5	ENGL100	3 бц	Англи хэл-1	Судалсан	
6	ENGL100	3 бц	Англи хэл-2	Судалсан	
7	ENGL102	3 бц	Англи хэл (Дунд)	Судлаагүй	
8	ENGL103	3 бц	Англи хэл (Ахисан Дунд)	Судлаагүй	
9	SPRT100	1.5 бц	Биеийн тамир I	Судалсан	
10	SPRT100	1.5 бц	Биеийн тамир II	Судалсан	
11	ENGL101	3 бц	Англи хэл (Анхан дунд)	Судлаагүй	
12	PENG220	2 бц	Мэргэжлийн англи хэл II (Мэдээллийн технологи-Дунд)	Судалсан	
13	PENG210	2 бц	Мэргэжлийн англи хэл I (Мэдээллийн технологи-Анхан дунд)	Судалсан	
14	ENGL104	3 бц	Англи хэл (Дээд)	Судлаагүй	
15	ENGL100	3 бц	Англи хэл (Анхан)	Судлаагүй	
16	ENGL103	1 бц	Академик англи хэл-Уншиж дадал-1 (Анхан дунд)	Судлаагүй	
17	ENGL104	1 бц	Академик англи хэл-Бичиж дадал-1 (Анхан дунд)	Судлаагүй	
18	ENGL105	1 бц	Академик англи хэл-Харилцах дадал-1(Анхан дунд)	Судлаагүй	
	Нийт	41 бц			
	Судалсан багц цаг	18 бц			

Мөн сургалтын төлөвлөгөөний биелэлтийг хүснэгт хэлбэрээр харах, хянах боломжтой.

Төлөвлөгөөний биелэлт
/Дутуу багц цагийг заавал гүйцээн судлах/

#	Бүлэг	Судлах ёстой багц цаг	Цуглуулсан багц цаг	Судалж байгаа багц цаг	Дутуу багц цаг
1	ерөнхий суурь хичээл	25.0	25	0.0	0
1.1	Заавал судлах хичээл	18.0	18.0	0.0	0
1.2	Сонгон судлах хүмүүнлэгийн ухааны хичээл	4.0	4.0	0.0	0
1.3	сонгон судлах нийгмийн ухааны хичээл	3.0	3.0	0.0	0
2	мэргэжлийн суурь заавал судлах хичээл	54.0	51	3.0	3
3	Мэргэшүүлэх хичээл	35.0	15	17.0	20
3.1	Заавал судлах хичээл	32.0	13.0	12.0	19
3.2	Бакалаврын судалгааны ажил	3.0	0.0	0.0	3
3.3	В2. сонгон судлах хичээл	3.0	2.0	5.0	1
4	Чөлөөт сонголтын хичээл	6.0	0	0.0	6
Нийт		120	91	20	29

Төлөвлөгөөний бүлгүүд

Таны судалж байгаа багц цаг

Дутуу багц цагийг заавал гүйцээн судлах

Нийт судлах ёстой багц цаг

Таны нийт цуглуулсан багц цаг

Б. Хичээлийн уялдаа

Та өөрийн сурч буй төлөвлөгөөнд байгаа хичээлүүдийн уялдаа холбоог энэ хэсгээс харах боломжтой. Уялдаа холбоо гэдэг нь ямар хичээл үзэж байж дараагийн хичээлийг үзэхийг зааж өгсөн холбоо юм. Хичээлийн уялдаа холбоог үндсэн цэсний **Хөтөлбөр -> Хичээлийн уялдаа** хэсгээс харна үү.

ХИЧЭЭЛИЙН УЯЛДАА ХОЛБОО

✎ Электроник, автоматик (Бакалаврын Өдрийн сургалт)

☰ Сургалтын төлөвлөгөө: 2012

☑ **Хичээлүүд**

- Ангийн ажил (- 1кр)
- Англи хэл (Дунд) (ENGL102 - 3кр)
- Англи хэл (Анхан дунд) (ENGL101 - 3кр)
- Англи хэл (Ахисан Дунд) (ENGL103 - 3кр)
- Англи хэл (Анхан) (ENGL100 - 3кр)
- Англи хэл (Дээд) (ENGL104 - 3кр)
- Англи хэл-1 (ENGL100 - 3кр)
- Англи хэл-2 (ENGL100 - 3кр)
- Бакалаврын судалгааны ажил (THES400 - 3кр)
- Биеийн тамир (SPRT100 - 3кр)
- Биеийн тамир I (SPRT100 - 1.5кр)
- Биеийн тамир II (SPRT100 - 1.5кр)
- Гамшигаас хамгаалах менежментийн үндэс (FNDP100 - 1кр)
- Дифференциал тэгшитгэл (EMAT200 - 4кр)
- ☑ **Дохио ба систем (ITCM211 - 3кр)**
- Компьютерийн сүлжээний үндэс (ITNW100 - 3кр)
- Магадлалын онол, санамсаргүй процесс (EMAT201 - 3кр)
- Менежментийн үндэс (MGMT100 - 3кр)
- Механик ба молекулын физик (EPHY101 - 3кр)
- Монгол хэлний найруулга зүй (LANG100 - 2кр)
- Монголын түүх (HIST100 - 3кр)
- Мэдээллийн технологи, мэдээллийн систем (COMP100 - 3кр)
- Мэргэжлийн англи хэл I (Мэдээллийн технологи-Анхан дунд) (PENG210 - 2кр)
- Мэргэжлийн англи хэл II (Мэдээллийн технологи-Дунд) (PENG220 - 2кр)
- Мэргэжлийн дадлага (ELEC105 - 1кр)
- Оптик, квант физик (EPHY201 - 3кр)
- Оюуны өмчийн эрх зүй (CILA514 - 2кр)
- ☑ **Програмчлалын үндэс (CSSW101 - 3кр)**
- ☑ **Програмчлалын хэл Си (CSSW111 - 3кр)**
- Компьютерийн бүтэц, ассемблер хэл (COMP332 - 3кр)

Уялдаа холбоотой хизэл (pointing to ITCM211)

Сурч буй хөтөлбөр, төлөвлөгөө (pointing to the top header)

Залгамжгүй хичээл (pointing to FNDP100)

Дараагийн залгамж (pointing to COMP332)

Дарах (pointing to CSSW101)

3. ХӨТӨЛБӨР СОНГОЛТ

Бакалаврын өдрийн ерөнхий суурь хөтөлбөрийн оюутнуудын мэргэжлийн хөтөлбөр сонгуулах үйл ажиллагаа нь дараах үе шаттайгаар, цахим хэлбэрээр явагдана. Үүнд:


- Цаашид суралцах мэргэжлийн хөтөлбөрүүдэд саналаа өгөх
- Санал өгсөн хөтөлбөрүүдээс зөвхөн нэг хөтөлбөрийг сонгож баталгаажуулах

А. Тандалт, санал

Мэргэжлийн хөтөлбөр сонгох болзол хангасан оюутнууд журамд заасан хугацааны дагуу системийн зүүн талд байрлах **Хөтөлбөр сонголт -> Тандалт, санал** хэсгээр орон журамд заасан тооны дагуу мэргэжлийн хөтөлбөрүүдэд саналаа өгнө. **Хөтөлбөр сонголт -> Тандалт, санал** хэсгээр ороход саналын тооноос хамааран дараах хэсэг дуудагдана.



Оюутан та харгалзах **Хөтөлбөр сонгох** товч бүр дээр даран ялгаатай хөтөлбөрүүдэд саналаа өгнө.



Тухайн хөтөлбөрийг сонгоод **Хадгалах** товч дарснаар тухайн хөтөлбөрт тандалт өгсөн гэсэн үг бөгөөд тандалт өгсөн хөтөлбөрүүд дараах байдлаар харагдана. Энэ хэсгээс тандалт өгсөн хөтөлбөрийг журмын тандалт өгөх хугацаанд солих боломжтой.

2015-	-аас 2015-	-ны хооронд явагдана.	Өгсөн саналууд
1	Компьютерийн график дизайн		Үргэлжлэн сонгох
2	Мэдээллийн систем		Үргэлжлэн сонгох
3	Менежмент, мэдээллийн системийн	Тандалт өгсөн хөтөлбөрүүд	Үргэлжлэн сонгох
4			Үргэлжлэн сонгох

Сонгосон хөтөлбөрийг солих

Санамж:

- Бүрэлдэхүүн сургуулиас хамааран оюутны тандалт өгөх хөтөлбөрийн тоо ялгаатай байна.
- Журамд заасан тандалт өгөх хугацаанд өөрийн тандалт өгсөн хөтөлбөрийг өөрчлөх боломжтой.
- Журамд заасан тандалт өгөх хугацаа дууссан тохиолдолд өөрийн тандалт өгсөн хөтөлбөрийг өөрчлөх боломжгүй.
- Оюутан та зөвхөн тандалт өгсөн мэргэжлийн хөтөлбөрүүдээс сонгож баталгаажуулах учир сонголтоо зөв хийгээрэй.

Б. Онооны үзүүлэлт

Оюутан та **Хөтөлбөр сонголт** -> **Онооны үзүүлэлт** хэсгээс мэргэжлийн хөтөлбөр сонгох болзол хангасан, хангаагүй эсэхээ харах бөгөөд хэрвээ та мэргэжлийн хөтөлбөр сонгох болзлоо хангасан бол тухайн салбар/сургуулийн хэмжээнд нийт хэдэн оюутнаас хэдэн оноотойгоор хэддүгээр байранд явж байгаагаа харах боломжтой.




Санамж:

- Мэргэжлийн хөтөлбөр сонгох журмын дагуу оюутныг болзол хангасан, хангаагүйг бодож байгаа учраас журамтай сайтар танилцана уу.
- Оюутны оноог журмын 3.1.2-ийн б-д заасан томъёоны дагуу бодогдоно.


В. Онооны жагсаалт


Оюутан өөрийн сургуулийн нийт оюутнууд болон өөрийн тандалт өгсөн хөтөлбөрүүдэд санал өгсөн нийт оюутнуудын онооны жагсаалт болон сонгож баталгаажуулсан мэргэжлийг **Хөтөлбөр сонголт** -> **Онооны жагсаалт** хэсгээс харж, хянах боломжтой.




Г. Баталгаажуулалт


Мэргэжлийн хөтөлбөрүүдэд саналаа өгсний дараа журамд заасан хугацаанд **Хөтөлбөр сонголт** -> **Баталгаажуулалт** хэсгээр орон зөвхөн тандалт өгсөн тухайн хөтөлбөрийн хяналтын тоонд багтсан хөтөлбөрүүдээс зөвхөн НЭГ мэргэжлийн хөтөлбөрийг сонгож баталгаажуулна.




Одоогоор эзэлж байр нийт хяналтын тоонд багтсан тохиолдолд дээрх зурагт үзүүлсэн байдлаар сонгох боломжтой. Өөрийн сонгох хөтөлбөрт харгалзах Сонгох талбар дах  утгыг сонгож **Баталгаажуулах** товч дээр даран сонгосон хөтөлбөрийг баталгаажуулах бөгөөд доорх анхааруулга цонх гарч ирнэ.



Анхааруулга цонхонд гарч ирсэн санамжтай сайтар танилцсаны дараа “Тийм. Зөвшөөрч байна.” гэсэн хэсгийг чагталж “Баталгаажуулах” товч дээр дарснаар таны сонгосон хөтөлбөр баталгаажна.



Баталгаажсан хөтөлбөр доорх байдлаар харагдана.



- ✓ Тухайн оюутан мэргэжлийн хөтөлбөр сонголтоо баталгаажуулахад бусад хөтөлбөрт өгсөн санал нь хүчингүй болж энэ хугацаанд жагсаалтын дагуу улаан шугамны доор байгаа оюутан хяналтын тоонд нэмэгдэн сонголтоо баталгаажуулах боломжтой.
- ✓ Оюутан өөрийн сургуулийн нийт оюутнууд болон өөрийн тандалт өгсөн хөтөлбөрүүдэд санал өгсөн нийт оюутнуудын онооны жагсаалт болон сонгож баталгаажуулсан мэргэжлийг **Жагсаалт харах** харах хэсэг болон **Хөтөлбөр сонголт** -> **Онооны жагсаалт** хэсгээс харж, хянах боломжтой.

Санамж:

- Оюутан та зөвхөн тандалт өгсөн мэргэжлийн хөтөлбөрүүдээс сонгож баталгаажуулна.
- Нэгэнт баталгаажуулсан мэргэжлийн хөтөлбөрийг буцаах боломжгүй тул

сонголтоо анхааралтай хийнэ үү.

- Хэрвээ та мэргэжлийн хөтөлбөрөө журамд заасан хугацаанд системээр баталгаажуулж чадаагүй бол журмын 3.1.2-ийн 3-д заасны дагуу мэргэжлийн хөтөлбөр сонгох боломжтой.

4. ХИЧЭЭЛД БҮРТГҮҮЛЭЛТ

Хичээлд бүртгүүлэх үйл ажиллагаа нь хоёр үе шаттай, цахим хэлбэрээр явагдана. Үүнд:

- Санал
- Баталгаажуулалт

А. САНАЛ


Хичээлд бүртгүүлэлтийн саналын үе нь тухайн улиралд суралцаж байгаа оюутнууд дараагийн улиралд ямар хичээл үзэх хүсэлтэй байгаа саналыг авдаг. Оюутнуудын саналыг үндэслэн тэнхим, Элсэлт, бүртгэлийн хэлтэс дараагийн улиралд ямар хичээлийг, хэн гэдэг багш, ямар хуваариар заах мөн хичнээн оюутан суралцахыг тодорхойлдог. Нэгдүгээр ангийн оюутнуудын хувьд намрын улирлын хичээлд бүртгүүлэлт хийхдээ санал өгөх шатыг алгасан шууд хичээлд бүртгүүлэх болно.

Хичээлд бүртгүүлэлтийн саналын үе нь дараах байдлаар явагдана.

- Элсэлт, бүртгэлийн хэлтсээс тухайн улирлын 13, 14 дэх долоо хоногуудад **Хичээлд бүртгүүлэлт (Санал)** -ийг нээнэ.
- Та тухайн улиралд үзэж байгаа бүх хичээлийн багшийн санал асуулгад оролцоно.
- Оюутан тухайн улирлын 13, 14 дэх долоо хоногт багтаан заавал болон сонгон судлах хичээлээс сонгон дараагийн улиралд судлах хичээлийн санал гаргана.

Багшийн санал асуулга: Та энэ улиралд судалж буй бүх хичээлийнхээ багшийн санал асуулгад эхлээд оролцоно. Үүний дараа хичээл тандалтаа хийх болно. Багшийн санал асуулга өгөхдөө нүүр хуудсанд байрлах **Судалж буй хичээлүүд** хэсэгт байрлах тухайн хичээл дээр даран гарч ирэх товчнуудаас **Санал асуулга өгөх** товчин дээр дарна.

Судалж буй хичээлүүд



COMP332 - Компьютерийн бүтэц, ассемблер хэл (3 кр)

ELEC222 - Тоон системийн дизайн (3 кр)

Хичээлийн мэдээлэл | Хуваарь | Журнал | **Санал асуулга өгөх**

ITNW100 - Компьютерийн сүлжээний үндэс (3 кр)

CSSW223 - Объект хандлагат програмчлал (3 кр)

CULT100 - Соёл судлалын үндэс (2 кр)

Хичээл дээр дарх

Дарх

Бүх хичээл дээр санал асуулга өгөх

Уг товчин дээр дарснаар оюутан таньд тухайн хичээлийг орж буй бүх багшийн нэрс гарч ирэх бөгөөд багш тус бүрт санал өгөх болно. Тухайн багшийн хэсэг дээр дарснаар санал өгөх хэсэг рүү шилжих болно.

Тоон системийн дизайн

1. Энэхүү санал асуулгын асуултаудад хариулснаар дараагийн улиралд заавал болон сонгон судлах хичээлийн санал өгөх боломжтой болно.
2. Санал асуулгын үр дүнг сургалтын үйл ажиллагааг сайжруулах, багшийн ажлыг үнэлэх, багшийн заах арга, ур чадварыг дээшлүүлэхэд ашиглана.
3. Санал өгсөн оюутны нэр багшид харагдахгүй ба зөвхөн санал асуулгын үр дүн харагдах болно.
4. Зөвхөн тухайн улиралд амжилттай бүртгүүлсэн хичээлд санал асуулга өгөх боломжтой.

Баттогтох.Ж (Багш, МУИС, Хшуис, Эхит)

Санал асуулга өгөх үү?

Зулхүү.Т (Сургалтын инженер, МУИС, Хшуис, Эхит)

Санал асуулга өгөх үү?

Санал асуулгын бүх бүлгийн бүх асуултыг үнэн зөв бөглөн **Илгээх** товчин дээр дарна.

Багшийн заах арга, түүнд шууд нөлөөтэй зарим үзүүлэлтийн талаарх оюутны үнэлгээ(шинэчилсэн)

Хичээлийн нэр: Тоон системийн дизайн

Багшийн нэр: Зулхүү.Т (Сургалтын инженер, МУИС, Хшуис, Эхит)

1. Багшийн талаар

1. Багш хичээлийн бэлтгэлийг сайн хангасан байдаг

- бүрэн санал нийлж байна
- ихэнхи тохиолдолд санал нийлж байна
- цөөн тохиолдолд санал нийлж байна
- огт санал нийлэхгүй байна

2. Багш хичээлийг ойлгомжтой, сонирхолтой заадаг

- бүрэн санал нийлж байна
- ихэнхи тохиолдолд санал нийлж байна
- цөөн тохиолдолд санал нийлж байна
- огт санал нийлэхгүй байна

2. Сургалтын орчин

16. Ангил, танхим тохилог, цэвэр байдаг

- бүрэн санал нийлж байна
- ихэнхи тохиолдолд санал нийлж байна
- цөөн тохиолдолд санал нийлж байна
- огт санал нийлэхгүй байна

19. Сургалтын орчны талаар өөр санал, хүсэлт байвал бичнэ үү. (Хариулт бичгээр)

Энд бичнэ үү!

3. Хичээлийн талаар

20. Хичээлийн онолын төвшин, дэс дараалал тохирсон байдаг

- бүрэн санал нийлж байна
- ихэнхи тохиолдолд санал нийлж байна
- цөөн тохиолдолд санал нийлж байна
- огт санал нийлэхгүй байна

23. Хичээлийн талаар өөр санал, хүсэлт байвал бичнэ үү. (Хариулт бичгээр)

Энд бичнэ үү!

Илгээх

Дээрх зааврын дагуу судалж буй бүх хичээлийнхээ санал асуулгыг тухайн хичээлийг орж байгаа бүх багшид өгөх бөгөөд бүх багшийн санал асуулгыг өгсөн тохиолдолд

түхайн хичээлийн Санал асуулга өгөх товч Санал асуулга өгсөн болсон байх болно.



Санамж:

- Элсэлт, бүртгэлийн хэлтсээс Хичээлд бүртгүүлэлт (санал) -ийг эхлүүлээгүй тохиолдолд багшийн санал асуулга болон хичээлийн санал өгөх эрх нээгдэхгүй.
- Оюутан та түхайн улиралд судалсан бүх хичээлийнхээ багшийн санал асуулгад оролцсон тохиолдолд дараагийн улиралд үзэх хичээлдээ санал өгөх эрх нээгдэнэ. Хэрвээ дор хаяж нэг хичээлийн багшийн санал асуулгад оролцоогүй тохиолдолд дараагийн улиралд үзэх хичээлдээ санал өгөх эрх нээгдэхгүй.
- Таны өгсөн санал асуулгын үр дүн багшийн үнэлгээнд шууд нөлөөлөх учир санал асуулгыг үнэн зөв өгөх хэрэгтэй.

Багшийн санал асуулгыг өгсний дараа дараагийн улиралд үзэх хичээлийн тандалтаа өгөх болно.

Хичээл тандалт: Түхайн улиралд судалсан бүх хичээлийн багшийн санал асуулгад оролцсоны дараа дараагийн улиралд үзэх хичээлдээ санал өгөх болно.


BLAW201 - Эрх зүйн үндэс (2 кр)



SPRT101 - Биеийн тамир (3 кр)






Түхайн улиралд судалж буй бүх хичээлийнхээ багшийн санал асуулгад оролцсоны дараа нүүр хуудасны Мэдээ хэсэг болон үндсэн цэсний Хичээлд бүртгүүлэлт -> Санал хэсэгт дараагийн улиралд үзэх хичээлдээ санал өгөх эрх нээгдэнэ.



Үндсэн мэдээлэлтэй танилцах

Хичээл тандалт хийхийн өмнө үндсэн мэдээллүүдтэй танилцах хэрэгтэй. Оюутан таны сургалтын төлөвлөгөөнд байгаа хичээлүүд доорх тэмдэглэгээний хамт гарч ирэх бөгөөд тус бүр утга илэрхийлнэ.

-  Судлах боломжтой
-  Судалсан эсвэл судалж байгаа
-  Судлах боломжгүй /Өмнөх залгамж хичээл судлаагүй/

Тухайн хичээлийн төлөв буюу тэмдэглэгээ

Оюутан таньд тус болохуйц нэмэлт мэдээллүүд дараах байдлаар харагдана.

Төлөвлөгөөний биелэлт

#	Бүлэг	Судлах	Судалсан, судалж байгаа	Дутуу багц	Санал өгсөн
1	ерөнхий суурь хичээл	25.0	23	2	0.0
2	Заавал судлах хичээл	18.0	18.0	0	0.0
3	Сонгон судлах хүмүүнлэгийн ухааны хичээл	4.0	2.0	2	0.0
4	сонгон судлах нийгмийн ухааны хичээл	3.0	3.0	0	0.0
5	мэргэжлийн суурь заавал судлах хичээл	54.0	48	6	0.0
6	Мэргэшүүлэх хичээл	35.0	10	25	0.0
7	Заавал судлах хичээл	32.0	10.0	22	0.0
8	Бакалаврын судалгааны ажил	3.0	0.0	3	0.0
9	Чөлөөт сонголтын хичээл	6.0	0	6	0.0

Тухайн бүлгийн нийт судлах ёстой багц цаг

Судалсан болон одоогоор судалж байгаа багц цаг


Тухайн бүлгээс үзэх шаардлагатай багц цаг

Одоогоор санал өгсөн багц цаг

Төлөвлөгөөний бүлгүүд

Хичээл тандалт

Санал өгөх хэсэгт таны сурч буй төлөвлөгөөний бүх хичээлүүд дээрх тайлбарын хамт хүснэгт хэлбэрээр гарч ирнэ.



B. Мэргэшүүлэх хичээл (Судлах: 36.0/ Судалсан, судалж байгаа: 6)				
B1. Заавал судлах хичээл (Судлах: 25.0/ Судалсан, судалж байгаа: 3.0)				
1	★	INTL437	26ц	Олон улсын эрх зүй
2	★	MRKT303	36ц	Маркетингийн удирдлага
3	★	INTR302	26ц	Олон улсын худалдааны үнэ тариф
4	★	INTR303	26ц	Олон улсын ложистик
5	★	MRKT412	36ц	Олон улсын маркетинг

Сонгох боломжтой хичээлүүд дээр дурдсаны адил урдаа ногоон таван хошуутай харагдах ба ногоон таван хошуун дээр дарахад дараах асуулт гарч ирнэ. Та санал өгөх бол ОК товчин дээр үгүй бол Cancel товчин дээр дарна.

Олон улсын эрх зүй хичээлийг сонгох уу? Сонгох бол Ок, үгүй бол Cancel дарна уу!

Мөн таны сурч буй төлөвлөгөөний тухайн бүлгийн нийт судлах багц цагаас таны сонгосон хичээлийн багц цаг хэтэрсэн тохиолдолд дараах анхааруулга гарч ирэх бөгөөд та зөвшөөрч байвал ОК товчин дээр үгүй бол Cancel товчин дээр дарна.

Англи хэл-(Анхан дунд түвшин) хичээлийг сонговол таны A1. Заавал судлах хичээл багцаас 1 багц цагаар хэтэрхийг анхааруулья! Сонгох бол Ок, үгүй бол Cancel дарна уу!

Санал өгсөн хичээл дараах байдалтай харагдах бөгөөд саналыг цуцлахаар бол Цуцлах товчин дээр дарна.



Санамж:

- Элсэлт, бүртгэлийн хэлтсээс **Хичээлд бүртгүүлэлт (санал)**-ийг эхлүүлээгүй тохиолдолд багшийн санал асуулга болон хичээлийн санал өгөх эрх нээгдэхгүй.
- Оюутан та тухайн улиралд судалсан бүх хичээлийнхээ багшийн санал асуулгад оролцсон тохиолдолд дараагийн улиралд үзэх хичээлдээ санал өгөх эрх нээгдэнэ. Хэрвээ дор хаяж нэг хичээлийн багшийн санал асуулгад оролцоогүй тохиолдолд дараагийн улиралд үзэх хичээлдээ санал өгөх эрх нээгдэхгүй.
- Идэвхтэй сурч байгаа, Идэвхгүй сурч байгаа, Оюутан солилцоогоор явсан, Чөлөө авсан - 1 улирал, Чөлөө авсан - 2 улирал төлөвтэй оюутнууд хичээл тандалт өгөх боломжтой.
- Бусад төлөвтэй тохиолдолд таны **ХИЧЭЭЛИЙН ЖАГСААЛТ ХАРАГДАХГҮЙ** тул өөрийн харъяа сургуулийн сургалтын албандаа хандана үү.
- Та өөрийн сурч буй төлөвлөгөөгөө сайтар нягтлан зөв сонголт хийнэ үү. Сурч буй төлөвлөгөөний тухайн бүлгийн заавал судлах багц цагийн биелүүлэлтийг амжилттай цуглуулсан бөгөөд тухайн бүлгээс нэмж хичээл сонгох гэж байгаа бол энэ нь илүү сонгон судалсан хичээл болно. Харин тухайн бүлгийн заавал судлах багц цагийн биелүүлэлтийг бүрэн биелүүлээгүй бөгөөд дараагийн улиралд энэ бүлгээс хичээл сонгож үзэх гэж байгаа бол тандалтаа заавал өгөхийг эрмэлзэнэ үү.

Жишээ нь: Оюутан дараах төлөвлөгөөний Байгалийн ухаан бүлгээс 6 багц цаг заавал сонгож судалсан байх ёстой бөгөөд 3 багц цагийг нь судалсан тул нэмж 3 багц цаг судлах ёстой. Оюутан дараагийн улиралд энэ бүлгээс үлдсэн 3 багц цагаа судлахаар төлөвлөж байгаа бол тандалтаа заавал өгөхийг эрмэлзээрэй. Хэрвээ 6 багц цагаа судалсан бол энэ бүлгийн хичээлээс ахин судлахад энэ нь илүү багц цаг болох болно.

ТАНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЕРӨНХИЙ СУУРЬ - (30 БАГЦ ЦАГ)

Нийт судалсан байх ёстой багц цаг

#	Хичээлийн индекс	Багц цаг	Хичээлийн нэр	Төлөв
Байгалийн ухаан - (6 БАГЦ ЦАГ)				
1	RHYS100	3	Юмс үзэгдлийн физик үндэс (Ерөнхий суурь)	Судалсан
2	RHYS102	3	Физикийн үндэс (Ерөнхий суурь)	Судлаагүй
3	GEOG100	3	Нийгмийн газарзүй (Ерөнхий суурь)	Судлаагүй
	Нийт	9 бц		
	Судалсан багц цаг	3 бц		

Тухайн бүлгээс заавал сонгох багц цаг

Судалсан хичээл

Судалсан

Судлаагүй

Судлаагүй

Судлах боломжтой хичээл

Тухайн бүлэгт байгаа хичээлүүдийн нийт багц цаг

Судалсан багц цаг

Дээрх бүлгээс өөр бүлэг бий


- Та өөрийн сурч буй төлөвлөгөөгөө зүүн цэсний **ХӨТӨЛБӨР -> СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ** хэсгээс харна уу.
- Тандалттай холбоотой үндсэн болон туслах мэдээлэлтэй сайтар танилцана уу.
- Таны сонгосон хичээлүүдийн нийт кредит нэг улиралд судлах багц /21 кредит/ цагийн хязгаараас хэтрэхгүй байна.
- Хэрвээ та тухайн хичээл дээр санал өгөөгүй тохиолдолд **Хичээлд бүртгүүлэлт (баталгаажуулалт)** -аар хугацааны 50%-ийн хоцрогдолтойгоор баталгаажуулалт хийх учир саналаа заавал өгнө үү.
- Тухайн хичээлд тандалт өгөөгүй тохиолдолд дараагийн улирлын **Хичээлд бүртгүүлэлт (баталгаажуулалт)** –аар хугацааны 50%-ийн хоцрогдолтойгоор баталгаажуулалт хийх учир саналаа заавал өгнө үү.
- Тухайн хичээлд тандалт өгсөн тохиолдолд дараагийн улирлын **Хичээлд бүртгүүлэлт (баталгаажуулалт)** –аар тухайн хичээлийг сонгох давуу эрх үүснэ.
- Хичээл тандалтын үр дүнгээс хамааран дараагийн улирлын хичээлийн хуваарь хийгддэг тул та тандалтаа заавал өгнө үү.
- Энэхүү тандалт нь тухайн хичээлийг дараагийн улиралд хэр олон оюутан үзэх хүсэлтэй байгаа талаар авч буй тандалт бөгөөд энэ нь эцсийн баталгаажуулалт биш болно.

Б. БАТАЛГААЖУУЛАЛТ

Хичээлд бүртгүүлэлтийн баталгаажуулалтын үе нь дараах байдлаар явагдана.

- Ирэх улиралд орох хичээл, анги танхим, цаг, багшийн талаарх мэдээлэл бүхий хичээлийн ерөнхий хуваарийг салбар Элсэлт, бүртгэлийн хэлтэс улирлын шалгалтын хугацаанд хичээлд бүртгүүлэлтийн санал дээр үндэслэн бэлэн болгоно.
- Элсэлт, бүртгэлийн хэлтэсээс тухайн улирлын **Хичээлд бүртгүүлэлт (баталгаажуулалт)** -ийг нээнэ.

- Оюутан хичээлийн хуваарийг үндэслэн хичээлд бүртгүүлэх буюу баталгаажуулна. Элсэлт, бүртгэлийн хэлтсээс **Хичээлд бүртгүүлэлт (баталгаажуулалт)** -ийг нээсэн тохиолдолд нүүр хуудасны Мэдээ хэсэг болон үндсэн цэсний Хичээлд бүртгүүлэлт -> Баталгаажуулалт хэсэгт хичээл сонгож баталгаажуулах эрх нээгдэнэ.



Хичээлд бүртгүүлэлтийн баталгаажуулалтын үе нь дотроо мөн 2 үе шаттай. Үүнд:

- Хичээл буюу хуваарь сонголт
- Баталгаажуулалт

Хуваарь сонголт:

- **Үндсэн мэдээлэлтэй танилцах**

Хуваарь сонголт хийхийн өмнө үндсэн мэдээллүүдтэй танилцах хэрэгтэй. Оюутан таны сургалтын төлөвлөгөөнд байгаа хичээлүүд доорх тэмдэглэгээний хамт гарч ирэх бөгөөд тус бүр утга илэрхийлнэ.

- ✓ Баталгаажуулсан хичээл
- ★ Судлах боломжтой
- ★ Судлах боломжтой боловч хичээлийн хуваарь бэлэн биш
- ★ Судлах боломжтой боловч хичээлийн хуваарьт тавигдаагүй
- ★ Судалсан эсвэл судалж байгаа
- ★ Судлах боломжгүй
- ★ Судлах боломжгүй хичээл сонгосон
- ★ Адилтгагдсан хичээл
- ★ Хичээлд санал өгөөгүй, хичээл сонголтын үргэлжлэх хугацааны 1/2-с хойш сонгох боломжтой.

Төлөвлөгөөний биелэлт

Энд дарна уу

Үндсэн мэдээлэл

Цуглуулсан : 33
 Суралцаж буй түвшин : 2
 Сонгох боломжтой нийт багц цаг : 21
 Англи хэлний түвшин : Дунд
 Нийт сонгосон багц цаг : 7
 Нийт баталгаажуулсан багц цаг : 0

Туслах мэдээлэл

Та онлайн гүйцэтгэний зөхтэй картаар болон Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль-н дараах дансанд Paybill үйлчилгээ ашиглан төлбөрөө төлөх боломжтой. Paybill үйлчилгээгээр төлбөр төлөх заавартай энд дамж танилцана уу!

Банк	Дансны дугаар	Дансны нэр
Хаан банк	5041339517	Монгол Улсын Их Сургууль
Голомт банк	8115006181	МУИС-ОУХНУСургууль

Баталгаажуулах
(төлбөр төлөх хэсэг рүү шилжих)

Төлбөр төлөх хэсэг рүү шилжихдээ уг товч дээр дарна!!!

Тухайн хичээлүүдийн төлөв буюу тэмдэглэгээ. Эндээс цайвар ногоон таван хошуу буюу Судлах боломжтой боловч хичээлийн хуваарьт тавигдаагүй байвал Сургалтын албандаа хандана уу!!!

Сонгосон багц цагийн мэдээлэл болон сонгох боломжтой багц цагийн мэдээлэл

Өөрийн тань суралцдаг салбар сургуулийн сургалтын төлбөрийн данс

• Хичээл буюу хуваарь сонголт


Үндсэн мэдээлэлтэй сайтар танилцсаны дараа өөрийн судлах хичээлийн хуваарийг зохионо. Сонгох боломжтой хичээлүүд дээр дурдсаны адил урдаа ногоон таван хошуутай харагдах бөгөөд хичээл бүрийн урд байгаа тэмдэглэгээн дээр заагчаа /хулгана/ аваачихад тэмдэглэгээний тайлбар гарч ирнэ.

ерөнхий суурь хичээл			
Заавал судлах хичээл			
Судлах боломжтой	00	3 бц	Мэдээллийн технологи, мэдээллийн систем
2	★ HIST100	3 бц	Монголын түүх


Заагчаа аваачихад тайлбар гарч ирнэ.

Сонгох боломжтой хичээл буюу ногоон таван хошуу дээр дарахад хуваарь сонгох хэсэг гарч ирнэ. Энд тухайн хичээлийн сонгох боломжтой хуваариуд дараах зурагт


үзүүлснээр сонгосон хуваариудын хамт гарч ирнэ.



Лекцийн хуваарийг сонгоход тухайн лекцэнд харгалзах лаборатори эсвэл семинар автоматаар гарч ирэх/хэрвээ лекц байхгүй бол лаборатори эсвэл семинарыг сонгоно/ба хуваариудаа бүрэн сонгосны дараа **Хадгалах** товчийг даран хуваари хадгална.



Та дээрх хэсгээс өөрийн хичээлийн хуваарийн давхардлыг маш ойлгомжтойгоор харах боломжтой бөгөөд тухайн хичээлийн хуваарийн дэлгэрэнгүй мэдээллийг мөн харах боломжтой.



Оюутан энэ хуваарийг сонгох гэж байгаа гэж бодъё.
/Энэ жишээнд оюутны сонгох гэж байгаа хуваарь нь Компьютерийн сүлжээний үндэс хичээлтэй 5 дахь өдрийн 09:00-10:30 ийн хооронд давхцаж байгаа нь харагдаж байна/

Хуваарь дээр дарх

Хуваарь сонгох /дөрвөлжин нүдийг чатган сонгох/

Тухайн хуваарь дээр даснаар хуваарийн дэлгэрэнгүй мэдээлэл гарч ирнэ.

	monday	tuesday	wednesday	thursday	saturday
09:00 - 09:45	Лекц Хин-3а 117 Тоон системийн дизайн	Лаб Хин-3а 120 Тоон системийн дизайн	Лаб Хин-3а 215 Мэдээллийн технологийн үндэс	Лаб Хин-3а 215 Мэдээллийн технологийн үндэс	Лаб Хин-3а 215 Мэдээллийн технологийн үндэс
09:45 - 10:30		Баттогтох Ж	Зулхуу Т	Энхтүваа Ц	Лаб Хин-3а 215 Мэдээллийн технологийн үндэс
10:40 - 11:25	Лаб Хин-3б 200 Мэдээллийн технологийн үндэс				
11:25 - 12:10		Хурал-Очир Ц			
12:20 - 13:05			Лаб Хин-2 215 Мэдээллийн технологийн үндэс	Лаб Хин-2 257 Мэдээллийн технологийн үндэс	
13:05 - 13:50			Лаб Хин-2 257 Мэдээллийн технологийн үндэс	Лаб Хин-3а 215 Мэдээллийн технологийн үндэс	
14:00 - 14:45	Лекц Хин-3а 200 Компьютерийн бутц, ассемблер хэл	Лаб Хин-3а 123 Компьютерийн сүлжээний үндэс	Лекц Хин-3а 114 Объект хандлагат програмчлал	Лекц Хин-3а Мэдээллийн технологийн үндэс	
14:45 - 15:30	Отгонцэцэг С	Тэгшжаргал Ж	Пүрэв	Гагц	
15:40 - 16:25					
16:25 - 17:10	Лаб Хин-3а 127 Компьютерийн бутц, ассемблер хэл	Лаб Хин-3а 200 Мэдээллийн технологийн үндэс			
17:20 - 18:05	Отгонцэцэг С	Лекц Хин-1 310 Соёл судлалын үндэс	Хэрлэн Л		
18:05 - 18:50					

Мэдээллийн технологийн үндэс Экр

1-р цаг friday

Багш Эрдэнэбат Д
Лаборатори

Цаг 09:00-10:30

өрөө 257 тоот, Хичээлийн 2 - р байр

Оролт 16 удаа

Эхлэх огноо 2014.9.5

Суудал 13 / 31

1 долоо хоног тутамд орно

Амжилттай сонгосон хичээл хуваарийн хамт дараах байдлаар харагдах ба **Цуцлах** товчийг даран хуваарийг цуцалж болно.

ерөнхий суурь хичээл

Заавал судлах хичээл

1	★ COMP100	3 бц	Мэдээллийн технологи, мэдээллийн систем	
2	★ HIST100	3 бц	Монголын түүх	Семинар Гонгоржав.У (Лхагва 14:00-15:30) Лекц Гонгоржав.У (Мягмар 17:20-18:50)

[Цуцлах](#)

Санамж:

- Хичээлийн хуваарийг салбар СА хийж боловсруулдаг тул хуваарьтай холбоотой асуудлыг СА-даа хандана уу.
- Хичээл баталгаажуулалтыг идэвхтэй сурч байгаа, идэвхгүй сурч байгаа, оюутан солилцоогоор явсан төлөвтэй оюутнууд хийх боломжтой. Эдгээрээс өөр



төлөвтэй оюутнуудын хичээлийн жагсаалт гарч ирэхгүй болно. Энэ тохиолдолд СА-даа хандана уу. Өөрийн төлвийг харахдаа системийн нүүр хуудсанд байрлах оюутны мэдээллийн хэсгээс хараарай.

- Хэрэв тухайн хичээлийг судлах оюутны тоонд багтахгүй бол хүлээлгийн жагсаалтанд нэрээ бүртгүүлж болно. Хүлээлгийн жагсаалтанд байгаа оюутан тухайн хичээл дээр сул суудал гарвал бүртгүүлэх боломжтой болно.

Хичээлээ сонгож дууссаны дараа заавал баталгаажуулах буюу төлбөр төлөх шаардлагатай.

Баталгаажуулалт:

Баталгаажуулалт буюу төлбөр төлөлт

МУИС-ийн сургалтын систем нь банкны онлайн төлбөр тооцооны системтэй холбогдсон бөгөөд тус сургуулийн оюутнууд сургалтын төлбөрөө онлайн гүйлгээний эрхтэй, дотоодын картаар төлөх болно. Онлайн төлбөрийн системээс гадна оюутан аль ч банкаар үйлчлүүлэн төлбөрөө хийх боломжтой. Хичээл сонголтыг баталгаажуулсанаар та тухайн хичээлд албан ёсоор бүртгэгдэх ба баталгаажуулахын тулд тухайн улиралд судлах кредитийн төлбөр болон суурь хураамж заавал төлөх болно. Хичээл баталгаажуулсаны дараа хичээлийг цуцлах бол нэмэлт төлбөр төлөх болохыг анхааран **сонголтоо хариуцлагатай хийгээрэй**. Оюутан та дараах хэлбэрүүдээр төлбөрөө хийх боломжтой. Үүнд:

- Онлайн төлбөрийн системийг ашиглан төлбөр төлөх
- Дансны үлдэгдлээр буюу нябогийн шивсэн төлбөрөөр төлбөр төлөх
- PayBill үйлчилгээгээр төлбөр төлөх

Баталгаажуулах

Онлайнаар төлбөр төлөх: Сонгосон хичээлээ онлайн төлбөрийн системээр баталгаажуулахын тулд товчин дээр дарна. Энэ товчин дээр дарсны дараа төлбөл зохих төлбөр банк болон үлдэгдлээр баталгаажуулах товчийн хамт харагдана. Таны SISi-ийн дансанд байрлах илүү болон дутуу төлөлт одоогийн хичээл сонголтын төлбөрт тооцогдоно. (Жишээ нь: Таны дансанд 200'000 төгрөгний илүү төлөлт байгаа бөгөөд та 500'000 төгрөгний хичээл сонгож байгаа тохиолдолд та 300'000 төгрөг төлнө. Эсвэл та 200'000 төгрөгний дутуу төлөлттэй бол та 700'000 төгрөг төлнө.) SISi дэх дансны үлдэгдлийг баталгаажсан кредитийн мэдээлэл хэсгээс харна уу.

Сонгосон багц цаг болон төлбөрийн мэдээлэл

Нийт сонгосон багц цаг:	3.00
Нийт төлбөр:	295800.00
Хоцорсон хураамж:	0
Нийт төлвөл зөхийс:	95800.00
Дансны үлдэгдэл:	200000.00

Сонгосон хичээлүүд Test

Хичээлийн нэр	Индекс	Багц цаг	Багц цагийн төлбөр	Нийт төлбөр
Молекул ба зөийн биологи (Ерөнхий суурь)	BIOL100	3	98600	295800

Төлбөр төлөх боломжууд

Хаан банк

Голомт банк

ХААН банкны онлайн гүйлгээ хийх эрхтэй зөвхөн **төгрөгийн картаар** хийх боломжтой.

ХААН банкнаас бусад бүх банкны онлайн гүйлгээ хийх эрхтэй зөвхөн **төгрөгийн картаар** хийх боломжтой.

Үлдэгдэл болон төлбөрийн мэдээлэл

Сонгосон хичээл ба харгалзах төлбөр

Төлбөр төлөх боломжтой банкны мэдээлэл

Аль банкаар төлбөр төлөхөөс шалтгаалан тухайн банкны систем дуудагдах ба сонгосон кредит цаг болон суурь хураамжийг нэхэмжилсэн хуудас банкны системд очно.

Хаан банк:



Төлбөр хийх /Paying to

Гүйлгээний мэдээлэл /Order Details

Дүн /Amount 120,700.00

Гүйлгээний дугаар /Order ID XXXXX

Хувийн мэдээлэл /Personal Information

Карт эзэмшигчийн нэр /Cardholder Name

Утасны дугаар /Phone Number

И-мэйл /E-mail

Өөрийн утасны дугаар email хаягийг оруулна.

Картын мэдээлэл /Card Information

Картын дугаар /Card Number* Талаа оруулсан картын дугаар буруу байна. Invalid card number length.

Картын ар талд байгаа 3 орон бүхий тоо /CVV2*

Хүчинтэй хугацаа /Expiry Date* Нэгдүгээр сар / 2018

Э-Пин Е-Pin*

Картын мэдээллээ зөв оруулна уу. Асуудал гарвал банкиндаа хандана уу.


Гүйлгээ хийх /Submit Цуцлах /CANCEL



Төлбөрийн картны мэдээллийг зөв оруулснаар банкны системээс тухайн картны гүйлгээний E-pin кодыг асууна. E-pin кодыг ХААН Банкны дурын АТМ-с авна. Асууж тодруулах зүйл байвал ХААН Банкны лавлах 1917 болон callcenter@khanbank.com хаягаар хандана уу.

Голомт банк:

**ГОЛОМТ Банкны картаар
гүйлгээ хийх**



Information about order / Гүйлгээний тухай мэдээлэл

Merchant ID (Үйлчилгээний байгууллагын дугаар)	MUIS-MTS
Currency (Валютын төрөл)	Tugrik (MNT)
Amount (Гүйлгээний дүн)	120,700.00
Invoice number (Нэхэнжлэлийн дугаар)	CR1823/71

Card Information /Төлбөрийн картны мэдээлэл

Card number (Картны дугаар)	123456789****
Cardholder name on card (Картан дээрх нэр)	batbayar
Expiration date (Картны хүчинтэй хугацаа)	4 2014
Card Verification Number (CVV код) <small>Картын ард талд дугаарын ард байгаа 3 оронтой тоо</small>	123
Telephone Number <small>(Холбоо барих утасны дугаар)</small>	99*****
E-mail address <small>(Электрон шуудангийн хаяг)</small>	email@yahoo.com

Төлбөр хийх/Do payment >

АНХААРУУЛГА
Та Голомт банкны картаар төлбөрөө төлөх бол картны нууц кодоо тус банкны аль нэг салбараас авсан байх шаардлагатай. Энэ код нь ATM машинаас мөнгө авахад хэрэглэдэг PIN кодоос ялгаатай гэдгийг анхаарна уу.

Банкны системд очсон төлбөрийн нэхэмжлэл

Картны мэдээлэлд ямар нэг асуудал гарвал тухайн банкандаа хандахыг зөвлөж байна.

Өөрийн утасны дугаар email хаягийг оруулна.

Картны мэдээллийг зөв оруулж Төлбөр хийх товчин дээр дарснаар банкны системээс тухайн картны гүйлгээний E-code -ийг асуух болно. E-code -ийг харилцах банкны салбаруудаас авна.

Дансны үлдэгдлээр төлбөр төлөх: Сургалтын төлбөрөө сургуулийн дансанд тушаачихсан байгаа оюутнуудын хувьд төлбөр төлсөн баримт /капитанз/-аа өөрийн сургуулийн нябо-д өгнө. Нябо төлбөрийн хэмжээг системд шивж оруулсны дараа тухайн оюутны SISi дансанд төлбөр байршина. Үүнээс гадна төрийн сангийн буцалтгүй тусламж, тэтгэлэг зэргийг оюутан таны SISi дансанд нябо мөн адил шивж оруулна.

Баталгаажсан кредитийн мэдээлэл

Нийт сонгосон кредит: 0
 Кредитийн төлбөр: 0.00₮
 Суурь хураамж: 0₮
 Нийт төлбөр: 0.00₮

Таны дансны үлдэгдэл: 0.00₮

Таны суралцаж буй түвшин судалсан кредитээс хамаарна.

Ня-бо-гийн шивж оруулсан төлбөрийн хэмжээ

Баталгаажуулах

Сонгосон хичээлээ дансны үлдэгдлээр баталгаажуулахын тулд товчин дээр дарна. Хэрвээ таны дансанд төлбөр нь шивэгдсэн бол Төлбөрийг данснаас авах товч идэвхжих болно.

Сонгосон багц цаг болон төлбөрийн мэдээлэл

Нийт сонгосон багц цаг:	3.00
Нийт төлбөр:	295800.00
Хоцорсон хураамж:	0
Нийт төлвөл зохих:	295800.00
Дансны үлдэгдэл:	600000.00

Сонгосон хичээлүүд

Хичээлийн нэр	Индекс	Багц цаг	Багц цагийн төлбөр	Нийт төлбөр
Шашин судлалын үндэс (Ерөнхий суурь)	REL100	3	98600	295800

Төлбөр төлөх боломжууд

Төлбөрийг данснаас авах

Уг товч дээр дарж байж сонгосон хичээл баталгаажна

Таны үлдэгдэл төлвөл зохих мөнгөн дүнгээс их буюу тэнцүү тохиолдолд уг товч гарч ирнэ

Үлдэгдэл болон төлбөрийн мэдээлэл

Сонгосон хичээл ба хичээлд харгалзах төлбөр

PayBill үйлчилгээгээр төлбөр төлөх: Та PayBill үйлчилгээгээр төлбөрөө төлөхийн тулд ердөө салбар сургуулийнхаа харилцах дансны дугаар, SISI системд нэвтрэх хэрэглэгчийн нэрээ мэддэг байхад хангалттай.

Энэ үйлчилгээний давуу тал нь:

- Оюутан заавал карт ашиглах шаардлагагүй
- Оюутан аль ч банкаар үйлчлүүлэн төлбөрөө төлж болно
- Оюутан банк хоорондын гүйлгээ хийх боломжтой
- Оюутан өөрийн биеэр банкны теллерээр үйлчлүүлэхээс гадна төлбөр төлөх бусад хэлбэрүүдийг ашиглаж болно. Үүнд: интернет банк, смарт банк, mobile банк гэх

мэт

- Оюутны төлсөн төлбөр SISI дэх дансны үлдэгдэлд нэмэгдэн орно
- Төлбөр төлсний дараа оюутан SISI системд нэвтрэн орж, SISI дэх дансны үлдэгдлээр хичээлээ баталгаажуулна

Үйлчилгээнд тавигдах шаардлага:

- Оюутан салбар сургуулийнхаа Хаан болон Голомт банкин дахь харилцах дансны дугаарыг мэддэг байх
- Оюутан SISI системд нэвтрэх хэрэглэгчийн нэр буюу SISI ID-гаа мэддэг байх
- SISI ID-г зөвхөн латин үсгээр бичнэ.
- Аль ч төрлийн гүйлгээ хийхэд гүйлгээний утга хэсэгт SISI ID-г хамгийн эхэнд бичнэ

Жишээ нь:

Гүйлгээний утга: 20B1NUM1234

Гүйлгээний утга: 20B1NUM1234 Овог Нэр/SISI ID-ний араас зай аваад дурын текст бичиж болно/

Анхааруулга:


- Уг үйлчилгээг сонгон төлбөрөө төлсний дараа SISI системд нэвтрэн орж SISI дэх дансны үлдэгдлээр хичээлээ баталгаажуулах шаардлагатай.
- Нэг сая төгрөг доторх Голомт банкны дансанд хийсэн банк хоорондын гүйлгээ манай системд шууд (real time) бүртгэгдэх бол Хаан банкны дансанд хийсэн банк хоорондын гүйлгээ 10 минутын дараа бүртгэгдэх болно.
- Нэг сая төгрөгөөс дээш банк хоорондын гүйлгээ ажлын өдрүүдэд 16 цагаас өмнө 15-30 минутын хугацаанд шилждэг бол, 16 цагаас хойшхи гүйлгээ дараагийн ажлын өдрийн 10 цагт багтан шилжин орно

МУИС-ийн Хаан болон Голомт банктai харилцах данс:

№	Сургуулийн нэр	Дансны дугаар	Банкны нэр
1	ХШУИС	5041339528	Хаан банк
2	ШУС-БУС	5041123767	Хаан банк
3	ШУС-НУС	5041123790	Хаан банк
4	ШУС-ХУС	5041123789	Хаан банк
5	ОУХНУС	5041339517	Хаан банк
6	Хуулийн сургууль	5041339506	Хаан банк
7	Бизнесийн сургууль	5041123756	Хаан банк
8	Орхон сургууль	5093076065	Хаан банк
9	Завхан сургууль	5495409830	Хаан банк

№	Сургуулийн нэр	Дансны дугаар	Банкны нэр
1	ХШУИС	8115006179	Голомт банк
2	ШУС-БУС	8115006325	Голомт банк
3	ШУС-НУС	8115006329	Голомт банк
4	ШУС-ХУС	8115006331	Голомт банк
5	ОУХНУС	8115006181	Голомт банк
6	Хуулийн сургууль	8115006180	Голомт банк
7	Бизнесийн сургууль	8115006330	Голомт банк

Хичээл амжилттай баталгаажсан эсэхийг шалгах: Хичээл баталгаажуулалт амжилттай болсон тохиолдолд баталгаажсан хичээл дараах байдлаар харагдана. Мөн дүнгийн мэдээлэл хэсэгт хичээлийн нэр орсон байх болно.

 ENGL100 1 бц	Ерөнхий англи хэл: Унших дадал	Унших Энхбат.Д (Даваа 12:20-13:50) Баталгаажуулснаа цуцлах
--	--------------------------------	--

Баталгаажсан хичээл

Баталгаажсан хичээлийг оюутан өөрөө цуцлах

Мөн оюутны эрхийн нүүр хэсэгт баталгаажсан хичээлийн мэдээлэл харагдах болно.

Судалж буй хичээлүүд
PHYS201 - Атом, цөмийн физик (4 кр)
ELEC203 - Дизайны үндэс (2 кр)
CULT100 - Соёл судлалын үндэс (2 кр)
PROG201 - Объект хандлагат програмчлал (3 кр)
ELEC102 - Компьютер дээрх электрон симуляци (2 кр)
PENG220 - Мэргэжлийн англи хэл II (Физик-Дунд) (2 кр)

Баталгаажсан хичээлүүд

Санамж:

- Төлбөрийг бэлнээр төлсөн тохиолдолд нябо төлбөрийг заавал оюутан таны үлдэгдэлд шивж өгөх ёстой.
- Төлбөрийг онлайнар төлөх бол заавал онлайн гүйлгээ хийх эрхтэй картаар хийнэ.
- Банкны карт нь заавал таны карт байх албагүй.
- Төлбөр төлөх банк нь салбар сургууль тус бүрт харилцан адилгүй бөгөөд тухайн сургуульд гэрээтэй банкаар л оюутан та төлбөрөө төлөх боломжтой.
- Баталгаажуулалтыг **Хичээлд бүртгүүлэлт (баталгаажуулалт)**-ийн хугацаанд хэдэн ч удаа хийж болох бөгөөд эхний баталгаажуулалтаар суурь хураамжийг авна. Дараа дараагийн баталгаажуулалтын үеэр суурь хураамж авахгүй болно.
- Банкны системээс SISi системд амжилттай хариу илгээгээгүйн улмаас таны төлбөр төлсөн картнаас мөнгө нь хасагдсан боловч хичээл баталгаажуулаагүй тохиолдолд сонгосон хуваарьтаа өөрчлөлт оруулахгүйгээр МТА-д хандана уу.
- Баталгаажуулсан хичээлээ оюутан та баталгаажуулалтын хугацаанд өөрөө цуцлах боломжтой бөгөөд цуцалсан хичээлийн кредитийн төлбөр таны SISi үлдэгдэлд орох болно. Тухайн хичээлийг хэзээ цуцлахаас хамааран таньд буцаан олгох кредитийн төлбөр өөр өөр тул сургалтын журамтай сайтар уншиж танилцана уу.


Төлбөртэй холбоотой бусад асуудлыг сургалтын журмаас харна уу. **Журам** <http://www.num.edu.mn/contentpage.htm?mtype=0&mid=4>

5. ДҮН

Та энэ хэсгээс өөрийн нийт суралцсан хугацааны дүнгийн мэдээлэл, задаргаа болон дүнгийн үзүүлэлтийг харах боломжтой.

А. Мэдээлэл

Дүнгийн мэдээлэл нь оюутны сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнгээр тодорхойлсон баримт байна. Оюутан та үндсэн цэсний **Дүн** -> **Мэдээлэл** хэсгээс нийт болон тодорхой улирал хооронд суралцсан хугацааны дүнгийн мэдээллийг харах болон хэвлэх боломжтой. Тодорхой улирал хоорондох дүнгийн мэдээллээ харах болон хэвлэхдээ хичээлийн жил болон улирлаа оруулан харгалзах товчин дээр дарснаар дүнгийн мэдээлэл гарч ирэх болно.



Хичээлийн жил | Намрын улирал | Намрын улирал | >> | Дарах

Хэвлэх

Монгол Улсын Их Сургууль
Шинжлэх ухааны сургууль

2013 оны 9 сарын 2-ны өдрийн 530 тоот тушаалаар "Физик" (Бакалавр, Өдрийн сургалт) хөтөлбөрт элсэн орсон
Овог овогтой Нэр -ын дүнгийн мэдээлэл

ИНДЕКС	ХИЧЭЭЛ	БЦ	ОНОО	ДҮН	ИНДЕКС	ХИЧЭЭЛ	БЦ	ОНОО	ДҮН		
2013 Намар	ENGL101	Англи хэл (Анхан дүнд)	3	0	NR	2014 Хавар	ENGL101	Англи хэл (Анхан дүнд)	3	0	W
	SPRT100	Биеийн тамир I	1.5	100	A		SPRT100	Биеийн тамир II	1.5	100	A
	MATH100	Математик I	4	20	F		MATH102	Математик II	4	0	F
	COMP100	Мэдээллийн технологи, мэдээллийн систем	3	61	D-		PHYS105	Молекул физик ба термодинамик	5	0	NA
							HIST100	Монголын түүх	3	0	NA
Улирлын голч дүн					11.5	Улирлын голч дүн					16.5
Улирлын голч оноо					1.1	Улирлын голч оноо					1.1

Сургалтын алба

2013-2014 намар судалсан хичээлүүд

2013-2014 хавар судалсан хичээлүүд

Тухайн улиралд судалсан хичээлийн багц цаг

Улирлын голч дүн

Улирлын голч оноо

Судалсан багц : 14.0 | Цуглуулсан багц цаг : 6.0 | Голч оноо : 40.2 | Голч дүн : 1.1

Нийт судалсан багц цаг

Нийт судалсан багц цагаас цуглуулсан багц цаг

Нийт голч оноо

Нийт голч дүн

Тайлбар:

- Оюутны сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнгээр тодорхойлно.
- Голч оноо - Багц цаг бүхий хичээл бүрээр оюутны авсан оноог багц цагаар нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг багц цагийн нийлбэрт хувааж (арифметикийн жигнэсэн дундаж), таслалаас хойш нэг орны нарийвчлалтай бодож гаргана.
- Голч дүн - Оюутны эзэмшсэн мэдлэг, чадварын тоон болон чанарын үнэлгээний нэгдэл бөгөөд голч онооны адил аргачлалаар бодно.
- Хувьчилсан оноо, үсгээр илтгэсэн дүн ба тоогоор илтгэсэн дүнгийн хоорондын холбоо дараах хэлбэртэй байна / 9 баллаар /.

У БҮЛЭГ. СУРАЛЦАГЧИЙГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ

МУИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, “Сургах ба сурах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэх” стратегийн чиглэлийг хэрэгжүүлэхэд, оюутан чанартай боловсрол эзэмшин хөгжих таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь бидний зорилго юм.

Суралцагчдад үзүүлэх дараах нийгмийн үйлчилгээг “Оюутан, төгсөгчийн хэлтэс” хариуцан хэрэгжүүлж байна.

Үйл ажиллагааны чиглэлүүд

- Академик үйлчилгээ
- Оюутны тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг үйлчилгээ
- Боловсролын зээлийн үйлчилгээ
- Оюутан солилцоо хөтөлбөрийг дэмжих үйлчилгээ
- Гадаад оюутныг дэмжих үйлчилгээ
- Оюутны дотуур байрны үйлчилгээ
- Хөдөлмөр эрхлэлт, төгсөгчдийг дэмжих үйлчилгээ
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үзүүлэх үйлчилгээ
- Хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээ
- Эрүүл мэндийн зөвлөх үйлчилгээ
- Нийгмийн үйлчилгээ, оюутны байгууллагад үзүүлэх үйлчилгээ
- Цахим үйлчилгээ

АКАДЕМИК ҮЙЛЧИЛГЭЭ

МУИС - судалгааны их сургууль болох стратегийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд оюутны сурлагын байдал, академик хөтөлбөрийн хэрэгжилт болон оюутанд зориулсан ном, мэдээллийн үйлчилгээ, оюутны сурах хэрэгцээнд нийцсэн байдал, сургалтын орчин зэрэгт холбогдох үнэлгээ хийж, чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, суралцагчдыг эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх арга зүйд суралцахад дэмжих үйлчилгээг мэргэжлийн тэнхим, холбогдох нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлэх.

ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ, САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

Элсэгчдийг дэмжих тэтгэлэг:

1. БСШУСЯ-наас тогтоосон Олон улсын олимпиад болон улсын олимпиадад оролцож 1-ээс 3-р байрт шалгарсан элсэгчид сургалтын төлбөрийн 50-100 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно. Үүнд:
 - Олон улсын олимпиадад оролцож 1-ээс 3-р байр эзэлсэн элсэгчид 100 хувь;
 - Улсын олимпиадад оролцож 1-р байрт шалгарсан элсэгчид 100 хувь;
 - Улсын олимпиадад оролцож 2-р байрт шалгарсан элсэгчид 75 хувь;
 - Улсын олимпиадад оролцож 3-р байрт шалгарсан элсэгчид 50 хувь;
2. ЭЕШ-ын өндөр үнэлгээтэй элсэгчдэд сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно. Үүнд:
 - Суурь шалгалтад 780 буюу түүнээс дээш оноо авч Хууль зүйн сургууль,

Бизнесийн сургууль, Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуульд элссэн бол;

- Суурь шалгалтад 750 буюу түүнээс дээш оноо авч Шинжлэх ухааны сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль, Завхан сургууль, Эрдэнэт сургуульд элссэн бол;
3. МУИС-ийн Байгаль эх лицей сургуулийн төгсөгч нь суурь шалгалтад 650 болон түүнээс дээш оноо авч Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуульд элссэн бол сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно.
 4. ШУС-ийн БУС-ын багц 2 хөтөлбөр болон ХШУИС-ийн 2+2 хөтөлбөрт элссэн элсэгчийг дэмжих бодлогоор сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно. Дараагийн улирлаас сурлагын голч дүн 2.8 болон түүнээс дээш тохиолдолд сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно.
 5. ШУС-ийн БУС-ын багц 3, ХУС-ын багц 2, ЭС-ийн багц 2 дахь багш мэргэжлийн хөтөлбөрт элссэн элсэгч нь ЭЕШ-д 650-750 оноо авсан бол 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол 100 хувь сургалтын төлбөрийг төрөөс эхний улиралд чөлөөлнө. Цаашид суралцагч сурлагын голч дүн 3.0 болон түүнээс дээш оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн 100 хувь олгоно.

Элсэгчид олгох тэтгэлэг нь эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрт олгогдоно.

Амжилттай суралцагчдыг дэмжих тэтгэлэг:

Амжилттай суралцаж буй оюутнуудыг дэмжих 20 гаруй байгууллага, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлэг болон “МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг” хамаарагдах боломжтой бөгөөд жил бүр 400 гаруй оюутанд тэтгэлэг олгогддог.

ШУС-ийн БУС-ын багц 2 хөтөлбөр болон ХШУИС-ийн 2+2 хөтөлбөрт элссэн элсэгчийг дэмжих бодлогоор сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно. Дараагийн улирлаас сурлагын голч дүн 2.8 болон түүнээс дээш тохиолдолд сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно.

ШУС-ийн БУС-ын багц 3, ХУС-ын багц 2, ЭС-ийн багц 2 дахь багш мэргэжлийн хөтөлбөрт элссэн элсэгч нь ЭЕШ-д 650-750 оноо авсан бол 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол 100 хувь сургалтын төлбөрийг төрөөс эхний улиралд чөлөөлнө. Цаашид суралцагч сурлагын голч дүн 3.0 болон түүнээс дээш оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн 100 хувь олгоно.

- МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг
- Гадаад, дотоодын хувь хүн, байгууллага, сангийн нэрэмжит тэтгэлэг
- Оюутан солилцооны тэтгэлэгт хөтөлбөрүүд



ГАДААД, ДОТООДЫН ХУВЬ ХҮН САНГИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ

№	Тэтгэлэг	Зарлагдах хугацаа	Тэтгэлгийн нөхцөл	Тавигдах шаардлага	Тэтгэлгийн хэмжээ
1	“МОНГОЛ СУДЛАЛЫГ ДЭМЖИХ Ц.ДАМДИНСҮРЭН, Ш.ЛУВСАНВАНДАН, Б.РЕНЧИН НАРЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ”	3-р сард	Монгол судлалын чиглэлээр ажилладаг гадаадын залуу судлаачдыг ахисан түвшний сургалтад хамруулж, мэргэшихэд нь дэмжлэг үзүүлэх	Монгол судлалын чиглэлээр докторантурт суралцаж байгаа болон докторын дараах судалгааны ажил хийх сонирхолтой 40 хүртэлх насны судлаач байх	Боловсролын зэргээс хамааруулж сар бүр 700.000 төгрөг
2	“ЯПОНЫ МИЦУБИШИ UFJ САНГИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ”	9-р сард	Сурлага, нийгмийн идэвх, оролцоо сайтай бакалаврын түвшний суралцагч	Улирал бүр 12-оос доошгүй багц цагийн хичээлийг сонгон амжилттай судалж, суралцах чадвар, идэвх санаачлага илтгэн харуулсан, санхүүгийн дэмжлэг шаардлагатай 2,3,4 дүгээр түвшний бакалаврын хөтөлбөрийн суралцагч байх, А групп ХШУИС, ШУС-БУС-ийн суралцагч 3.0 болон түүнээс дээш, В групп ОУХНУС, ХЗС, ШУС-НУС, ШУС-ХУС-ийн суралцагч 3.2 буюу түүнээс дээш байна	300-500 ам доллартой тэнцэх хэмжээний монгол төгрөг
3	“ЯПОН УЛСЫН МИЦУБИШИ КОРПОРАЦИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ”	10-р сард	Сурлага, нийгмийн идэвх, оролцоо сайтай бакалавр, магистр, докторын суралцагч	А. Бакалаврын түвшний суралцагч: Улирал бүр 12-оос доошгүй багц цагийн хичээл судалсан, голч дүн / GPA/ нь 3.0 буюу түүнээс дээш, Эрдэм шинжилгээний хурал, нийгмийн ажил, спорт, урлаг соёлын арга хэмжээнд идэвхтэй оролцдог бол давуу тал болно Б. Магистр, докторын түвшний суралцагч: МУИС болон бусад их дээд сургуулиуд, ШУ-ны академийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг хөндлөнгийн үнэлгээ бүхий сэтгүүлүүдэд судалгааны өгүүлэл хэвлүүлсэн, ЭШ-ний хуралд илтгэл тавьсан байх Хөтөлбөрт заасан багц цагийг 50 хувь болон түүнээс дээш судалсан, сурлагын голч оноо 3,5 буюу түүнээс дээш байх ОУ-ын хөндлөнгийн үнэлгээ бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн, илтгэл тавьсан болон судалгааны чиглэлээр гарын авлага, сурах бичиг бичиж хэрэглээнд оруулсан байх	1.000.000 төгрөг
